



ШИНЭ ТОЛЬ

**“КОВИД 19: ЭДИЙН ЗАСАГ БА АРДЧИЛЛЫН СОРИЛТУУД БОДЛОГЫН
ЗӨВЛӨМЖ СУДАЛГАА**

Тусгай дугаар №82



УЛААНБААТАР ХОТ
2021 он



ШИНЭ ТОЛЬ №82 СЭТГҮҮЛИЙГ
ХБНГУ-ын Конрад Аденауерын Сангийн Ивээн тэтгэлгээр хэвлүүлэв

Ерөнхий Редактор: Базарваанийн АРИУНБАЯР

Редакцын зохицуулагч Сэлэнгийн ЦЭНГЭЛ

Редакц: Др. Гунгаагийн БАЗАРВААНЬ

Др. Самбуугийн БАЗАРПҮРЭВ

Дашдондогийн ОЮУНЧИМЭГ

ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛСЭН
УЛС ТӨР БОЛОВСРОЛЫН АКАДЕМИ

Сөүлийн гудамж, Браухаус-22
Улаанбаатар хот - 210628
Утас: +976 (11) 319135, 319336
Факс: 00976 - 11/319137
Веб: <http://www.academy.edu.mn/>
Е-Шуудан info@academy.edu.mn

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм уншигч, Конрад Аденауерын сан болон Улс Төрийн Боловсролын Академийн анд нөхөд та бүхний амар амгаланг айлтгая.

Анх 1993 онд Конрад Аденауерын Сангийн улс төрийн боловсрол түгээх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан тус академи ердөө нэг жилийн дараа бие даасан, хараат бус байгууллага болон хөгжсөн цагаас эхлэн мэдээлэлд түшиглэсэн иргэний нийгмийг цогцлоох нийтлэг ашиг сонирхол дээр тулгуурлан бид хамтын ажиллагаагаа тогтоосон байдаг. Ингэснээр өнөөдрийг хүртэлх 28 жилийн түүхтэй бидний хамтын ажиллагаа нягт явж ирсэн байна.

Энэ жилийн тухайд дэлхийн нийтийг цочроогоод буй цар тахлыг онцлон авч, “ШИНЭ ТОЛЬ” сэтгүүлийн 81 дэх дугаар олон улсын харилцаа, КОВИД-19-ийн үе дэх Монголын болоод бусад улс орнуудын сонгуулийн туршлага зэрэг сэдвийн хүрээнд хэвлэгдэн гарч байсан. Тэгвэл Монгол Улсын хувьд бодлогын олон шийдвэр гарч буй энэ цаг дор бид хамтран сэтгүүлийн дахин нэг тусгай 82 дахь дугаарыг “Цар тахал ба Ардчилал, эдийн засаг” сэдвийн хүрээнд бодлогын зөвлөмж хэлбэрээр уншигч таны гарт эрхлэн гаргахыг хичээлээ.

МОНГОЛ ДАХЬ КОНРАД АДЕНАУЕРЫН САН

СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ

ИОХАНН ФУРМАНН

ӨМНӨХ ҮГ



Улс Төрийн Боловсролын Академи “ШИНЭ ТОЛЬ” эрдэм шинжилгээний сэтгүүлийг анх эрхлэн гаргаснаас хойш өдгөө 28 дахь жилдээ цуврал 82 дах тусгай дугаараа уншигч таны гарт хүргэж байгаадаа баяртай байна.

1993 оноос эхлэлтэй ардчилал, хүний эрх, эрх чөлөө, иргэний нийгэм, улс төрийн боловсролын төлөөх бидний үйл ажиллагаатай хамтдаа хүчин зүтгэж ирсэн ХБНГУ-ын Конрад Аденауерын Сангийн нөр их хөдөлмөр өнгөрсөн хугацаанд чамлахааргүй их үр өгөөжийг Монголын нийгэм, соёлын салбарт өгсөн гэдэгт итгэлтэй байна.

КОВИД-19 гэх цар тахал дэлхийд тархаснаас хойш өдгөө 1 жилийн хугацааг өнгөрүүлсэн байгаа нь улс орнуудын гадаад, дотоод бодлогод ихээхэн өөрчлөлт авч иржээ. Монгол Улсын ирээдүйтэй шууд холбогдох бодлогын шийдвэрүүд ар араасаа цувран гарч буй энэ үед ХБНГУ-ын Конрад Аденауэрын сан болон Монголын ууган ардчиллын төлөөх иргэний нийгмийн төлөөлөл болсон Улс Төрийн Боловсролын Академи нар хамтран бодлогын зөвлөмж судалгааг гүйцэтгэж хувь нэмрээ оруулахыг зорилоо.

“КОВИД-19 ба Ардчилал, эдийн засгийн сорилтууд” бодлогын зөвлөмж дэлхийн улс орнуудын цар тахлын үеийн тойм, улс төр ба ардчилал, эдийн засгийн харьцуулсан шинжилгээ гэх гурван голлох салбарын судалгаанаас бүрдлээ.

Уг бодлогын зөвлөмж шийдвэр гаргачдад төдийгүй уншигч таны эрдмийн ажилд дэм оруулж чадна гэдэгт итгэлтэй байна.

Нийт уншигч та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН АКАДЕМИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. АРИУНБАЯР

АГУУЛГА

УЛС ТӨР, АРДЧИЛАЛ

- Д. Бумдарь
 - Б. Хишигням
 - Д. Бадамдаш
- КОВИД 19-С ҮҮДЭЛТЭЙ АРДЧИЛАЛД ҮҮССЭН СОРИЛТ, БОЛОМЖ

ЭДИЙН ЗАСАГ

- Б. Эрдэнэбат
 - Б. Соелмаа
- КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭДИЙН ЗАСАГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ,
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛУУД

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЦАР ТАХЛЫН ТОЙМ


- Р. Нямдаваа
 - Хавсралтын оронд
- ЗАРИМ УЛС ОРНЫ КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭ, ТУРШЛАГА СУРГАМЖ, ЗӨВЛӨМЖ



“КОВИД 19-С ҮҮДЭЛТЭЙ АРДЧИЛАЛД ҮҮССЭН СОРИЛТ, БОЛОМЖ”

Зохиогчид:

- Д. Бумдарь PhD
- Б. Бадамдаш PhD
- Д. Хишигням PhD



Зургын тайлбар: Платоны Академи “өнөө цагт”

Судалгааны үндэслэл

Дэлхийн дахинд шинэ төрлийн халдварт вирус дэлгэрсэнтэй холбоотойгоор ДЭМБ цар тахал хэмээн зарлаж улс орнууд өөрсдийн эрсдэлийн менежментийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4-т заасныг үндэслэн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр УОК-ын даргын тушаал-аар “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 11.2, 11.3.3-т заасныг үндэслэн “өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжин ажилласан болно.

Манай улсын хувьд дотоод халдвар 11 сарын 11-нд зарлагдан 12-ны өдрөөс УОК-ын саналын дагуу Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн болно.

Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой нийгмийн дунд эргэлзээ, үл итгэх байдал хүчтэй илэрч байна. Учир нь гаргасан шийдвэр болгон нь өдөр бүр өөрчлөгдөх, баттай эх сурвалжийн мэдээлэл хоорондоо зөрөх зэрэг тодорхойгүй гайхсан байдалтай эхний долоо хоног өнгөрсөн болно. Энэхүү байдалтай зэрэгцэн аж ахуй нэгж, иргэдийн эдийн засгийн байдал, өдөр тутмын үйл ажиллагаанд зохицуулалт хийх, авах арга хэмжээ мөн тодорхой бус байсан нь нийгмийг ихэд бухимдуулсан.

Товчхондоо дүгнэж үзэхэд өндөржүүлсэн бэлэн байдлын үе буюу 10 сарын турш УОК-ын хийсэн үйл ажиллагааны үр дүн гарсангүй хэмээн хэлж болох юм. Иймээс төрийн засаглалын чадамжид эргэлзэх нийгмийн уур амьсгал бүрэлдсэн байна хэмээн үзэн нөлөөлсөн хүчин зүйлсийн судалгаа хийж зөвлөмж гаргахыг зорьж байна.

Судалгааны гол зорилгын хүрээнд дараах асуудлыг судлан гаргах зорилт тавьж байна.

- Улс төрийн эрсдэлийн менежментийн тогтолцоо манайд байгаа эсэх (Political crisis management system)
- Хөл хорионоос үүдэлтэй засаглалд үзүүлсэн сайн нөлөө (Популист улс төрчдийг ялгах боломж, Ардчилсан засаглал нь аливаа шийдвэр, мэдээллийг залруулах тал дээр илүү хурдтай байж чадах эсэх)
- Хөл хорио, засгийн газрын шийдвэрүүд, хэрэгжилт, түүнээс үүдэлтэй нийгэм-сэтгэл зүйн зарим онцлогийг илрүүлэх (Нийгэм-сэтгэлзүй (Psycho-social) нь нийгмийн хүчин зүйлс болон хувь хүний хандлага, бодол санаа, зан үйлийн харилцан хамаарлыг хэлдэг)

Нэгдүгээр хэсэг: Ковид-19 Улс төрийн эрсдэлийн менежментийн тогтолцоо

Улс төрийн эрсдэлийн менежмент (*political crisis management*) гэдэг энэхүү нэр томъёо нь орчин үеийн эрсдэлийн менежментэд засаглалын онцлог, хэв маягыг илэрхийлэхэд хэрэглэгддэг. Тодруулбал нийгэм бүхэлдээ эх баригчдаас эрсдэлийн нөлөө хамгийн бага байхыг шаарддаг бол сөрөг хүчин хэвлэл мэдээллийн сувгийг ашиглан бодлогын шүүмжийг хүчтэй өрнүүлэх ба үүнээс хэрхэн сэргийлж байгааг улс төрийн эрсдэлийн менежмент гэж ойлгож болно. Ийм хоёр туйлын нөхцөлд бодлого тодорхойлогч хамгийн боломжит хувилбарыг сонгох байдлыг улс төрийн эрсдэлийн менежмент сайн эсвэл засаглал сайн байна гэж үзэж болох юм.

Аливаа эрсдэл нь дараах үндсэн гурван шинжийг агуулсан байдаг гэж үздэг уламжлалт хандлага байна.

- Эрсдэл, хямрал нь урьдчилсан таамаглах аргагүй
- Гаргасан шийдвэрүүд нөхцөл байдалд тохирохгүй байх, үр дүнд хүрэхгүй байх
- Аливаа шийдвэрүүдийг түргэн шуурхай гаргах, яаралтай өөрчлөх гэсэн шинжүүдтэй.

Тиймээс эрсдэлийн менежмент нь аюулыг урьдчилан тооцоолж, шинжлэх ухааны үндэслэлтэй өөрийн нөөц боломж, чадавхад таарсан хувилбаруудыг бодлогын төвшинд боловсруулсан байхыг хэлж байгаа юм.

Шийдвэр гаргагчид эрсдэлийн менежмент хийхдээ дараах зүйлсийг зайлшгүй анхаарах ёстой. Үүнд:

- Мэдрэмжтэй байх (*Sense making*)
- Шийдвэр оновчтой гаргах, гаргасан шийдвэр нь үр дүнтэй байх ёстой (*Decision making and coordinating implementation*)
- Бодож тунгаах, судлах (*Meaning making*)
- Тооцоололтой, дуусгаж сурах (*Accounting and ending*)
- Амжилт, алдаанаас суралцах (*Learning*)


Дээрх байдлыг шийдвэр гаргалтын үе шатан шингээж өгөхгүй бол тухайн шийдвэр ямар нэгэн үр дүнгүй болж дуусах юм. Монгол улс цар тахалтай холбоотой шийдвэр гаргалт, үр дүнгийн талаар нийгэм таатай бус байгаа нь улс төрийн эрсдэлийн менежмент сул байна гэж дүгнэх боломжтой.

Монгол улсын цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өнөөдрийн байдлаар дараах үе шаттай хувааж үзэх боломжтой. Үүнд:

- Эхэн үеийн бодлого (цар тахлаас сэргийлэх, гаднаас зөөгдөж анхны халдвар илэрсэн)
- Цар тахал ба Сонгуулийн үеийн бодлого
- Ковидыг дотооддоо алдсан үеийн бодлого


Мөн манай улсад онцгой байдлын үед шийдвэр гарах, чиглэл өгөх удирдлагын тогтолцооны бүтэц хэрэгжих үе шатыг дараах схемүүдээр үзүүлье.

Схем.1. Онцгой байдлын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт



Эх сурвалж: Судлаач өөрөө бэлтгэв.

Схем.2. Монгол Улсын онц байдлын үед шийдвэр хэрэгжих үе шат түүний бүрэн зураглал



Эх сурвалж: Судлаач өөрөө бэлтгэв.

Манай улсад аюулгүй байдал, нийгмийг хамарсан аливаа гамшгийн үед ҮАБЗ-өөс Улсын Онцгой комисс, УИХ-аас Засгийн газар төлөөлөн хэрэгжүүлэх чиг дараалалтай байдаг. Онцгой байдлын ерөнхий комиссыг удирдан зохион байгуулах үүргийг Засгийн газарт бүрэн хариуцуулсан байдаг болохыг харж болж байна. Энэ чиг үүргийн дарааллаар бол манай улс бусад улс орнуудтай ижил гүйцэтгэх засаглалаас шийдвэр гаргалтыг хэрэгжүүлдэг байдал нь ижил байна.

Тэхээр цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дээрх схемийн дагуу харвал Засгийн газраас гарсан шийдвэр нь хамгийн эцсийн шийдвэр байдаг болохыг харах боломжтой байна. Нөгөө талаас эрх баригч намын засаглалын чадамж, улс төрийн эрсдэлийн менежмент байгаа эсэхийг харах боломжтой гэсэн үг юм.

Дараагийн хэсэгт Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын шийдвэрүүдийг авч үзье.

Эхэн үеийн бодлого (цар тахлаас сэргийлэх, гаднаас зөөгдөж анхны халдвар илэрсэн)

ДЭМБ-аас нэгдүгээр сарын 3-ны өдөр БНХАУ-д анх коронавирусын сэжигтэй тохиолдол бүртгэгдлээ гэж зарласны дараа Эрүүл мэндийн яамнаас арга хэмжээ авч эхэлсэн бөгөөд 2019 оны 12 сараас эхлэн томуу, томуу төст өвчний идэвхжил ихэсдэг Монгол улсын хувьд анхаарч үзэх шаардлагатай болсон. Монгол Улсад шинэ төрлийн вирусийн халдвар дамжин орж ирэх эрсдэлийн зэргийн үнэлгээг гаргахад дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн орны тоонд орсон. Тиймээс Монгол Улс онц байдал зарлахгүй гэж 01-р сарын 21-ны өдөр мэдэгдсэн байдаг.

Эрүүл Мэндийн Яамнаас ДЭМБ-аас зургаан чиглэлээр түр зөвлөмж гаргасны дагуу Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий Газар, хил орчмын Орон Нутгийн Засаг Дарга нар зэрэг холбогдох бүх байгууллагад анхааруулга, сэрэмжлүүлгийг албан бичгээр хүргүүлж, ялангуяа хилээр орж ирж буй хүмүүсийн өвчтэй эсэхийг хэрхэн хянах вэ гэдэг зааварчилга өгч эхэлсэн.

Мөн нийт иргэдэд гаднын улс орнуудад зорчихгүй байх, коронавирус амьсгалын замаар халдаж байгаа учраас амны хаалт хэрэглэх, гараа савандаж угаах, гар ариутгагч хэрэглэх, амьтны маханд хүрэхгүй байх, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг сайтар боловсруулж хэрэглэх шаардлагатай бөгөөд хэрэв ханиаж, халуурч, амьсгалахад хүнд болох гурван төрлийн шинж тэмдэг илэрч байвал эрүүл мэндийн байгууллагад хандах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өгч байсан.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас шат шатны байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллаж байсан.

Эхэн үеийн бодлого нь урьдчилан таамаглах боломжгүй эрсдэлд бэлэн байгааг илтгэсэн шийдвэрүүдийг авч хэрэгжүүлсэн байдаг.

Тухайлбал:

2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар

- Шинэ коронавирусын голомт болох Ухань хотод хөл хорионд орсон 32 монгол оюутныг эх оронд нь шилжүүлэн авах тухай албан ёсны хүсэлтийг Гадаад харилцааны яам Бээжин дэх Элчин сайдын яамаараа дамжуулан Хятадын Гадаад хэргийн яаманд ноот бичгээр хүргүүлэв (энэ үед Ухань хотоос иргэдээ шилжүүлэн авах хүсэлтээ Америк, Франц, Япон, Өмнөд Солонгос зэрэг 10 гаруй улс Хятадын Засгийн газарт мөн хүргүүлээд байв)

2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар

- Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн хичээлийг 2020.02.03-ны өдрөөс өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр хичээл зааж эхлэх. Теле хичээлийг нийгмийн сүлжээгээр хяналтгүй цацах, бага ангийн хүүхдүүдэд сошиал хаяг нээх зэргийг хориглож, цахим орчны халдлагаас хүүхдүүдээ хамгаалах бодлого барьж байна.

2020 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар

- Хилийн боомтод хязгаарлалт хийх талаар хэлэлцэн шийдвэр гаргасан

2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 02 дугаар сарын 13-наас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /хэсэгчлэн/ шилжүүлсэн

2020 оны 02 дүгээр сарын 19-ны өдрийн ээлжит хуралдаанаар

- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 03 дугаар сарын 30 хүртэл сунгасан

2020 оны 02 дүгээр сарын 26-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар

- Коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээнд зориулж Засгийн газрын нөөц сангаас 6,5 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт хийхээр шийдвэрлэлээ (Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын эрсдэлийн үнэлгээгээр манай улсад коронавируст халдвар зөөрлөгдөн орж ирэх эрсдэл МАШ ӨНДӨР, тархах эрсдэл ӨНДӨР гэж үнэлэгдээд байна. Иймд урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, санхүүжилтийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзжээ)

2020 оны 02 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хуралдаанаар

- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэл, татвараа тайлагнасан боловч хугацаандаа төлөөгүй тохиолдолд алданги, торгуулийг нэг удаа чөлөөлөх хуулийн төсөл боловсруулж хэлэлцэхээр болсон зэрэг засаглалын хувьд шийдмэг үр дүнтэй бодлогыг хэрэгжүүлж байна гэсэн үнэлэмжийг нийгэм өгч байсан.

2020 оны 03 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хуралдаанаар (зөвөөрлөгдөж ирсэн үе)

- Зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацаагаар өөрчлөлт оруулсан. Монгол Улсын Ерөнхий сайд өндөржүүлсэн бэлэн байдлын үед иргэд, аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдэд зориулж зээлийн эргэн төлөлтийн уян хатан бодлого хэрэгжүүлэхийг хүссэний дагуу Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хамтран зээлийн ангилал, эргэн төлөлтийн хугацаанд 90-120 хүртэл хоногийн өөрчлөлт оруулсан байна. Зохицуулалтын хугацаа дуусах үед ердийн зохицуулалтын дагуу мөрдөхөөр шийдвэрлэлээ (Улсын хэмжээнд 419.000 зээлдэгч 18 их наяд төгрөгийн зээлтэйгээс 70-аас дээш хувийг хэрэглээний зээл эзэлж байгаа аж).

2020 оны 03 дүгээр сарын 19-ны өдрийн ээлжит бус хуралдаан:

Шинэ вируст халдварын уршгаар Монгол улс ноолуураа БНХАУ болон бусад орнууд руу экспортлох боломжгүй болсон тул дотооддоо ноолуур бэлтгэлийн ажлыг зохион байгуулахаар болсон.

- Ноолуур бэлтгэлд 300 тэрбум төгрөгийн эх үүсвэр гаргана (Ноолуурын салбарынхан 2020 онд нэг килограмм ноолуурыг 100.000 төгрөгөөр тооцож, нийт 5.000 тн ноолуур худалдан авахаар төлөвлөж ноолуур бэлтгэлд ойролцоогоор 456.1 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө шаардлагатай гэж үзжээ)

Ийнхүү Засгийн газраас ноолууртай холбоотой тогтоол гарсан үеэс эхлэн цар тахлын эсрэг арга хэмжээ нь улс төрийн зорилго бүхий шийдвэрүүд болж харагдаж эхэлсэн. Учир нь парламентын ээлжит сонгууль зургаан сард зохион байгуулагдахаар хүлээгдэж байсан тул сонгогчдод зориулсан эдийн засгийн дэмжлэг гэсэн хардлагыг нийгэмд төрүүлсэн юм.


Цар тахлын эхэн үеийн шийдвэр гаргалтын гол цөм нь 1дүгээр сарын 26-нд Гамшигаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт улс даяар шилжсэн. Коронавируст халдвар /Ковид -19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг УИХ дөрөвдүгээр сард баталсан. Энэ нь 2020 оны цар тахалтай холбоотой бүх шийдвэр энэхүү хуулийн хүрээнд хэрэгжих эрх зүйн нөхцөл бүрдсэн гэсэн үг юм.

Цар тахал ба Сонгуулийн үеийн бодлого

Монгол улсын Засгийн газраас баримталсан бодлого, шийдвэрийн хүрээнд дотооддоо нэг ч халдвар тархаагүй байсан. Харин гадаадаас иргэдээ авчрах үе шаттайгаар авчрах үед нийт 287 халдвар илэрсэн ч гадагш алдахгүй, нас баралтгүй эмчилж эдгээж байлаа. Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолын 4-т заасныг үндэслэн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр УОК-ын даргын тушаал -аар “Гамшигаас хамгаалах тухай хууль” -ийн 11.2, 11.3.3-т заасныг үндэслэн “өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т хэсэгчлэн шилжсэн цагаас хойш хагас жилийн хугацаанд Монгол улсын Засгийн газраас гэхэд нийтдээ 23 тогтоол, журам батлагдан гарчээ. Мөн цар тахалтай тэмцэхэд зориулагдсан хандив 7 сарын байдлаар нийтдээ 7.9 тэрбум цугларсан байсан.

Гэвч цар тахалтай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн нь нийгэмд эдийн засгийн хувьд томоохон хүндрэл авчирсан юм. Учир нь Тахал гарсны дараа бүх улсуудад нэгэн зүй тогтол ажиглагдаж байна. Энэ нь нийгэм оршин тогтнож байгаад халдварт өвчин тахал гарвал асар их үхлийг буюу эрсдэлийг дагуулдаг. Төр, Засгийн Газрууд тахлын эсрэг арга хэмжээ авч бодлого хэрэгжүүлж бууруулж чадах боловч, тахлын дараа улс орнуудын эдийн засаг үлэмж доройтдог байна. Тахлын үйл явц, үр дүнгийн зураглалыг дараах байдлаар үзүүлэв.

Схем.3. Тахлын дараах эдийн засгийн доройтол



Дээрх байдал манай улсыг тойроогүй болно. Тухайлбал 2020 оны нэгдүгээр улиралд 2019 оны мөн үеийнхтэй харьцуулахад ДНБ 10.7 хувиар, экспорт 41.5 хувиар, импорт 9.7 хувиар тус тус буурсан. Монгол улсын гадаад өрийн хэмжээ ойролцоогоор ДНБ-ийн 70 хувийг эзэлж байна. 2020 оны эдийн засгийн өсөлтийн урьдчилсан таамаглал 5.4 хувь байсанг хасах 1 хувийн өсөлттэй байх таамаглалыг Олон улсын Валютын сан илэрхийлсэн байдаг. Энэхүү байдал нь манай улсын хувьд эдийн засгийн хүнд байдлыг үүсэх нөхцөл бүрдсэн г харуулж байна.

Гэвч шийдвэр гаргагчид эдийн засаг, нийгмийн асуудал гэхээс илүүтэй сонгуулийг зохион байгуулах үйл явцад цар тахлыг ашигласан гэж хэлж болно. Олон улсад Ковид-19-ийн улмаас 2020 оны хоёрдугаар сараас арван хоёрдугаар сарын хооронд төлөвлөсөн сонгуулиудын тэн хагасыг хойшлуулжээ. Харин 2020 оны хоёрдугаар сараас аравдугаар сарын хооронд бүх шатны нийт 65 сонгууль явуулсан байна.

Нийгмийн зүгээс өндөржүүлсэн бэлэн байдлын үед гаргасан шийдвэрүүд нь ардчиллын үнэт зүйл болох амьд явах эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, улс төрийн эрх зэргүүдэд тодорхой хэмжээнд хязгаарлалт үүсгэн зөрчигдөж байна хэмээн шүүмжлэлтэй хандаж байсан.

Мөн цар тахал хэмээн зарлагдахад гадаадад түр болон урт хугацаагаар оршин суугч, оюутнууд, албаны болон аяллын шугамаар түр зорчигсад, эрүүл мэндийн шалтгаанаар зорчсон иргэдийг нутагтаа буцан ирэх эрхийг боогдуулсан талаар онцгой шүүмжлэлтэй хандаж байлаа.

Цар тахал дэлгэрсэн цагаас эхлэн Монгол улс дотооддоо алдаагүй хэдий ч хөл хорио тавьж хилээ хаах биш хэрхэн зэрэгцэн амьдрах талаар бэлтгэл хангаж чадсан эсэхэд эргэлзээ нийгэмд үүсэж Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогуудыг “Коронабизнес” бодлого хэмээн нэрийдэх болсон. Учир нь цар тахалтай тэмцэх, эрүүл мэндийн салбартаа илүү анхаарах зэрэгт олон улсын донор байгууллагаас өгсөн хандив, иргэдийн хандив, байгууллагуудын хандивын зарцуулалт ил тод байхгүй, тодорхой бус байгаа нь нийгэмд хардлага төрүүлсэн хэвээр байна.

Тодруулбал эрүүл мэндийн салбарын хувьд ДЭМБ-ийн зааварчилцааг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хөл хорио тогтоосон цагаас эхлэн өдөр бүрийн 11 цагаас Эрүүл мэндийн яамнаас тогтмол цаг үеийн шинжтэй мэдээллийг хүргэж байна.

Харин эрүүл мэндийн бодит нөхцөл байдал, хүчин чадал, бэлэн байдлын зэрэглэл зэргийг хагас жил болоход нийгэм бүхэлдээ нэгдсэн ойлголтгүй байгаа нь төрд итгэх итгэлийг бууруулах том шалтгаан болж байлаа. Улмаар цар тахал зарлагдан хөл хорио тогтоосон цагаас эхлэн ДЭМБ-ийн тооцооллын дагуу хүн амын 1 хувь халдварлана гэсэн судалгаа гарсан. Үүний дагуу эмнэлгийн бэлэн байдал, дутуу тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт төсөв хүрэхгүй учир олон улсын байгууллага, хувь иргэд, албан газраас хандив цуглаж эхэлсэн.

Хагас жилийн хугацаанд УОК-т иргэд, байгууллагын зүгээс нийт 7.1 тэрбум төгрөг хандивласан байна. Хандивын үлдэгдэл нь 7 сарын байдлаар 957 сая болсон ба хамгийн чухал хэрэгтэй уушги орлуулагч 2 ширхэг авах л шийдвэр гарсан байна. Эрүүл мэндийн яаманд 775 сая орчим мөнгөн тусламж орсон ба хэрхэн зарцуулсан талаарх тоо баримт одоо хүртэл бүрхэг байна. Мөн халдварласан иргэдийг эмчлүүлэх, яаралтай арга хэмжээ авахад зориулалтын эмнэлгийн хүчин чадал нь 250 орны багтаамжтай. Үүнээс өөр ямар нэгэн бэлтгэл хийгдсэн эсэх нь тодорхой бус байна. Энэхүү нөхцөл байдал нь 7 сард тодорхой болсон ба манай улсын халдвар авах эрсдэлийн зэрэг өндөр хэмээн гарсан болно.

Гэтэл шийдвэр гаргаж буй Засгийн газар нь 6 сард болсон УИХ-ын сонгуульд үнэмлэхүй ялалт авсан. Монгол улсын парламентын сонгууль 8 удаа зохион байгуулагдахдаа дараалан үнэмлэхүй ялалт авсан тохиолдол нь анх удаа юм. Энэ салбарын судлаачид, экспертүүд энэхүү ялалтыг дүгнэхдээ нийгмийн айдас өндөр байсан ба засаглалын тогтвортой байдлыг хүссэн нийгмийн захиалга хэмээн үзсэн. Хамгийн гол нь Ковид 19-ийг дотооддоо алдаагүй нь шууд нөлөөлсөн хэмээн дүгнэсэн байна.

Үүнд:

- Засгийн газрын нөөц сангийн 10 тэрбум төгрөгөөр шаардлагатай эм тариа, хамгаалах хэрэгсэл авсан. Үүнийгээ 38 эрүүл мэндийн байгууллагад хуваарилсан.

- Япон улсаас 1200, ОХУ-аас 200, ДЭМБ-аас 3000 оношлуур авсан.

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 572 тоног төхөөрөмж авсан.

- Дэлхийн банкны санхүүжилт 2.2 сая доллар аар эмнэлгийн тоног төхөөрөмж авсан.

- Дорноговь аймгийн хоёр суманд 100 болон 50 ортой эмнэлэг ашиглалтанд ороход бэлэн болсон.

- Анагаахын оюутнууд 1340, дадлагажигч эмч 1824, халдвартын чиглэлээр яаралтай тусламж үзүүлэх 159 эмч, 66 сувилагч нарыг тусгайлан бэлтгэсэн зэрэг эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь сайшаагдаж байсан.

Сонгуулийн дараах нийгэмд үүссэн залхалтын байдал, гадаадаас эх орондоо эргэн ирж чадахгүй байгаа иргэдийн бухимдал зэргээс харахад энэхүү сонгуулийн ялалтанд Ковид хэрхэн холбоотой байсан г эргэн харах нь зүй ёсны асуудал болж байна.

2020 оны 4 сарын 10-нд Монгол улсын Шадар сайд, УОК-ын дарга УИХ-н нэгдсэн чуулганд асуулгад орсон байдаг. Энэ талаар маш дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд хүргэсэн. 4 сарын байдлаар Засгийн газар 12, УОК 15, УИХ чуулган 1, Аюулгүй байдлын зөвлөл 5, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 1 удаа тус тус хуралдаж шийдвэр гаргасан байна. Энэ үед манай улсад зөөвөрлөгдөж ирсэн тохиолдол 16, дотооддоо халдав алдаагүй байсан. Асуулгын үеэр дараах зүйлс бэлэн байгаа талаар мэдээлэл өгсөн.

Улмаар нийгмийн хамгааллын үүднээс дараах арга хэмжээнүүдийг авсан байна.

Үүнд:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсэн
- Иргэдийн нийгмийн даатгалыг шимтгэлээс бүрэн чөлөөлсөн
- Ажлын байраа хадгалж үлдсэн аж ахуй нэгжид ажилгүйдлийн даатгалын сангаас нэг ажилчин тус бүрд сар бүр 200, 000 төгрөг олгох журам гаргасан байна.

Хамгийн гол нь эдгээр арга хэмжээнүүд бүгд 4 сараас эхэлж 10 сард дуусах зохицуулалттай байгаа юм. Энэ нь 6 сарын УИХ, 10 сарын орон нутгийн сонгуулийг угтсан ажил байсан хэмээн үзэх боломжтой юм.

Улмаар эдийн засгийн хувьд авсан арга хэмжээ нь орон нутгийн жижиг дунд аж ахуй эрхлэгчдийн сайшаалыг маш сайн авсан болно. Тухайлбал НДШ-н татварыг 26 хувиар тэглэсэн, Орлогын татварыг бүрэн чөлөөлсөн, Малчдаас ноолуур худалдан авахад зориулж 300 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг үйлдвэрлэгч нарт олгосон ба хүүгийн зөрүүг Засгийн газар даахаар зохицуулсан. Мөн бензиний литр тутмыг 300-400 төгрөгийн хямдрал үзүүлсэн зэрэг эдийн засгийн хувьд тодорхой нөлөө болохуйц арга хэмжээнүүдийг авсан байна.

Дээрх арга шийдвэрүүд, авсан арга хэмжээнүүд бүгд 4 сараас хэрэгжиж эхэлсэн ба сонгуулийн кампанит ажил 6 сарын 2-нд эхлэхэд нийгэм эхний үр шимээ хүртэж эхэлсэн болно. Тухайлбал 18 нас хүртэлх 4 хүүхэдтэй айл ковидоос өмнө сар бүр хүүхдийн мөнгө нийтдээ 80, 000 авдаг байсан.

Харин энэхүү шийдвэрийн дараа сар бүр нийтдээ 400,000 мянгыг авахаар болсон даруй 4 дахин нэмэгдсэн мөнгөн дүн юм. Мөн иргэд цалингаа анх удаа татваргүй бүтэн авсан нь жир иргэний амьдралд маш дэмтэй болсон. Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлсэн эдийн засгийн энэхүү арга хэмжээнүүд нь Political economy cycle буюу улс төрийн эдийн засгийн мөчлөг хэмээх сонгуулийн жил бүр санал өгөхөд нөлөөлдөг онолын дагуу хэрэгжиж чадсан юм. Хамгийн гол нь Ковидоос өмнө авсан судалгааны үр дүнгээр эрх баригч 76 суудлын 30-40 суудлыг авна гэсэн олон судалгааны байгууллагын үр дүнг Ковид 19-с сэргийлэх түр журам, бодлогууд эрс өөрчилсөн болно. Тиймээс үр дүн нь эрх баригчид үнэмлэхүй ялалт авсан.

Харин сонгуулийн дараа энэхүү байдалд өөрчлөлт гарсаар ирсэн. Нийгмийн зүгээс бухимдал ихсэх, шаардлага тавих нь өндөрсөж байлаа.

“Ковид-19” цар тахлын нөхцөл байдал дэлхийн олон улс оронд популист улс төрчдийг ялгаж харах боломжийг өгч байсан нь сайшаалтай байсан. Вирус тархсан энэ үед Солонгос, АНУ, Польш, Монгол гэх зэрэг олон улс оронд Ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль болж өнгөрсөн. Сонгуулиа хийсэн улс орнуудад ажиглагдсан нэг зүйл нь ковидын эхэн үед популизмаас үүдэлтэй улс төрийн ямар нэгэн үйл ажиллагаа явуулах боломжгүй болж эхэлсэн байна.

Тогтсон тодорхой систем, эрхзүй ажиллаж байж, энэ цар тахлын аливаа аюулаас улс орноо, ард иргэдээ хамгаалж сэргийлэх юм байна гэдэг ийм бодит нөхцөл үүссэн. Тийм учраас ковидын ихэнх үед, хөл хорионы үеэр сонгууль нь болсон улс орнуудад популизм ярих, дуугарч өрсөлдөх боломж байгаагүй. Улс төрч судлаачид популизм сулрах юм байна, энэ чигээрээ байвал популизм бол ард түмнийг үймүүлж байсан улс төрийн түр зуурын үзэгдэл юм байна гэдэг байр суурьнаас харж дүгнэж ярьж байна. Гэхдээ популизм өөрөө устгах боломжгүй, төрийн чадамжгүй байдлаас үүдэн урт хугацааны популизмыг авчрах эрсдэл мөн өндөр байгааг анхаарах ёстой.

Энэ нөхцөл манайд ирээдүйд илэрч гарах нөхцөл бүрдэж байна үзэж болно.

Учир шалтгаан нь юунд оршиж байгааг дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзье.

Ковидыг дотооддоо алдсан үеийн бодлого

2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Засгийн газрын хуралдааны шийдвэр гаран анх удаа Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гарсан. Энэхүү шийдвэр гарсан цагаас эхлэн цар тахал дотооддоо алдсан тохиолдолд бид бэлэн эсэхэд эргэлзсэн шийдвэр, чиглэлүүд хөвөрч эхэлсэн болно.

Тухайлбал, хувийн унаа унах эсэх, дэлгүүр орох цагт хязгаарлалт хийх, яаралтай эмнэлгийн тусламж авах зэрэг хүний анхан шатны хэрэгцээг хэрхэн зохицуулсан талаар зааварчилгаа улс орон даяар олж хараагүй болно. Ковид 19-ийн эсрэг хуульд заасан “хүнийг ялгаварлан гадуурхаагүй, нэр төрийг нь доромжлоогүй байх” шаардлага нь анхны голомтын эерэг гарсан иргэний овог нэр, регистрийн дугаар нь орон даяар цацагдахад хуулийн хэрэгжилт хангах талаар шийдвэр гаргагчдын зүгээс дорвитой шийдвэр авч чадахгүй байсан.

Харин нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандсаны үр дүнд хүний эрхийн зөрчлүүдийг засаж явсан. Мөн УОК, НОК-ийн уялдаагүй үйл ажиллагаанаас үүдэн гарсан шийдвэр нь маш их дарамт, хүнд суртал, хүний суурь эрхийг зөрчсөн үйлдлүүд болж байсан хэдий ч нэг сарын турш хатуу хөл хориог нийгмээрээ даван туулсан болно. Энэ хугацаанд эрх баригчдын улс төрийн манлайлал, эрсдэлийн менежмент хийгээгүй, бодлогын сонголтгүй, чадамжгүй байдалд нийгмээрээ үнэлгээ тавьсан болно.

Улмаар бүх шатны сонгуулиуд дуусаад ийнхүү дотооддоо халдварласан байдал нь хяналт сул, ялалтанд бялуурсан, бялуу хуваагдалд хүчтэй өрнөсөн, эрх мэдлийн шилжилтийн зай үүссэн нөхцөлтэй шууд хамаатуулж ойлгохоор улс төрийн хариуцлагагүй байдал гэж хэлж болно.


Цар тахал дотооддоо алдаж гаргасан шийдвэрүүд нийгэмд хэрхэн үнэлэгдэж байгааг дараах судалгаагаар үзүүлье.

Хоёрдугаар хэсэг. Судалгааны үр дүн

Түүврийн бүтэц:

Судалгаанд нийт 196 хүн оролцсоноос эрэгтэй 17.3 хувь, эмэгтэй 83.2 хувийг эзэлж байна. Оролцогчдын насны медиан нь 29 ба 16-89 насны хооронд байлаа. Улаанбаатар хотын оролцогчид 84.7 хувь бол 16.3 хувь нь орон нутгийнх, оролцогчдын 75 хувь нь дээд боловсролтой, 24 хувь нь бүрэн дунд боловсролтой, 1.5 хувь нь бүрэн бус дунд боловсролтой.

Ажил эрхлэлтийн байдлыг харахад, оюутан, төрийн байгууллага, хувийн хэвшилд ажилладаг хүмүүсийн оролцоо их байв.



НЭГ. АЙДАС БА ЗОВИНОЛ**Ирээдүйд айх айдас:**

Судалгаанд оролцогчид ирээдүйн 1-2 жилийн хугацаанд хамгийн их айж байгаа зүйлийг дараах байдлаар үзжээ. Үүнд:



Одоогийн нөхцөл байдалтай холбоотойгоор ирээдүйд цар тахал дуусахгүй, өвчин ихээр гарах, эдийн засаг муудах, ажлын байргүй болох, ЕБС, их, дээд сургуулийн боловсролын чанар муудах, боловсрол муутай хүмүүс бий болох, КОВИД-ийн эмчилгээ хүртээмжгүй байхаас хамгийн их айж байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа. Бусад хэсгийг дэлгэрэнгүйгээр харвал:

1. Улс төрөөс, Дэглэмээс
2. Бизнесээс
3. Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байхаас
4. Ковидоос болж хүмүүс нас барахаас
5. Мэдэхгүй
6. Гэр бүл эрсдэлт орох вий гэхэс
7. Хүчирхийллээс
8. Шударга бус байдлаас
9. Ядуурлаас
10. Агаарын бохирдлоос
11. Архидалтаас
12. Ахмад настнуудад санаа зовж, айж байна
13. Бослого, хөдөлгөөн гарахаас
14. Ёс суртахуунгүй байдлаас
15. Өр, зээлнээс
16. Тусгаар тогтнолоо алдахаас
17. Хүнсний аюулгүй байдлаас
18. Цалин орлого багасахаас
19. Барааны хомсдол үүсэхээс

Ирээдүйн 1-2 жилийн хугацаанд айж байгаа зүйлийг Улаанбаатар хот болон орон нутгийн хувьд ялган харуулбал:

оролцогчдын хувьд		оролцогчдын хувьд	
Цар тахал дуусахгүй, өвчин гарах	16.20%	Эдийн засаг муудах	30.80%
Ажлын байргүй болох	9.70%	Боловсрол муудах	19.20%
Эдийн засаг муудах	8.40%	Цар тахал дуусахгүй, өвчин гарах	15.40%
Боловсрол муудах	7.80%	Ажлын байргүй болох	11.50%
Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	7.80%	Айх зүйл алга	11.50%
Хил нээхгүй байх, гадаад явж чадахгүй	6.50%		

Ирээдүйдээ айх айдсыг ажил эрхлэлтийн байдалтай харьцуулан харахад:

Оюутнуудын хувьд:	Төрийн бийгууллагын албан хаагчдын хувьд:	Хувийн хэвшилд ажилладаг хүмүүсийн хувьд:	Хувьнараа хөдөлмөрлөдөг хүмүүсийн хувьд:	Тэтгэврийн хүмүүсийн хувьд:	Ажилгүй хүмүүсийн хувьд:
Боловсрол муудах	Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Эрүүл мэндийн үйлчилгээ ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	Боловсролын чанар муудах	Хяналт үнэмлэхүй үргэлжлэх гэрээ байх	Хил нээхгүй байх, гадаад явж чадахгүй
Эдийн засаг муудах	Ажлын байргүй болох	Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Бизнесгүй болох Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байх	Бэлтгэл хангалуун чанар муудах	Төрийн тнийдмэр буруу, шовхон үй байх
Хил нээхгүй байх, гадаад явж чадахгүй			Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Архидалт	Цар тахал дуусахгүй, өвчин гарах
Цар тахал дуусахгүй, өвчин гарах			Ажлын байргүй болох	Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байх Ес сургажуулалт байдал Тусгаар үйлчилгээ алдах Хүндрэлтэй	Ажил олдсохгүй байх
				Цар тахал дуусахгүй, өвчин гарах	
				Ядуурал	

Ирээдүйд айх айдсыг хүйсийн хувьд ялгаатайгаар харахад:

Эрэгтэй хүмүүсийн хувьд	Эмэгтэй хүмүүсийн хувьд
Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Цар тахал дуусахгүй, өвчин гарах
Хорио цээр үргэлжилж гэртээ байх	Боловсролын чанар муудах
Эдийн засаг муудах	Эдийн засаг муудах
Төрийн шийдвэр буруу, оновчгүй байх	Эрүүл мэндийн үйлчилгээ, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх

Яг одоо айж байгаа айдас:

Яг одоо айж байгаа зүйлээ судалгаанд оролцогчид дараах байдлаар авч үзсэн байна.

Үүнд:

1	Цар тахал дуусахгүй, өвчин гарах
2	Боловсролын чанар муудах
3	Архидалт
4	Хорио цээр үргэлжилж гэртээ байх
5	Цалин, орлого, өрхийн санхүүгийн байдал
6	Гэр бүл эрсдэлд орох
7	Вакцин гарахгүй байх, үр дүнгүй байх, хүртээмжгүй байх
8	Ёс суртахуунгүй байдал
9	Төрийн шийдвэр, арга хэмжээ оновчгүй байх
10	Эдийн засаг, санхүү муудах
11	Эрүүл мэндийн үйлчилгээ, ковидын эмчилгээ
12	Улс төр, төрийн байгууллагын үйл ажиллагаа
13	Өр, зээл

Одоогийн айдсыг хүйсийн хувьд ялгаатайгаар харахад:

Эрэгтэй хүмүүсийн хувьд	Эмэгтэй хүмүүсийн хувьд
Архидалт	Архидалт
Боловсролын чанар муудах	Боловсрол муудах
Ёс суртахуунгүй байдал	Цар тахал дуусахгүй, өвчин их тархах
Хорио цээр үргэлжилж, гэртээ байх	
Цалин, орлого багасах, өрхийн санхүү	
Цар тахал дуусахгүй, өвчин их тархах	

Байршлын ялгаатай байдлаар нь харахад дараах үр дүн гарлаа.

Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд	Орон нутгаас судалгаанд оролцогчдын хувьд
Цар тахал дуусахгүй, өвчин их тархах	Цар тахал дуусахгүй, өвчин их тархах
Архидалт	Төрийн шийдвэр, арга хэмжээ
Боловсролын чанар муудах	
Цар тахал дуусахгүй, өвчин их тархах	

Боловсролын түвшингөөр нь ялгаатайгаар харахад, дийлэнх хувийг дараах айдсууд үзүүлж байна.

Бүрэн бус дунд боловсролтой	Бүрэн дунд боловсролтой	Дээд боловсролтой
Цар тахал дуусахгүй, өвчин гарах	Архидалт	Архидалт
Мэдэхгүй	Боловсролын чанар муудах	Боловсролын чанар муудах
	Төрийн шийдвэр, арга хэмжээ оновчгүй байх	Цар тахал дуусахгүй, өвчин их тархах
	Хорио цээр үргэлжилж, гэртээ байх	

Санаа зоволттой холбоотой асуудлууд:

Судалгаанд оролцогчид гэр бүлийнхээ хувьд хамгийн их санаа зовж байгаа зүйлийг дараах байдлаар үзжээ. Үүнд:



Дэлхий дахинд тархаад байгаа КОВИД-19 цар тахал дуусахгүй, цаашид улам их тархах, эдийн засаг, санхүү хямрах, цалин орлого буурах, сургуулиудын боловсролын чанар муудах, эрүүл мэндийн үйлчилгээ болон КОВИД-ийн эмчилгээ хүртээмжгүй байхаас хамгийн их санаа зовж байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа. Түүнчлэн агаар орчны бохирдол, ажлын байргүй болох, хүнс ба барааны хомстолд орох, өр зээлээ төлж чадахгүй болох, орон байргүй болох, төр засгийн шийдвэр арга хэмжээ буруу байх, вакцины хүртээмж, хөл хорио удаан үргэлжлэх зэрэг асуудалд санаа зовж байна.

Гэр бүлийнхээ хувьд санаа зовж байгаа зүйлийг Улаанбаатар хот болон орон нутгийн хувьд ялган харуулбал:

Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд		Орон нутгаас судалгаанд оролцогчдын хувьд	
Цар тахал үргэлжилж, тархах	38.90%	Цар тахал үргэлжилж, тархах	46.40%
Эдийн засаг, санхүү хямрах	18.50%	Эдийн засаг, санхүү хямрах	10.70%
Цалин, орлого буурах	8.30%	Цалин, орлого буурах	14.30%
Ядуурал	3.20%	Ядуурал	7.10%
Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	6.40%	Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байхаас	3.60%

Гэр бүлийнхээ талаар санаа зовж байгаа зүйлсийг боловсролын хувьд ялган харуулбал:

Санаа зовж буй зүйлс	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Дээд
Цар тахал үргэлжилж, тархах	0%	40.9%	40.6%
Эдийн засаг санхүү хямрах	33.3%	13.6%	18.1%
Хөл хорио удаан үргэлжлэх	33.3%	6.8%	2.2%
Цалин орлого буурах	0%	6.8%	10.1%
Боловсролын чанар муудах	0%	2.3%	8.7%
Эрүүл мэнд, ковидын эмчилгээ хүртээмжгүй байх	0%	0%	8%

Гэр бүлийнхээ талаар санаа зовж байгаа зүйлсийг ажил эрхлэлтээр ялган харуулбал:

Гэр бүлийн хувьд санаа зовж буй зүйлс	Оюутан	Төрийн байгууллага	Хувийн хэвшил	Хувинараа	Тэтгэвэрт	Ажилгүй
Цар тахал үргэлжилж, тархах	33.9%	53.8%	40.5%	23.1%	0%	38.5%
Эдийн засаг санхүү хямрах	21.4%	13.5%	14.3%	30.8%	20%	15.4%
Цалиг орлого буурах	8.9%	5.8%	14.3%	15.4%	0%	7.7%
Ажилгүйдэл	5.4%	0%	0%	7.7%	0%	7.7%

Судалгаанд оролцогчид улс орны хувьд хамгийн их санаа зовж байгаа зүйлийг дараах байдлаар үзжээ. Үүнд:



Судалгаанд оролцогчид эдийн засаг хямрах, цар тахал үргэлжилж, тархах, улс орноороо өрөндөө баригдаж, цаашилбал газар нутгаа алдахад хүрэх вий, одоогийн цар тахлын нөхцөл байдалтай холбоотой болоод мөн цаашид төр засгийн зүгээс буруу шийдвэр гаргах, ядууралд нэрвэгдэх, хэт их улс төржих, чадваргүй хүмүүс эрх барих зэрэгт хамгийн ихээр санаа зовж байна. Бусад санаа зовж буй зүйлст авилга, ёс суртахууны доройтол, ажилгүйдэл, ард түмний амьжиргааны төвшин буурах, ардчилал, хүний эрх, эрх чөлөө хумигдах, аюулгүй байдал, гэмт хэрэг, хүчирхийлэл зэргийг авч үзсэн байна.


Улс орны хувьд санаа зовж байгаа зүйлийг боловсролын байдлаар ялган харуулбал:

Улс орны хувьд санаа зовж буй зүйлс	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Дээд
Эдийн засгийн хямрал	33.3%	34.9%	34.6%
Авлигад идэгдэх	33.3%	2.3%	2.9%
Амьжиргаа доройтох	33.3%	0%	0.7%
Өр зээлэнд баригдах	0%	9.3%	8.8%
Төрийн шийдвэр, арга хэмжээ буруу байх	0%	2.3%	10.3%

ХОЁР. ХАНДЛАГА, ХАРИЛЦАА БА ИТГЭЛ

Судалгаанд оролцогчдын хөл хорио, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа шийдвэрүүд, КОВИД 19, эрх чөлөөнд хандах хандлагыг судлахад дараах үр дүн гарлаа.

Хөл хорионд хандах хандлага:



Судалгаанд оролцогчдын 57 хувь нь хөл хориог

- Өвчин тарх эрсдэлээс хамгаалсан зөв алхам, зөв шийдвэр

- Шинэ зүйл сурах, өөрийгөө хөгжүүлэх, гэр бүлийнхэнтэйгээ илүү ойр харилцах боломжийг бий болгосон гэж үзэн эерэгээр хандаж байна.

Харин 38 хувь нь хөл хорионд сөрөг хандлагатай байна.

- Эдийн засаг, гэр бүлийн санхүү хэцүү байна
- Боломжууд хязгаарлагдмал
- Гэрийнхнээс хол байгаа хүмүүсийн хувьд хэцүү байна
- Цаг хугацааг хий дэмий өнгөрүүлж байна
- Уйтгартай, ганцаардмал байна
- Гэр хороололд амьдарч байгаа сурагчид хичээлээс их хоцорч байгаа. Олон хүүхэдтэй айл өрх хичээлүүдийг нөхөж үзэх боломж бага
- Гэр бүл, хүүхдийн хүчирхийлэл гарч байна.
- Ажлын хамт олон, өдөр тутмын тогтсон хэмнэлээ санаж байна.

Хөл хорионд хандах хандлагыг хүйс, байршлын хувьд ялгаатай эсэхэд статистик шинжилгээ хийж үзэхэд илэрхий ялгаатай байдал гарсангүй. Харин боловсролын хувьд болон ажил эрхлэлтийн байдлаас шалтгаалан хандлага нь өөр байна. Энэ үр дүнг дэлгэрүүлэн харуулбал:

Боловсролын түвшингөөр нь:

	Бүрэн бус дунд боловсролтой	Бүрэн дунд боловсролтой	Дээд боловсролтой
Эерэг хандлагатай	66.7%	52.9%	58%
Сөрөг хандлагатай		46.6%	35.3%
Нейтраль хандлагатай	33.3%	0.5%	6.7%


Бүрэн бус дунд боловсролтой хүмүүсийнх дийлэнх нь эерэг хандаж, сөрөг хандлагагүй болох нь судалгааны үр дүнгээс гарч байна.

Ажил эрхлэлтээр нь:

	Оюутан	Төрийн байгууллагад ажилладаг	Хувийн хэвшилд ажилладаг	Хувиараа бизнес эрхэлдэг	Ажилгүй	Тэтгэвэрт
Эерэг хандлагатай	45.5%	74.5%	57.1%	53.9%	61.5%	30%
Сөрөг хандлагатай	50.9%	21.5%	33.3%	46.2%	38.5%	70%
Нейтраль хандлагатай	3.6%	4%	9.6%			

Төрийн байгууллагад ажилладаг хүмүүс болон ажилгүй хүмүүсийн хувьд хөл хорионд хандах эерэг хандлага давамгайлж байгаа бол тэтгэвэрт байгаа хүмүүсийн хувьд сөрөг хандлага дийлэнх нь байна. Тэтгэврийн хүмүүст нийгмийн харилцаа, үр хүүхэд, ач зээтэйгээ уулзах, найзуудтай уулзах, гадуур гарах хэрэгцээ их байгаа нь тэдний сөрөг хандлагаас харагдаж байна.

Засгийн газрын шийдвэрүүдэд хандах хандлага:



Судалгаанд оролцогчдын 52 хувь нь Засгийн газрын шийдвэрүүдэд сөрөг хандлагатай байна. Үүнд:

- Хот суурингийн том хаусанд амьдардаг хүмүүс цахилгаан, ус, дулааны хэрэглээндээ хэдэн зуун мянгыг төлдөг бол хөдөө орон нутгийн иргэд бага төлбөр төлдөг гэх мэт ялгаатай. Гэр хорооллын зөөврийн усны төлбөрийн талаар оновчтой арга хэмжээ аваагүй.
- Иргэдээ чин сэтгэлээсээ бодоогүй дараагийн сонгуулийн шоу
- Судалгаа, шинжилгээний үндэслэлгүй шийдвэрүүд
- Нэг гаргасан шийдвэртээ үнэнч бус, эргэж буцдаг, төрийн удирдлагууд чадваргүй байна.
- Засгийн газрын шийдвэрүүд ямар ч уялдаа холбоо байхгүй. Халамж гэсэн хавтгайруулсан бодлогоос болоод маш олон тооны хүмүүс юу ч хийхгүй амьдарч болно гэсэн ойлголттой болж байна.
- Зөв шийдвэрийг хэрэгжүүлэх шатандаа буруу үйл ажиллагаа явуулж байна.

Харин 38 хувь нь Засгийн газрын шийдвэрийг зөв зүйтэй, ард иргэддээ дэмжлэг болсон гэж эерэгээр хандсан байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа.

Засгийн газрын шийдвэрүүдэд хандаж байгаа хандлагыг хүйс, боловсролын төвшин, байршил, эрхэлж буй ажлын ялгаатай байдлаар нь статистик шинжилгээ хийж үзэхэд илэрхий ялгаа гарсангүй.

Ирээдүйд Засгийн газартаа хандах хандлага:

Судалгаанд оролцогчдын хандлага:



Судалгаанд оролцогчдын 45 хувь нь ирээдүйд Засгийн газартаа сөргөөр хандаж байна.

Үүнд:

- Ард иргэддээ мөнгө тараах биш ажлын байраар хангах шаардлагатай байна.
- Хэрвээ сэтгэл хөдлөлөөрөө гаргасан шийдвэрээ үргэлжлүүлсээр байвал ард иргэд ойрын хэдэн жил хэцүүхэн амьдрал туулах болно

Маш олон тооны өр зээл бондын эргэн төлөлт ойртож байхад сонгуулийнхаа PR хийсээр маш олон өнөө маргаашаа аргацаасан шийдвэр гаргаж байгаа нь харамсалтай. Манай улс сонгуулиас сонгуулийн хооронд амьдардаг нь ажиглагддаг.

- Жинхэнэ ард иргэдийнхээ амьдралд тус болсон оновчтой, судалгаатай шийдвэр гаргамаар байна, төрийн албан хаагчид цалин тасрахгүй байгаа, хувийн хэвшлийнхэн маш хэцүү байдалтай байна.

Судалгаанд оролцогчид Засгийн газрыг хойшид дараах байдлаар ажиллахыг хүсч байна.

Үүнд:

- Шийдвэрээ бодитой, судалгаатай гаргах	15.20%
- Эрсдэлийг тооцож, зөв төлөвлөгөө, хөгжлийн бодлого гаргах	13.90%
- Мэргэжлийн, шударга хүмүүс ажиллуулах	12.70%
- Ажлын байр хадгалах, нэмэгдүүлэх	8.90%
- Бэлэн мөнгө тараах болон халамжаас татгалзах	8.90%
- Иргэд, ААН-ийг дэмжих	7.60%

Ирээдүйд итгэх итгэл:

Судалгаанд оролцогчдын 81.4 хувь нь ирээдүйдээ итгэх итгэлтэй байна. Үүнд:

- Вакцин гарч бүх зүйл хэвийн байдалдаа орно.
- Хүн бүр эрүүл орчинд, ажлын байртай орлого сайтай сэтгэл хангалуун амьдарна.
- Шударга байдал тогтоно гэдэгт итгэлтэй байна.

Хөл хорионы үед “БИ”



Судалгаанд оролцогчдын 18.4 хувь нь өөртөө сөрөг хандаж байсан.

Үүнд:

- Цахимаар өдөр шөнөгүй ажиллаж, ажлын ачаалал улам нэмэгдсэн тул стресстэй байна.
- Сэтгэл санаа тогтворгүй байна.
- Чимээгүй тайван орчинд ажилламаар байна.
- Уйдаж, ганцаардаж байна.
- Нойрны хэмнэлээ алдсан
- Үр ашиггүй цагийг хий дэмий өнгөрөөж байгаадаа харамсаж байна.

Судалгаанд оролцогчдын 13 хувь нь өөртөө эерэг хандаж байна.

Үүнд:


- Сууж хийх шаардлагатай байсан амжуулаагүй ажлуудаа амжуулж байна
- Эрүүл мэнд ямар чухал болохыг илүү ихээр мэдэрч, гэр бүлийн харилцаа бол амьдралын чухал үнэт зүйл гэдгийг ойлгож байна. Гэр бүлийнхэнтэйгээ цагийг сайхан өнгөрөөж байгаа.

25.9 хувь нь өөрийгөө хөгжүүлэх цаг гарсан гэж үзжээ.

Үүнд:

- Даалгавар бие даалтаа сайн хийх, гадаад хэл сурч байгаа
- Цахимаар ажиллаж мэдээлэл технологийн орчин үеийн арга техникийг эзэмшиж байна
- Шинэ хоол хийж сурч байгаа.
- Буруу зан үйлээ засахыг хичээж байна.

Гэр бүлийн харилцаа:



- Судалгаанд оролцогчдын 9.4 хувь нь гэр бүлийн харилцаа нь тааламжтай биш, гэрийнхнээсээ тусдаа баймаар байгаа талаар хариулсан байна.
- 67.8 хувь нь гэр бүлийн харилцаа илүү ойр дотно, илүү нээлттэй, аз жаргалтай байна гэжээ.

Судалгааны дүгнэлт

Судалгаанд оролцсон байдлаас харахад, эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх, оролцоо эрэгтэйчүүдээс өндөр байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь эрүүл мэндийн үйлчилгээ, түүний хүртээмж хангалтгүй байх, эдийн засгийн хүндрэл, амьжиргааны төвшин буурах, боловсролын чанар муудахаас хамгийн их айж, санаа зовинож байна.

Судалгаанд оролцогчдын 57 хувь нь хөл хорио тогтоох арга хэмжээ нь өвчин тарах эрсдэлээс хамгаалсан зөв шийдвэр гэж дэмжиж байна.

Харин Засгийн газрын хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, шийдвэрүүдэд 52 хувь нь сөрөг хандлагатай байна. Шийдвэр гаргахдаа судалгаанд үндэслээгүй, олон талыг харгалзаагүй, нэг гаргасан шийдвэртээ үнэнч бус, эргэж буцдаг, одоогийн төрийн удирдлагууд чадваргүй байна гэжээ.

Засгийн газартаа сөрөг болон шүүмжлэлтэй хандаж байгаа нь 86 хувийг эзэлж байна.

Халамжийн бодлогыг өөрчлөх, ард иргэддээ мөнгө тараах биш, ажлын байраар хангах, түр зуурын бус урт хугацаандаа үр өгөөжтэй арга хэмжээ авах хэрэгтэй гэж дийлэнх нь хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын 81.4 хувь нь ирээдүйгээ өөдрөгөөр харж, ирээдүйдээ итгэх итгэл дүүрэн байна. Түүнчлэн хөл хорионы үед гэр бүлийн харилцаанд эерэг талууд бий болсон, гэр бүлийн уур амьсгал таатай, аз жаргалтай байгаа гэж 67.8 хувь үзжээ.

Дээрх судалгаанаас дүгнэлт хийхэд Засгийн газрын хэрэгжүүлж байгаа шийдвэрт 52 хувь сөрөг, Засгийн газрын чадамжинд сөрөг хандаж байгаа нь 86 хувь гэсэн судалгааны үр дүнгээс бид Өндөржүүлсэн бэлэн байдал зарласан цагаас эхлэн дотооддоо халдвар илрэх хүртэл хугацаанд төрийн зүгээс нэгдсэн хамгаалах ямар нэгэн бодлого байхгүй байж үзэж байна.

Учир нь гаргасан шийдвэр бүрт нийгмийн зүгээс сайшаалтай хүлээн авахгүй, асуудал үүсэх бүрт дахин засаж шийдвэр гаргаж байгаа нь энэхүү эргэлзээг улам бататгаж байгаа юм.

Дэлхийн улс орнууд амжилттай ковид 19-ийн эсрэг бодлого баримталж буй Улс төрчид дараах гурван зүйлийг чандлан баримталж байна гэж үзсэн. Үүнд:

- Шинжлэх ухаанчаар байлдан дагуулах
- Харилцааны чадвартай байх
- Хамтаараа хийж байгаа гэдгийг ойлгуулах, хамт гэсэн мэдрэмжийг төрүүлэх гэсэн байсан.

Гуравдугаар хэсэг. КОВИД-19 цар тахлын үеийн арга хэмжээ ба Ардчилал, хүний эрх, хэвлэл мэдээлэлд үзүүлэх нөлөөлөл

Судлаачид “Ковид-19” цар тахлын сорилт хүн төрөлхтөнд зарим онцгой нөхцөлийг тулгаж байгаа ч хүндрэл бэрхшээлийг бид өөрөөр харж, түүнээс зарим боломжийг эрэлхийлэх нь чухал байгааг онцолж байна. ДХБ-ын гишүүн орнууд хилээ хаасантай холбогдуулан дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл үүсэж болох юм. Мөн төрийн үйлчилгээг илүү ухаалаг, цахим хэлбэрт оруулах, мэдээлэл, технологийн салбарт хөрөнгө оруулалт түлхүү хийх хэрэгцээг энэхүү сорилт улс орон бүхний өмнө авчирлаа.

Иймээс монголчууд бид цар тахлын улмаас өөрчлөгдөн буй дэлхий ертөнцөд дасан зохицох, цаашид нарийн төлөвлөгөө боловсруулж эхлэх, харин ч энэхүү нөхцөл байдлыг өөрт давуу тал болгон ашиглах талаар төлөвлөх нь зүйтэй.

Судлаач Ювал Ноа Хараре “Коронавирусийн дараах дэлхий ертөнц” нийтлэлдээ “Хүн төрөлхтөн дэлхий нийтийг хамарсан хямралтай нүүр тулаад байна. Бүр манай үеийн хамгийн том хямрал. Энэ хэдэн өдрүүдэд хүмүүс хийгээд Засгийн газруудын гаргах шийдвэр ирэх жилүүдэд дэлхий ертөнц ямар байхыг тодорхойлох болно. Энэ шийдвэрүүд бидний эрүүлийг хамгаалах тогтолцоог төдийгүй манай эдийн засаг, улс төр, соёлыг тодорхойлно. Бид түргэн, бас шийдэмгий хөдлөх ёстой. Бидний үйлдэл урт хугацааны үр дагавартай гэдгийг тооцох хэрэгтэй.

Сонголт хийхдээ зөвхөн энэхэн зуурын аюул заналыг даван туулах төдийгүй “гай гамшиг” өнгөрсөн хойно ямархуу дэлхийд амьдрахаа бас эргэж өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Тиймээ, энэ гай гамшиг өнгөрнө, хүн төрөлхтөн даваад гарна, бидний ихэнх нь эсэн мэнд үлдэнэ, гэхдээ бид өөрчлөгдсөн дэлхийд амьдрах болно” гэсэн бөгөөд цаашдаа үндсэрхэг үзлийн хананд бус даяар хамтын ажиллагаа, эв санааны нэгдлийг хангахын чухлыг онцолсон.

КОВИД 19 цах тахлын үеийн арга хэмжээ ба Ардчилал

Олон улсын Ардчиллын боловсрол, туслалцааны хүрээлэнгээс гаргасан судалгааны тайланд Монгол улс нь цар тахлын үед хамгийн шуурхай харцу арга хэмжээ авсан орнуудын нэг бөгөөд нэгдүгээр сарын сүүл гэхэд Хятадтай хилээ хааж, сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг зогсоосон боловч онцгой байдал зарлаагүй юм. Харин ч 6 сард зохих хязгаар, урьдчилан сэргийлэх арга хэмжээг аван Парламентын сонгуулийг зохион байгуулсан. 2020 оны 3 сарын 24-ний өдөр, Улсын онцгой байдлын газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн бөгөөд 2020 оны 4 сарын 30 хүртэл үргэлжлүүлсэн. Харин 2020 оны 8 сарын 31-нээс энэхүү өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасан. Харин дотоодод халдвар гарсан үе буюу 11 сарын 11-нд зарлагдан 12-ны өдрөөс УОК-ын саналын дагуу Засгийн газраас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн болно.

Зураг. 2.Эх сурвалж Олон улсын ардчиллын бөлөвсрол, туслалцааны хүрээлэн, 2020

Mongolia (COVID-19)

■ 0.00 - 0.399 Low performance
 ■ 0.40 - 0.70 Mid-range performance
 ■ 0.701 - 1.00 High performance



Энд хийсэн үзүүлэлтээр Монгол улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бүхэлдээ ардчилсан засаглалын зарчмууд, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр муугүй ажиллаж байгааг харуулж байгаа юм. Харин ганцхан үзүүлэлт болох шууд ардчиллын чиглэлээр хангалтгүй үзүүлэлттэй байгаа нь цар тахлын үеийн хөл хорионы үеэр олон нийтийг хамруулсан цуглаан, хурал зохион байгуулах болохгүйтэй холбоотой гэж үзэж байгаа юм.

Дэлхийн олон оронд сонгуулийг хойшлуулах хандлага байсан боловч БНСУ-ын жишгээр парламентын болон орон нутгийн сонгуулиуд зохих хугацаанд зохион байгуулсан юм. Олон улсын Ардчилал болон Сонгуулийн туслалцааны хүрээлэн /IDEA/ гээс 2020.02.21-2020.07.19 хооронд дэлхий нийтээр сонгуулийн үйл явцадтай холбоотой үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн бөгөөд эдгээрт бүх нийтийн санал хураалт, улсын болон орон нутгийн сонгуулиудыг хамруулжээ Үүнд:

- 75 улс, нутаг дэвсгэрт улсын болон орон нутгийн чанартай сонгуулиа КОВИД-19 цар тахлаас болж хойшлуулсан бөгөөд үүнээс 40-өөд оронд нь улсын сонгууль, бүх нийтийн санал хураалтаа хойшлуулсан байна.
- 99 улс, нутаг дэвсгэрт улсын болон орон нутгийн чанартай сонгуулиа КОВИД-19 цар тахлаас болж хойшлуулалгүй явуулсан бөгөөд үүнээс 76 оронд улсын сонгууль, бүх нийтийн санал хураалтаа зохион байгуулсан байна.
- 48 улс, нутаг дэвсгэрт КОВИД-19 цар тахлаас болж хойшлуулсан улсын болон орон нутгийн чанартай сонгуулиа зохион байгуулсан бөгөөд үүнээс 26 оронд улсын сонгууль, бүх нийтийн санал хураалтаа зохион байгуулсан байна.

Өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ын сонгуулийг хойшлуулах санал гаргаж байсан боловч УИХ болон Засгийн газрын зүгээс сонгуулийг хойшлуулах шаардлагагүй гэж үзсэн юм. Тухайлан, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2020.03.25-ны өдөр ард түмэндээ хандан зургаан зүйл “Улсын төсөвт тодотгол хийж, сонгуульд зориулсан болон тэвчиж болох бүх зардлыг танаж, үүнээс гарсан мөнгийг хямралын эсрэг арга хэмжээнд зарцуулах, үүний тулд энэ удаагийн УИХ-ын сонгуулийг хойшлуулж, түүнд зарцуулах хөрөнгө мөнгийг хэмнэх, хямралын нөхцөлд зохицуулан төрийн удирдлагыг төвлөрүүлэх шаардлагатай байна” хэмээн уриалга гаргаж байсан юм.

УИХ-ын сонгуулийн үед сонгогчдын ирц харьцангуй өндөр буюу 73.65 хувьтай байсан бөгөөд эрх баригч МАН үнэмлэхүй олонхын суудлыг авч чадсан юм. Сонгуулийн ирцийг судлаач Д.Уртнасан дүгнэхдээ “Монгол улс 1992 оноос хойш 2020 он хүртэл нийт 8 удаагийн парламентын сонгууль явуулсан бөгөөд эхний 6 удаагийн сонгуулийн ирц тогтмол буурсан бол 2016 онд 73,58%-д хүрч өмнөх сонгуулиас 6,28 функцээр өссөн бол 2020 онд 73,60% болж өсөлтөө хадгалсан үзүүлэлттэй байна” гэжээ.

Мөн уг үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлсэн нь



Ийнхүү цар тахлын аюул, айдас байсан ч гэсэн ирц өндөр гарсан нь сонгогчдын боловсролд зориулсан сурталчилгаа мэдээллийн ажил, кампанит ажлууд нэлээд сайн зохион байгуулагдсантай холбоотой. Учир нь эхэндээ иргэд цар тахлын аюулаас болоод идэвхгүй оролцох байх гэсэн болгоомжлол шийдвэр гаргагчдын дунд байсан юм. Тухайлбал, залуучуудын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой ӨГЛӨӨ, НАДАД НЭГ САНАЛ БАЙНА зэрэг цахим аян, цуврал арга хэмжээнүүд нь олонд нэлээд сайн хүрч чадсан. Олон улсын байгууллагууд ч гэсэн энэ чиглэлээр анхаарч дэмжлэг үзүүлсэн юм. Үүнээс гадна гадаадад орнуудад зорчиж байгаа, цар тахлын үеийн хөл хорионоос болж ирж чадаагүй олон хүмүүс сонгуульд оролцож чадаагүй юм. Мөн УИХ-ын Сонгуулийн тухай хуульд “Гадаад улсад сурч, ажиллаж, амьдарч байгаа Монгол улсын сонгогчдын УИХ-ын сонгуульд оролцох, саналаа өгөх эрхийг хуульчилж заагаагүй” байгаа нь гадаадад оршин суугаа, сонгуулийн насны 150 мянга гаруй иргэдэд мөн л сонгох эрхгүй болсон юм.

Сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос зай барих, маск зүүх, олон нийт цугларсан арга хэмжээнд халуун хэмжигч, гар ариутгагч шингэн ашиглах зааварчилгаа гаргаж мөрдөж ажилласан болно. Энэ талаар Д.Уртнасан өгүүлэлдээ

“Коронавируст халдварын (КОВИД-19) УИХ-ын сонгуулийн үйл ажиллагааг сонгогч болон сонгуульд ажиллаж байгаа алба хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс сонгуулийн санал авах байр, нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны үед аливаа арга хэмжээ, сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглааны үйл ажиллагаа явуулах өрөө тасалгааны ариутгал халдваргүйжилтийг ханган, сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглааныг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Цахим хэлбэрээр зохион байгуулах боломжгүй тохиолдолд арга хэмжээнд оролцогч хүн хоорондын зай 1,5 метрээс доошгүй байх бөгөөд биеэр хүрэлцэхгүй (гар барих, тэврэх, үнэсэх) зайнаас харилцаж, оролцогчид амны хаалт заавал зүүж, оролцогчдын биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэн, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүйн тулд танхимд хийх уулзалт, хурал, цуглааныг богино цагаар (нэг удаагийн уулзалт, хурал цуглаан 2 цагаас хэтрэхгүй) зохион байгуулахыг журамлажээ. Түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг тараах үед нэг удаагийн бээлий өмсөн, гэр бүлийн гишүүдтэй харьцахгүйгээр, хаалганы гадна талд үлдээнэ хэмээн заасан байна. Өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд сонин хэвлэл, радио, телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид иргэдийг сонгох эрхээ эдлэх, сонгуульд оролцохдоо коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх журам, дэглэмээ мөрдөх, сонгуулийн явц, санал хураалтын дүнг нийтэд шуурхай мэдээлж ажилласан байна. Санал авах байранд сонгогчийн санал авах үед болон сонгуулийн үйл явцын бүхий л үед халдвараас сэргийлэх үйл ажиллагааг сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүн, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн даамал, үйлчлэгч, ажиглагч болон мэргэжлийн хяналт, цагдаа, онцгой байдал, эрүүл мэнд, нутгийн захиргааны байгууллагын нийт 35772 төрийн алба хаагч нар хамтран зохион байгуулж, хяналт тавин ажилласан” гэжээ.

Сонгуулийн үйл явцыг Европын Аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага зэрэг гаднын ажиглагчид ажиглаагүй ч гэсэн Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт сүлжээ зэрэг ажиглагч байгууллагууд ажиллаж, мэдээллээ хуваалцаж байсан юм. Тус байгууллагаас Нийслэл болон 5 аймагт 100 санал хураах байруудад ажиглалт хийсэн байна.

УИХ-ын сонгуулийн ирцийн хувьд өмнөх сонгуулийн ирцтэй ижил төвшинд байв. УИХ Сонгууль хэдий өндөржүүлсэн бэлэн байдлын орчинд явагдсан ч гэсэн ч олон улсын хэвлэл мэдээллийн 11 байгууллагын 14 сурвалжлагч, дотоодын хэвлэл мэдээллийн 72 байгууллагын 380 сурвалжлагч, хэвлэл мэдээллийн ажилтнууд сурвалжилж мэдээллийг цаг тухайд нь шуурхай дамжуулж ажилласан байна. Мөн оны 10 сарын 15-нд Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн сонгууль мөн ижил нөхцөлд зохион байгуулагдсан. Сонгуулийн кампанит ажлын үеэр хязгаарлагдмал орчинд сурталчилгааны мэдээллийг хэвлэмэл мэдээлэл, телевиз болон цахимаар голдуу авч байгаа нь, цахим үйлчилгээ, тоног төхөөрөмж хэрэглэж чаддаггүй, интернетгүй иргэдийн хувьд хүртээмжийг эрс хязгаарлаж байгаа юм.

Олон нийтийн хөл хорьсон арга хэмжээ нь хүний нэг үндсэн эрх чөлөө болох эвлэлдэн нэгдэх, цуглах эрхийг хязгаарласан юм. 2020 оны 1 сарын 24-ний өдрөөс эхэлсэн олон нийтийн цуглуулсан арга хэмжээ, олон нийтийн баяр, тэмдэглэлт өдрүүдийн ёслол тэмдэглэхийг хязгаарласан шийдвэрүүд гарсан нь нэг талаас эдгээр эрхийг түр хугацаанд хязгаарласан боловч цар тахал дамжих, халдварлах боломжийг зогсоож чадсанаараа үр дүнтэй арга хэмжээ болжээ. Хэдий тийм боловч, 6 сард болсон сонгуулийн кампанит ажлын үеэр голлох намууд олон нийтийг цуглуулсан арга хэмжээ зохион байгуулсан нь энэхүү зай барих арга хэмжээг зөрчсөн юм. Харин 2020 оны 11 сард, дотоодод цар тахлын голомт илэрснээр, бүрэн хөл хорио тогтоож, олон нийтийн үйлчилгээний газар, сургууль, цэцэрлэгийг хаасан. Боловсролын байгууллагууд цахимаар сургалтын үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байгаа юм.

Судлаач П.Алтанчимэг “Цар Тахал ба Монгол дахь Ардчилал” өгүүлэлдээ,

“...- Иргэд эвлэлдэн нэгдэж ил тод байдлыг ханган ажиллах талаар шаардлагыг зохих байгууллагуудад хүргэж байна.

- Төр иргэдээ албан бусаар сошиал орчноос сонсож байна. Энэ нь нэг талаас сайн хэрэг ч өөр сөрөг талуудыг дагуулах эрсдэл байгаа,

- Төрийн байгууллагуудын үйлчилгээ бага багаар цахимжиж байна. Цахим гарын үсгийн тухай хууль тэртээх 2011 онд батлагдсан ч өнөөдрийг хүртэл дорвитой хэрэглээнд нэвтрээгүй байсан. Харин өнөөгийн Цар тахлын хөл хорионы нөхцөл байдал нь энэ мэт батлагдсан хууль дүрэм журам мөн мэдээллийн технологийн дэд бүтцийг хэрэглээнд оруулах том боломж юм.

- Төрийн байгууллагын ил тод байдал хангалттай биш ч энэ тал дээр ахиц дэвшил гарч байна. 2014 онд батлагдсан “Шилэн дансны тухай” хууль, 2011 онд батлагдсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль гэх мэт хэрэгжүүлээд байгаа ч ойлгомжгүй төвөгтэй хуулийн хэрэгжилтийг ойлгомжстой, энгийн хэлбэрээр иргэдэд хүргэж ажиллах боломжит цаг хугацаа билээ” хэмээн дүгнэсэн байна.

Мөн цаашлаад энэ нөхцөл байдлыг ардчиллыг улам бэхжүүлэх боломж гэдэг талаас нь ашиглаж зөв шийдвэр гаргах хэрэгтэй гэж зөвлөжээ.

КОВИД 19 цар тахлын үеийн арга хэмжээ ба Хүний эрх

Хөл хорих арга хэмжээ нь чөлөөтэй явах, шилжих эрх чөлөөг мөн хязгаарласан юм. 2020 оны 2 сарын 23-ны байдлаар Засгийн газар улс орны хэмжээнд 336 хяналтын эргүүлийн цэг ажиллуулж, 832 албан хаагчийг дайчлан ажиллуулсан. Гадаад дотоодын нислэгээр ирэх зорчих явдлыг 2020 оны 5 сарын 31 хүртэл хязгаарласан бөгөөд энэ хугацаанд гадаадад байгаа Монголчуудыг эх орондоо буцах нөхцөлийг хангахын тулд захиалгат нислэгүүд зохион байгуулсан юм. Монгол улсад анхны тохиолдол гадаадаас ирсэн зорчигчоос илэрсэн бөгөөд энэ үе болох 2020 оны 3 сарын 10-наас эхлэн 2020 оны 2 сарын 16 хүртэл галт тэрэг, нисэх онгоц, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг зогсоож дотоодын зорчих хөдөлгөөнийг хязгаарласан. Мөн гадаадаас ирсэн хүмүүсийг Засгийн газраас тусгайлан заасан газруудад 21 хоног тусгаарлаж, ажиглалт хийсэн бөгөөд үүний дараа гэртээ 14 хоног тусгаарлалт байлгахар чиглэл өгч байсан юм.

Монголын иргэд 2020 оны 5 сарын 30 хүртэл цар тахал илэрсэн гаднын орнуудад аялахыг хориглосон. Олон улсын иргэний нислэгүүд, олон нийтийн цугларалт, гадаадын иргэд нэвтрэхийг хориглосон хорио 2020 оны 6 сарын 20 хүртэл сунгагдсан.

2020 оны 5 сарын 6-8-ны өдрүүдэд өглөө 6 цагаас орой 18 цаг хүртэл Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт тусад нь бүрэн хөл хорио тогтоож, онцгой байдлын бэлтгэл ажлын сургуулилт хийсэн.

Харин 6 сарын дундаас олон нийтийн үйл ажиллагаа, кино театр, бар, ресторан зэрэг газруудын үйл ажиллагааг зөвшөөрсөн боловч тэмцээн уралдаан, жагсаал цуглааныг хориглосон хэвээр байсан юм. Монголын үндэсний баяр наадмын үйл ажиллагааг мөн цуцалж, зөвхөн цахим хэлбэрээр зохион байгуулсан. 7 сарын дундаас фитнес клуб, бар, караоке зэрэг газрын үйл ажиллагааг зөвшөөрсөн бөгөөд үйлчлүүлэгчдийн халууныг хэмжиж, хамгаалалтын маск зүүхийг чиглэл болгосон.

Засгийн газраас 9 сарын 16-наас эхлэн соёлын болон олон нийтийн арга хэмжээ, жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэл, цэнгээнт үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зөвшөөрсөн. Мөн 9 сарын 21-нээс бүх ерөнхий боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг тодорхой цагийн болон хүүхдийн тооны хязгаарлалттайгаар эхлүүлсэн.

Харин 11 сард дотоодод халдвар илэрсний улмаас бүрэн хөл хорио тогтоож боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа цахимаар болон теле хувилбараар явагдаж байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон хөдөө аж ахуйд ажилладаг хүмүүс Ковид цар тахлын хөл хорионд хамгийн өртсөн гэж гарчээ.

Орлого буурсан болон хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөнөөс болж, ядуу иргэд хүнсний аюулгүй байдлын эрсдэлд ороод байгаа юм. Мөн зарим судалгаанаас үзэхэд (МЭК) бизнес эрхлэгчдийн орлого ихээхэн тасарч, ажилчдаа цомхтгох, цалингаа зардлаа танахад хүрээд байгаа аж.

Ковид 19 цар тахлын үеийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэг буюу бүрэн хөл хорионы горимд шилжсэнээр хүний дараах голлох эрхүүд шууд хөндөгдөж байгаа юм. Эдгээ эрх нь НҮБ-ын Хүний эрхийн конвенц зэрэг олон улсын гэрээ эрх зүй болон Үндсэн хуулинд тусгагдаж баталгаажсан эрхүүд юм. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйлд “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 12 дугаар зүйлд “Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй”, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.18 дахь хэсэгт “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй, Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно” хэмээн чөлөөтэй зорчих эрхийн тухай зохицуулсан.

Мөн хөл хорионы бас нэг сөрөг үр дагавар нь 2020 оны эхний улирал гэхэд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өмнөх оны дүнтэй харьцуулахад 50% өссөн байгаа юм. Монгол Улсын Засгийн газар 178 дугаар тогтоол баталж 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн. Тус шийдвэр гарснаар эрүүл мэндийн, албан, хувийн шалтгаанаар нийслэл, орон нутагт ирсэн иргэдийн зорчих эрхийг хязгаарлаад байна. Үүний улмаас гадаа, машиндаа хоноглох, хоол тэжээлийн хомстолд орох, бага насны хүүхэд эцэг, эхээсээ тусдаа асрамж халамжийн гадна үлдэх, ажил хөдөлмөр эрхэлж орлого олох боломжгүй болсон зэрэг олон сөрөг үр дагавар ажиглаж байгааг Нээлттэй нийгэм форумас гаргаж буй цувралд тэмдэглэжээ.

Хүний эрхий зөрчлийн талаар эрх зүй судлаач, хүний эрх хамгаалагч Б.Болорсайхан, цар тахлын үеийн Засгийн газраас авч хэрэгжүүлж үйл ажиллагааны явцад олон улсын улсын хүний эрхийн гэрээ, конвенцод заасан эрхүүд зөрчигдөж буй талаар анхааруулж, нарийвчлан дүн шинжилгээ хийжээ .

Тухайлбал, цар тахлын халдвар илэрсэнтэй холбогдуулан Ялгаварлан гадуурхахаас ангид байх эрх нь бодит болон цахим орчинд нэлээд түгээмэл ажиглагдаж байгаа гэжээ.

Мөн "... Нийслэлийн байшин хороолол бус гэр хороололд амьдардаг, дэд бүтэц дутмаг, хүүхдэд ээлтэй, аюулгүй тоглоомын талбай байхгүйн улмаас цэцэрлэгт хүрээлэнгийн усан толионд цөөнгүй тооны хүүхэд амиа алдсан, гэртээ асран хамгаалах хүнгүй орхисон хүүхдүүд тогонд цохиулж нас барсан зэрэг үйл явдал нь ялгаварлан гадуурхахаас үүдэлтэйг цаг ямагт санавал зохихыг ..." анхааруулсан байна.

Мөн Нээлттэй нийгэм форумын Ковид-19 ба Хүний эрх цувралд "... коронавируст цар тахлын нөхцөл байдлын үед буюу "онц болон дайны байдал" зарласнаас бусад тохиолдолд эх орондоо буцаж ирэх эрхийг хязгаарлаж болохгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан үндэслэл, тайлбарт нийцнэ. Харин ийнхүү хязгаарласан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж заасныг зөрчсөн гэж дүгнэжээ. Түүгээр ч үл барам Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12, 7.1.22-т зааснаар Монгол Улсын Засгийн газар цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах, хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн байнгын тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Энэ үүрэг эх орондоо байгаа иргэдийн зэрэгцээ гадаад улсад байгаа иргэдэд ч мөн адил хамаарна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Гадаад харилцааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Хөрөнгө гаргах тухай" Дугаар А/45 тушаалаар гадаадад байгаа нэр бүхий 113 иргэнд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлжээ . Гэвч Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдын яамдуудаас санхүүгийн болон бусад хүндрэл бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн өөр ямар нэг бодитой тусламж, дэмжлэг үзүүлсэн мэдээгүй байгаа ажээ.

Цар тахлын үеийн бэлэн байдлын зэргээс болоод бүхий л боловсролын байгууллагууд цахимаар болон телевизээр сургалтын үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байгаа нь интернет, цахим төхөөрөмжийн дутагдалтай суралцагчид болон тусгай хэрэгцээтэй хүмүүсийн сургалтад ижил төвшинд хамрагдах боломжийг боогдуулж байгаа юм.

Цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үеийн эхнээс хилийн чанадаас эх орондоо эргэн ирж байгаа иргэдийн зүгээс тусгаарлах байрны орчин нөхцөл, дэд бүтэц, үйлчилгээ, хоолтой холбоотой асуудлыг анхны тусгай нислэгээс ирсэн цагаас хойш онцолж байгаа бөгөөд үүний дагуу хяналт шалгалт хийж, тухай бүр зөрчлийг таслан зогсоосон үйл баримт ховор байгааг онцолжээ.

Судлаачид дүгнэхдээ дотооддоо иргэдийн эрхийг хамгаалан сахихаас гадна гадаад орнуудад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, хүний эрхийг нь хангаж ажиллах явдал дутагдалтай байгааг иргэдийн ялгаатай нөхцөл байдал ялангуяа тусгай хэрэгцээтэй болон эмзэг бүлгийн хүмүүсийн онцлогийг харгалзан үзэж, иргэдэд тэгш үйлчилгээгээр хангах, мэдээллийн ил тод байдлыг сахин ажиллахын чухлыг онцолж байгаа юм.

КОВИД 19 ба Хууль тогтоох байгууллагын хэвийн ажиллагаа

Дэлхийн олон орны парламентууд үйл ажиллагаагаа түр завсарлах, эсвэл цөөн хүнтэй хуралдах, саналаа төлөөлөгчөөр дамжуулан өгөх зэрэг дэгийн өөрчлөлт хийж, ихэвчлэн цахим хуралдаан горимоор ажиллаж эхэлсэн. Ер нь иргэдээс шууд сонгогдон байгуулагддаг төлөөллийн байгууллагын хувьд парламент нь Засгийн үйл ажиллагааны бодлого, төсвийг батлахаас гадна, онцгой шуурхай нөхцөл байдалд Засгийн газрын явуулж буй арга хэмжээнд нь урьдчилаад, явцын болон сүүлд нь хяналт, шалгалт хийх чухал үүрэгтэй. Энэ утгаараа олон улсын ажиглагчид парламентын байнгын ажиллагаа бол ардчилал, хүний эрхийг хангахад чухал үүрэгтэй механизм гэж үзэж, үйл ажиллагаагаа тасалдуулалгүй явуулж буй парламентыг сайшааж байгаа юм.

Монгол Улсын их хурал ч гэсэн энэ жишгийн дагуу, үйл ажиллагаагаа тасалдуулалгүй шуурхай үргэлжлүүлж байгаа билээ. 2020 оны 4 сарын 6-нд УИХ-ын ээлжит чуулган эхэлж, эхний хуралдаанаар дэгийн тухай хуулинд өөрчлөлт оруулж, цахимаар хуралдах болон олон танхим цөөн хүний тоогоор сууж цахимаар хуралдах журмыг баталсан юм. Харин УИХ-ын шинэ сонгуулиар бүрэлдсэн шинэ гишүүд энгийн горимоор хуралдаж байсан боловч 11 сарын дундаас эхлэн бүрэн цахим хэлбэрээр хуралдаж эхэлсэн юм. Сая 2020 оны 12 сарын эхээр Парламент бүрэн цахим хэлбэрээс хагас цахим дэг рүү шилжиж, гишүүд төрийн ордонд цуглах боловч 5 танхимаас цахимаар хуралдах, хоорондын зай барих зарчмаар хуралдаж эхлээд байна.

Монгол дахь Азийн сангийн суурин төлөөлөгч Марк Көниг, УИХ-ын хаврын чуулган эхлэхдээ дэгдээ өөрчлөлт оруулж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн. Парламентын үйл ажиллагаа ийнхүү хэвийн явагдаж эхлэх нь хэд хэдэн ач холбогдолтой гэж дүгнэжээ. Үүнд:

- Нэгт, аюулгүй үйл ажиллагаа явуулах Засгийн газрын олон талт ажиллагааны нэг хэсэг бөгөөд маск болон зай барих нь амин чухал бөгөөд үр дүнтэй болох тухай ойлголтыг улам бэхжүүлж өгсөн

- Хоёрдугаарт, хямралын үед парламент хуралдаж цар тахалтай холбоотой шийдвэр, хууль тогтоомж гаргах боломжийг олгож байгаа юм. Мөн түүнчлэн, цар тахлын аюул тулгараад байсан ч гэсэн Монголын цэцэглэн хөгжиж буй ардчилсан уламжлалыг тасалдуулалгүй үргэлжлүүлж байгаа юм” гэж дүгнэсэн байна.

Парламентын шинэ дэгээр гишүүд биеэр парламентын танхимд хүрэлцэн ирэх боловч өөр өөр хурлын танхимд хуваагдан орж, 1.5 метрийн зайтай суухаар зохицуулсан. Ингээд танхимууд хоорондоо холбогдох видео хурлын төхөөрөмжийг танхим бүрт суулгасан бөгөөд эндээс шууд олон нийтэд нэвтрүүлэх боломжийг хангасан. Саналыг тусгай санал авах төхөөрөмж болон гар өргөх замаар хурааж байгаа юм. Энэ нь дэгд өөрчлөлт оруулахаас гадна, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт шаардлагатайгаас гадна хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийн оролцоог зохицуулж өгсөн юм. Ялангуяа, хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг тусгай заасан бүсэд байршуулж, хурлын засвараар гишүүд болон хэвлэлийн төлөөлөгчид тусгай бүсэд очиж мэдээлэл өгч байсан юм.



Үндсэн хуулийн цэцийн дарга, УИХ-аас томилогддог агентлагийн дарга нар, Дипломат төлөөлөгчдийн газрын дарга нар Улсын их хурлын чуулганы нээлтэд оролцож буй байдал.

КОВИД 19 ба Хэвлэл мэдээлэл

2020 оны 5 сард Засгийн газар Ковид-19 тахлын талаар хуурамч мэдээлэл тараасан байгууллага, хувь хүмүүст хуулийн арга хэмжээ авна гэж сануулсан. Ингэснэр Европын сэтгүүлзүйн ажиглагч байгууллагаас энэхүү сануулга нь сэтгүүлчид илүү болгоомжтой байж, өөрсдөдөө хяналт, нягтралыг сайжруулж, Засгийн газрын эх сурвалжийг гол сурвалжаа болгоход нөлөөлснөөс гадна Засгийн газрыг шүүмжлэх хандлага нь буурсан гэж дүгнэсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын алба, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэн харьяатын албан хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэлд хяналт тавьж ажиллаж байгаа юм. Мөн олон нийтийн зүгээс ч гэсэн хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээллийг илрүүлж, эх сурвалжийг мэдээллийг уриалсан юм.

Зөрчлийн тухай хуулийн дагуу хуурамч мэдээ түгээсэн хувь хүмүүст 150 000 төгрөгөөр торгох бөгөөд байгууллагыг 1.5 сая төгрөгөөр торгох аж. Харин Эрүүгийн гэмт хэргийн тухай хуулиар 450,000-1,300,000 төгрөгөөр торгох эсвэл 1-3 сарын нийгэмд тустай хөдөлмөр хийлгэх болон шоронд хорихоор заасан байгаа ажээ. 2020 оны 3 сарын 25-ны байдлаар гэхэд л МОНЦАМЭ Агентлагийн мэдээлснээр хуурамч мэдээлэл түгээсэнтэй холбоотой 25 хэргийг цагдаагийн газар шалгаж байсан байна. Харин news.mn мэдээллийн сайтын мэдээлснээ 3 сарын 30-ны байдлаар 8 хүнийг хуурамч мэдээлэл тараасан хэргээр шийтгэсэн байна .

Иймд хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчид үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтлан ажиллаж байна гэж үзэж болно. Нэгдүгээрт, зөвхөн албаны эх сурвалжаас авсан мэдээллийг хэвлэн нийтлэх. Засгийн газрын албан ёсны хэвлэлийн хурал, мэдээлэл, төлөөлөгчдийн мэдээллийг эх үндэс болгож мэдээлэл хийх хандлага зонхилж байна. Ялангуяа, Эрүүл мэндийн яам, Засгийн газрын хэвлэл мэдээллийн алба, Улсын онцгой комисс, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага мөн онцгой комиссын салбар зөвлөлийн дарга нар, холбогдох захиргааны нэгжийн засаг дарга нар зэрэг болно. Хоёрдугаарт, ийнхүү албан эх сурвалжид төвлөрөн мэдээлэл явуулж байгаа нь сэтгүүлчид иймэрхүү эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөхцөл байдалд ажиллаж байсан туршлага байхгүйтэй холбоотой. Засгийн газар шуурхай арга хэмжээ авч дотоодод цар тахлын тохиолдол гараагүй эхэн үедээ засгийн газрын нэр хүнд харьцангуй өндөр байсан нь УИХ-ын болон орон нутгийн сонгуульд эрх баригч нам амжилттай оролцоход мөн нөлөөлсөн гэж үзэж болно. Иймд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээллээ нягтлах, олон нийтийн сүлжээгээр гарч буй мэдээлэлд нягтлал, шүүлтүүртэй хандаж байсан юм. Үүнд мэдээж Засгийн газраас өгсөн сануулга, анхааруулга нөлөөлсөн нь дамжиггүй юм. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн чиглэлээр ажилладаг Хэвлэлийн хүрээлэн төрийн бус байгууллагаас ийм эрүүл мэндийн онцгой байдлын үед хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээлэл түгээхдээ баримтлах гарын авлага гаргасан. Гуравдугаарт, Засгийн газраас өгсөн анхааруулга, сануулгын дагуу хууль сахиулах байгууллагууд Зөрчлийн тухай болон Эрүүгийн гэмт хэргийн тухай хуулийн дагуу хуурамч мэдээ тараасан хувь хүмүүс, байгууллагуудад арга хэмжээ авч эхэлсэн нь хуурамч мэдээлэлд өндөржүүлсэн хяналт тавигдаж эхэлсний шинж юм.

Харин Засгийн газраас Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж буй заалтад худалд мэдээлэл тараасан бол 80 хүртэлх сая төгрөгөөр торгож, 1-5 жилийн ял эдлүүлэх хуулийн төсөл бэлтгээд байгаа ажээ. Энэ нь худал мэдээ тараах нь бусдын нэр хүндэд халдсан тохиолдолд энэ зүйл ангиар эрүүгийн хуулиар шийтгэх боломжтой болгосны зэрэгцээ, хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгаж байгаа аж. Энэ талаар Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл төрийн бус байгууллагаас эсэргүүцсэн мэдэгдэл гаргаад байгаа юм (Доорх зургийг үзнэ үү).

Энэхүү хуулийн өөрчлөлтөөр далимдуулан эрх мэдэлтнүүд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг боомилох гэсэн оролдлого гэж үзэж байгаа аж. Уг төслийг УИХ-ын чуулганы 2021 оны 1 сарын хуралдаанаар хэлэлцэхээр зэхэж байгаа юм байна.

Мөн Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын Телевизээр нэвтрүүлэхтэй холбогдуулан Өргөн нэвтрүүлгийн голлох телевизийн сувгаар теле хичээлүүд орж байгаа нь агуулгын цагт боловсролын агуулга нэлээд нэмэгдсэн хэмжээгээр гарч эхэлсэн юм.

Бүрэн хөл хорионы улмаас бизнесийн салбарууд ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид хамгийн ихээр орлогогүй болж байгаа бөгөөд хүн амын ядуу, эмзэг хэсэгт хамгийн хүчтэй нөлөөлж байгаа юм. Энэ нөхцөл байдлыг харгалзан үзэж Засгийн газраас 2020 оны 12 сарын 1-ээс 2021 оны 7 сарын 1 хүртэлх бүх айл өрх болон жижиг дунд бизнесийн цахилгаан, дулаан, усны хэрэглээний зардлыг төрөөс хариуцаж, зардлыг нь төрийн өмчит үйлдвэрийн газраас гаргахаар шийдвэрлэснийг мэдэгдсэн. Хэдий энэ нь олны талархлыг хүлээж, эдгээр хэрэглээнд зарцуулах зардлыг өргөн хэрэглээнд шилжүүлж, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлж буй боловч, цахилгааны, усны зүй бус хэрэглээ газар авбал, эрчим хүчний хүчин чадал даац хэтрүүлэх, техник төхөөрөмжийн аюулгүй болон найдвартай ажиллагаанд хүндрэл үүсгэх эрсдэлтэй юм.



МЭДЭГДЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, албан ёсны цахим хуудастаа 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байршуулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 13.14 " Худал мэдээлэл тараах" заалтыг өөрчилж, хэвлэлийн болон иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүхий л талаар хянан цагдах, хягаарлан боомлохоор тусгаоныг Засгийн газрын бодлого хэмээн үзэж, эрс өсөргүүцэж байна.

Уг төсөл "илтэд худал мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн мэдээллийн сүлжээний хэрэгсэл ашиглан тараасан, эсхүл илтэд худал мэдээлэл болохыг мэдвэр байж түгээсэн бол" торгуулах, зөрчих эрхээ хасуулах, улмаар тав хүртэлх жилээр хоригдох мэт шийтгэлтэй байхаар тусгасан нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл төдийгүй нийгмийн сүлжээнд иргэдийнхээ үзэл бодолд цэнхур тогтоож, адийн засгийн аргаар боомлох, ял шийтгэлээр айлган сүрдүүлэхийг санаархаж буй хэрэг юм.


Эрх баригчид, албан тушаалтнуудын үзэл суртал, таалал, хүсэл зорилгод үл нийцэх өөр үзэл бодол, байр суурь илэрхийлсэн иргэн, сэтгүүлч хэн бүхнийг хэвээ, хөн шалган тогтоож, кэрхэн нотлох нь үл ойлгогдох "илтэд худал мэдээлэл" гэх калжавчин дор Эрүүгийн гэмт хэргэгэн болгох гэж буй нь туйлаас харамсалтай.

Алдар нэр, албан тушаалын нэр хүндийн гэх асуудлын ард ихэвчлэн төрийн өндөр албан тушаалтан, эрх мэдэлтний ашиг сонирхол, авилга, албан тушаалын гэмт хэрэг, томоохон хулгай, хуйсандан зэрэг хууль бус зүйлс нуугдаж байдаг билээ. Энэ нь чухамдаа нийтийн сайн сайхан, тэгш эрх, шударга ёс, боломжийг булааж, нийгмээ өвчлүүлэх тавчишгүй үзэгдлүүд бөгөөд эдгээрийг илчлэх, мэдээлэх, шүгэл үлээх, тэмцэх, өөрчлөх бүхий л арга замыг хаан боогдуулах өюул дагуулах юм.

Бидний сөнгөсөн Ардчилсан нийгмийн амьн сүнс болох иргэний үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг Эрүүгийн куулиар булаан авах гэсэн өнөжүү санаархлаа хэрэгжүүлэхийн тулд "өнцгэй нөхцөл байдал", "цар тахал" зэргээр далайлган иргэд, сэтгүүлчдийн амыг үдэх гэсэн башир арга мэхтэй бид эвлэрэхгүй. Энэ нь Монголын ардчилал, түүний үнэт зүйлд халгдаж буй хэрэг хэмээн үзэж эрс буруушааж байна.

Монгол Улсын иргэний үг хэлэх, хэвлэл нийтлэх, үзэл бодолтой байх эрх чөлөө хийгээд хэвлэлийн эрх чөлөө, хараат бус байдалд халдах аливаа үйлдэл, санаархлын эсрэг хэвлэл мэдээллийн салбарынхан бид тууштай тэмцэхээ мэдэгдэж байна.

МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧДИЙН НЭГДСЭН ЭВЛЭЛ



2020 оны 12 дугаар сарын 11

Эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992/№1
- Монгол Улсын Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоол. 2020 оны 11-р сарын 11-ний өдөр, Дугаар 178
- Т. Түмэнжаргал, Г. Эрдэнэбаяр “Монгол Улсын Сонгуулийн Хуулийн өөрчлөлт: Хэрэгжилт, Боловсронгуй болгох асуудал.” Политологи №18 (534), 2020: 94-116
- <https://www.legalinfo.mn/law/details/15081?lawid=15081>
- <https://nema.gov.mn/wpcontent/uploads/2020/02/%D0%A3%D0%9E%D0%9A-%D1%8B%D0%BD-%D0%B4%D0%B0%D1%80%D0%B3%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%88%D0%B0%D0%B0%D0%BB%E2%84%9604.pdf>
- <https://www.legalinfo.mn/law/details/12458?lawid=12458>
- <https://www.controlrisks.com/jp/our-thinking/japanese/covid-19-uncertainty>
- <http://www.mec.mn/?p=830>
- <https://www.legalinfo.mn/law/details/15081?lawid=15081>
- <https://nema.gov.mn/wpcontent/uploads/2020/02/%D0%A3%D0%9E%D0%9A-%D1%8B%D0%BD-%D0%B4%D0%B0%D1%80%D0%B3%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%88%D0%B0%D0%B0%D0%BB%E2%84%9604.pdf>
- <https://www.legalinfo.mn/law/details/12458?lawid=12458>
- <https://www.nso.mn/content/2396#.X-DfVy1h1p9>
- https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=4_3
- <https://www.imf.org/en/Countries/MNG>
- International Institute for Democracy and Electoral Assistance, 2020. Global Monitor of COVID-19’s impact on Democracy and Human Rights <https://www.idea.int/gsod-indices/#/indices/countries-regions-profile?rsc=%5B999%5D&covid19=1>
- <https://ikon.mn/n/1xyt> on 23.07.2020
- <https://covid19.mohs.mn/p/эрүүл-мэндийн-яаманд-хандивласан-бэлэн-болон-шилжүүлгээр-орж-ирсэн-мөнгөн-дүнгийн-тайлан-202002-21-20200520-ны-байдлаар/22/>
- <https://www.zasag.mn/news/view/24815>
- <https://www.zasag.mn/news/view/24815>
- Монгол Улсын шинжлэх ухааны академийн олон улсын харилцааны хүрээлэн.2020. “ковид-19”: олон улсын нөхцөл байдал, сорилт, үр дагавар, хандлага /2020 оны 4 дүгээр сарын байдлаар/
- <https://www.ft.com/content/19d90308-6858-11ea-a3c9-1fe6fedcca75>
- <https://www.idea.int/gsod-indices/#/indices/countries-regions-profile?rsc=%5B712%5D&covid19=1>
- <https://www.idea.int/news-media/multimedia-reports/global-overview-covid-19-impact-elections>
- http://www.academy.edu.mn/content/pandemics-election-mongolia-urtnasan/#_ftn9
- http://www.academy.edu.mn/content/pandemics-election-mongolia-urtnasan/#_ftn9
- <https://www.sanal.mn/>
- http://www.academy.edu.mn/content/pandemics-democracy-altanchimeg/#_ftn22
- <https://www.legalinfo.mn/law/details/1271?lawid=1271>
- <https://www.legalinfo.mn/law/details/1257>
- https://www.forum.mn/res_mat/2020/OSF_COVID-19%20and%20Human%20Rights_3.pdf
- <http://www.academy.edu.mn/content/pandemics-human-rights-violation-mongolia/>
- https://www.forum.mn/res_mat/2020/OSF_COVID-19%20and%20Human%20Rights_4.pdf
- <https://asiafoundation.org/2020/06/24/mongolias-lessons-on-democracy-during-a-pandemic/>
- <https://en.ejo.ch/ethics-quality/mongolia-coronavirus-and-the-media>
- <https://news.mn/en/791544/>
- <https://cmj.mn/89>

Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдал, үзүүлэх нөлөө, хариу арга хэмжээний саналууд

Зохиогчид:

- Б. Эрдэнэбат PhD
- Б. Соёлмаа PhD



Photo credit: David Bonazzi (Bologna, Italy)

Оршил

Дэлхий нийтээрээ нүүр тулаад буй Ковид-19 цар тахал өнөөдөр дэлхийн улсуудад эрүүл мэнд, эдийн засаг хоёрын аль алиныг зэрэг хамгаалах баланстай бодлогын хувилбарыг олох гэсэн тун хүнд сорилтыг тулгаж байна. Энэ байдал нь аливаа бодлогыг улс төрийн хувьд тогтворгүй болгоход мөн нөлөөлж байна (Eichenbaum, 2020).

Түүнчлэн, цар тахлын нөхцөл байдлыг тодорхойлоход шаардлагатай олон чухал зүйлүүд тодорхойгүй байгаа үед нөхцөл байдалд дүгнэлт өгөх нь эрт байна (Jacob Glazier, 2020). Тухайлбал, вакцин гараад эхний улсууд захиалаад, хэрэглээд эхэлж байх үеэр уг вирусийн шинэ төрөл бий болж буй тухай мэдээнүүд гарч эхэллээ. Тестлэх-мөшгөх (testing-tracing) стратеги хэрэгжүүлснээр цар тахлыг хохирол багатай даван туулж буй хэмээн тооцогдож байсан цөөхөн улсуудын нэг Өмнөд Солонгост өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байсан хатуу хөл хорионы арга хэмжээ авах шаардлагатай болж магадгүй тухай яригдаж эхлээд байна.


Нөгөө талаас тестлэх-мөшгөр стратегийг хэрэгжүүлэхдээ халдвар эерэг гарсан иргэдийг тусгаарлах ажлыг маш чанд зохион байгуулаагүй үед тестлэх нь бүр аюултай ч байж болно. Учир нь ёс суртахууны аюул (moral hazard) ёсоор нэгэнт халдвар авснаа мэдсэн хүмүүс халдвар хамгааллын дэглэм баримтлах нь төстийн үр дүнгээ мэдээгүй үеийнхээс суларч, халдвараас сэргийлэх авир нь өөрчлөгдөж болно.

Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гэнэтийн чанд хөл хорио нь түүхэнд маань анх удаа болж байгаа бөгөөд энэ нь ямар үр дагаварт хүргэх талаар үндсэндээ бид мэдээлэлгүй байна. Эдийн засгийн бодлогын сонголтууд, боломжит үр дүнг хэлэлцэж эхлэхэд тодорхой тоо мэдээлэл, онолын суурь мэдлэг нэн ихээр дутагдаж байгаа билээ. Яаралтай харцу үйлдэл үзүүлэх ёстой болоод буй ийм үед эдийн засгийн бодит нөхцөл байдалдаа сайтар суурилан онол, зарчмуудаа зохистойгоор ашиглах нь зүйтэй бизээ.

Энэхүү ажил маань үндсэн 5 хэсэгтэй. Эхний хэсэгт Монгол улсын макро эдийн засгийн нөхцөл байдлыг танилцуулна. Удаах хэсэгт цар тахалтай холбоотойгоор хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг хэрхэн ойлгож буйгаа, түүний дараа цар тахлын нөхцөл байдал болон сорилтыг харьцангуй амжилттай даван туулж буй улсуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өөрийн улстай харьцуулсан. 5-р хэсэгт дүгнэнэ.


Макро эдийн засгийн нөхцөл байдал

Онолын хувьд энэ цар тахал нийт эрэлт болон нийт нийлүүлэлтийн талд аль алинд нь сөрөг цохилт үзүүлж байгаа бөгөөд яг ямар хэмжээний үр дагаварт урт болон богино хугацаанд хүргэхийг тооцоолоход өгөгдөл тун хомс байна.



Зураг 1. 2010 оны үеээрх Монгол улсын ДНБ, 2000 оны 1-р улирлаас 2020 оны 3-р улирал (тэрбум төгрөгөөр).


Нийлүүлэлтийн талын нөлөө нь ажил хийж байгаа хүмүүсийг цар тахлын эрсдэлд хүргэж буйгаас үүднэ. Энэ нь хүмүүс уг эрсдэлээс зайлсхийн, хөдөлмөрийн нийлүүлэлтээ хумихад хүргэнэ. Хөдөлмөрийн орлогын бууралтаа капиталын орлого, тухайлбал хадгаламжийн хүү, хувьцааны өгөөж мэтээс нөхөхийг оролдоно. Хэрэглээ ч мөн хүмүүсийг халдвар авах эрсдэлд оруулах учир үүнээс зайлсхийхийн тулд, мөн капиталын хэмжээгээ өсгөхийн тулд хэрэглээний эрэлтээ багасгана. Энэ хоёр хүчин зүйлс хамтарч тун тэсвэртэй, ужиг хямралд хүргэх аюултай. Ямар нэгэн хөл хорио тогтоогоогүй байсан ч ийм хямрал болж байгааг дэмжсэн эмпирик нотолгоонууд гарч эхлээд байна (Hendren & Steiner, 2020; Goolsbee & Syverson, 2020).



Зураг 2. Монгол Улсын бодит ДНБ, эдийн засгийн салбаруудаарх эрэмбэ (тэрбум төгрөгөөр).


Хэдийгээр Ковид-19, түүнтэй холбоотой хөл хорио нь Монгол Улсын ДНБ-ий уналтын яг хэдэн хувийг тайлбарлаж байгааг тогтооход эрт боловч Зураг 1-ээс Монгол Улсын бодит ДНБ-ий төвшин энэ оны 1-р улиралд 2017 оны 3-р улирлынхаас доогуур төвшинд хүрсний гол шалтгаан нь хөл хорио гэдэгтэй маргах боломжгүй бизээ. Энэхүү уналт эдийн засгийн салбаруудаар нэн ялгаатай байгааг бодлогын арга хэмжээндээ тусгах ёстойг Зураг 2-т харуулж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал түүхий эдийн эрэлтийг улам бууруулсан, хил хаагдсантай холбоотойгоор уул уурхайн салбар, үүнтэй болон хөл хориотой холбоотойгоор тээвэр, агуулах, боловсруулахын үйл ажиллагаанд нэн сөрөг нөлөө үзүүлсэн. Улмаар энэ нь цар тахлаас өмнө уналтад ороод байсан бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээний салбарт улам бүр нэрмээс болоод байна. Харин хөдөө аж ахуй, дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарууд цар тахалд харьцангуй мэдрэмжгүй буюу тэсвэртэй байна.



Зураг 3. Хэрэглээний үнийн индекс ба түүний урт хугацааны чиг хандлага .

Зураг 4-өөс цар тахлаас үүдэлтэй хөл хорио нь монгол улсын 2, 4, 7 дахь том ажил олгогчид болох бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр ба агуулахын салбарт ажиллагчдад нэн хүндээр тусахаар байна. Энэ нь Засгийн газраас хэрэгжүүлэх өрхүүд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлогууд бүх нийтийг хамрахаас илүүтэй, зорилтот бүлэгт чиглэсэн, уян хатан байх шаардлагатайг харуулж байна.




Зураг 5. Сарын дундаж бодит цалингийн эрэмбэ (2020.III улирлын сая ₮) .

Учир нь орлогын хувьд хүнд байдалд орсон бүлгүүдэд чиглэсэн төсвийн дэмжлэг нь эргээд эдийн засгийн эргэлтэндээ хурдан орж, хэрэглээг дэмжиж, эрэлтийн талын сөрөг нөлөөг сааруулах сайн талтай.

Иймд хүүхдийн мөнгө, хүн амын орлогын албан татвар, НДШ-ээр дамжуулан нийтийг хамруулсан, мохоо, үр ашиггүй, цамаан дэмжлэг үзүүлж байгаа өнөөдрийн байдлаасаа татгалзаж, цар тахал хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй, санхүүгийн боломж хязгаарлагдмал үед эдгээр уналтад ороод байгаа салбарууд руу дэмжлэгээ чиглүүлэх хэрэгтэй байна. Хүүхдийн мөнгийг аль болох зөвхөн эдгээр салбарт хувиараа бизнес эрхэлдэг, аж ахуйн нэгжүүдэд ажиллагсад, мөн ажилгүйдлийн даатгал болон татварын дансаар нь дамжуулан буцаан олговол (өөрөөр хэлбэл сөрөг орлогын татварын хувь нэвтрүүлбэл) илүү үр ашигтай, эзнээ олсон байхаар байна. Ийнхүү зорилтот бүлгүүд рүү төсвийн дэмжлэгийг чиглүүлэх нь 50 мянга орчим өрхийн 250 мянган хүнд хүнсний талон тарааж байгаагаа таслалгүй удаан үргэлжлүүлэхэд ч дэмтэй юм.


Эдийн засгийн хүндрэл ажиллагчдын цалинд тусгалаа олж эхлээгүй байгааг, бүр инфляцын төвшин буурсантай холбоотойгоор бодитоор өссөнийг Зураг 5-аас харж болно. Хэдийгээр энэ нь иргэдийн орлого буураагүй, сайн дүр зураг мэт боловч, нөгөө талаар энэ нь эдийн засаг унаж байгаа үед хөдөлмөрийн зах зээлийн уян хатан бус байдал, цаашид энэхүү хөшүүн байдал нь ажилгүйдэл, хөдөлмөрийн дутуу ашиглалтад хүргэж болох аюулыг мөн илтгэж байна.



Зураг 6. Ажиллах хүчний оролцооны түвшний эрэмбэ, насны бүлгээр.

Монгол улсын ажиллах хүчний оролцооны төвшин 2020 оны 3-р улирлын байдлаар 56.1% байна (зураг 6). Дэлхийн дундаж нь 60.5% бөгөөд нийт 195 улсаас шашин, уламжлал, болон бусад шалтгааны улмаас эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо доогуур байдаг 45 улсынхаас л илүү өндөр гэсэн үг юм. Хэдийгээр тодорхой чиг хандлагыг албан ёсоор тогтооход хангалттай өгөгдөл бүрэлдээгүй байгаа ч гэр бүл авч явах ид насны 40-49 насныхны ажиллах хүчний оролцооны төвшин 80 орчим хувь руу орж ирж байгаа нь, 55-59 насныхны оролцоо 25-29 настнуудынхаас давж гарч буй нь анхаарууштай асуудал юм.

Гэнэтийн эдийн засгийн уналт нь гэрээс ажиллах боломж нь боловсрол, төрийн удирдлагын салбараас харьцангуй хязгаарлагдмал хувийн секторынхон, хөдөлмөрийн зах зээлийн эмзэг хэсгүүдэд, тухайлбал, харьцангуй бага цалинтай бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, мөн боловсролын төвшин доогуур, ажлын туршлага хомс, бага цалинтай ажиллагчдад хамгийн хүндээр тусч байгаа бөгөөд орлого, боломжийн ялгааг улам бүр нэмэгдүүлж, хувийн сектороос дайжих аюулд хүргэхээр байна.



Зураг 7. Ажилгүйдлийн түвшний эрэмбэ, насны бүлгээр.

Эдийн засгийн уналтын үед хөдөлмөрийн зах зээл дээр харьцангуй шинэ, туршлага багатай, нийгмийн сүлжээ муутай залуу ажиллагсад түрүүлж халагдах, цалин буурах, ажлын нөхцөл байдал нь муудах хандлагатай байдаг. Мөн Raatum & Røed (2006), Kahn (2010), Genda et al. (2010), Oreopolous et al. (2012), Andrews et al. (2020), Rothstein (2020) хямралын үеэр хөдөлмөрийн гараагаа эхлэх нь сорвижилт (scarring) хэмээх нөлөөнөөс болж 10-аад жилийн турш бага цалинтай байж, нэг ажлын байран дээрх хугацаа нь илүү богино байдгийг тогтоосон байдаг.

Хэдийгээр ижил төрлийн судалгаа одоогоор Монголд хийгдээгүй байгаа ч залуусын ажилгүйдлийн төвшин нэн өндөр, ялангуяа 24-өөс дооших насныхных сүүлийн 2 улиралд огцом өсөж байгааг Зураг 7-аас харж болно. Иймд хөдөлмөрийн зах зээлийн бодлогын хүрээнд хөдөлмөрийн гараагаа дөнгөж эхэлж буй, нийгмийн хамгааллын системд хамрагдаж амжаагүй байгаа залуус болон ид гэр бүлээ тэтгэж байгаа насныхныг хамгаалах нь чухал юм. Нийгмийн хамгааллын тогтолцоогоор тэтгэвэр, тэтгэмж авч хамгаалагдах эрх нь нээгдсэн байх магадлалтай 60-64 насны 24124, 65-69 насны 9315, 70-аас дээш насны 5674 хүн хөдөлмөрийн зах зээл дээр ажиллаж байна.

2019 онд дотоодын их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийн тоо 28045 байсан бөгөөд эдгээр болон энэ жилийн төгсөгчдийг ажлын байраар хангах, дараагийн шатны сургалтанд үргэлжлүүлэн суралцуулах бодлогыг даруй боловсруулах шаардлагатай байна. Түүнчлэн, нэгэнтээ цахим хэлбэрийн сургалтыг дөрвөн сар шахам хугацаанд хэрэгжүүлээд буй туршлагатай болсон учраас гадаадын их сургуулиудад багшилж буй монгол эрдэмтдийг цахим хэлбэрээр багшлуулж эхлэх нь аж үйлдвэрийн IV хувьсгалыг нэвтрүүлж буй учир нэн өгөөжтэй. Ингэснээр төгсөлтийн дараах сургалтыг чанартай болгож, дээд боловсролын салбартаа дорвитой шинэчлэл хийх боломж бүрдэнэ.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ

Манай улсын хувьд Ковид-19 халдварын тархалтын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болоод халдвар тархсан байдал нь бусад улс орнуудтай харьцуулахад нэлээд онцлог байгааг дурдах нь зүйтэй. Үүнийг дараах гурван нөхцөл байдлаар багцлан дурдвал:


1. Шинэ төрлийн коронавирусын халдвар албан ёсоор бүртгэгдсэн 2019 оны 12 сарын 31-ний өдрийн дараахан буюу 2020 оны 1 сарын 1-нээс олон нийтэд энэ тухай мэдээлж эхэлсэн зургаан улсын нэг нь Монгол Улс байна. Мөн 2020 оны 1 сарын 22-ны өдрөөс БНХАУ-д нийтийг хамарсан үйл ажиллагааг цуцалж, мөн оны 1 сарын 26-ны өдрөөс бүтэн хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн. Харин манай улсын хувьд урд хөрштэй ижил хугацаанд хөл хорионы хатуу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь өнөөдрийн байдлаар халдвар багатай цөөн улсын нэг болоход нөлөөлсөн. Хэдийгээр халдварын тоо бага байлгасан амжилт нь эрүүл мэндийн салбарт үүсэх дарамтыг багасгаж чадсан хэдий ч эдийн засгийн өсөлтийг маш ихээр саарууллаа. Дэлхийн ихэнх улсуудын хувьд харьцангуй хожуу арга хэмжээ авсан нь халдварын тоог эрс өсгөж, эрүүл мэндийн салбарт нь асар их дарамт учруулсан хэдий ч эдийн засгийн өсөлт нь манай улстай харьцуулахад харьцангуй хожуу саарч эхэлсэн.

2. Нөгөө талаас манай улсад дотоодын халдварын тохиолдол 2020 оны 11 сарын 10-ны өдөр бүртгэгдсэн. Үүнээс өмнөх халдварууд дандаа гаднаас зөөвөрлөгдөн ирсэн тохиолдлууд байв. Иймээс яг одоогоор манай улсад ковид 19 халдварын нөхцөл байдал ямар байх талаар дүгнэлт өгөхөд эрт байна. Учир нь дэлхийн улсуудад халдварын төвшинг насны бүлгээр харахад өндөр настай хүмүүс илүү эрсдэл өндөртэй байгаа. Гэтэл манай улсын хувьд 2020 оны 11 сарын 22-ны байдлаар ДЭМБ-ын нөхцөл байдлын тайлангаас халдвар авагсдын насны тархалтын мэдээг харахад 15-24 насны бүлгийнхний халдварын төвшин хамгийн өндөр 65-аас дээш насны бүлгийнхний халдварын төвшин нэлээд бага байна (хүснэгт 1). Харин хүн амын тоо, өндөр настай эцэг эхээ гэртээ асардаг манайхтай ижил уламжлалтай өндөр хөгжилтэй улсын жишээ болгон авсан Израйл улсынхыг харвал 85-аас дээш насныхны дунд халдварын төвшин хамгийн өндөр байна. Энэхүү ялгаа нь манайд бүртгэгдсэн халдварын ихэнх нь зөөрлөгдсөнтэй холбоотой. Учир нь ид хөдөлмөрийн насны идэвхтэй, залуу хүмүүс гадаадад зорчих нь өндөр настай бүлэгтэй харьцуулахад их байдаг. Тиймээс яг одоогоор халдвар авсан хүмүүсийн дийлэнх нь залуу хүмүүс байгаа нь нас барах эрсдэлийг бага, мөн хүндрэх эрсдэлийг ч бага байлгаж байна. Харин нэгэнт дотоодод халдвар тархаад эхэлсэн учраас цаашид халдварын тархалт дэлхийн улсуудын жишгээр өрнөнө гэж хүлээвэл өндөр настай, суурь өвчтэй хүмүүс халдвар авах нь нэмэгдэж нас барах, хүндрэх эрсдэл өсөж магадгүй.

Хүснэгт 1. Халдварын түвшин, насны бүлгээр


Насны бүлэг	Монгол			Израйл		
	Хүн амд эзлэх хувь	Халдварын түвшин %	Нас баралтын түвшин	Хүн амд эзлэх хувь	Халдварын түвшин %	Нас баралтын түвшин
5-14	19.8	0.007	0.	18.	0.11	0.
15-24	14.	0.044	0.	15.	0.23	0.
25-34	17.7	0.025	0.	13.6	0.24	0.
35-44	14.4	0.018	0.	12.7	0.18	0.
45-54	11.	0.021	0.	10.2	0.22	0.
55-64	7.2	0.018	0.	8.6	0.22	1.
65+	4.1	0.013	0.	11.7	0.19-0.26	4-23

Эх үүсвэр: Монголын мэдээллийг *Mongolia Coronavirus Disease 2019 (COVID-19) Situation Report #28 As of 15 November 2020*, WHO тайлан болон статистик мэдээллийн www.1212.mn сайтаас зохих мэдээллийг авч тооцоолсон. Израйлыг мэдээллийг *Eckstein et al (2020)* судалгааны ажлаас шууд авч ашигласан.



Зураг 7. Төсвийн тэнцэл, ДНБ-д эзлэх хувь

3. Дэлхийн улсууд хөл хорионы үеэр зогсонги байдалд орсон эдийн засгаа дэмжих сангийн тэлэх бодлогуудыг хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд энэ жишгээр эдийн засгаа дэмжих бодлогыг 2020 оны 3 сараас эхлэн хэрэгжүүлсэн. Энэхүү төсвийн тэлэх бодлого нь зөвхөн богино хугацаанд хэрэгжих боломжтой. Гэтэл халдвар болон хөл хорионы дэглэм хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй байгаа нь ДНБ-д эзлэх төсвийн алдагдал 14%-д хүрсэн энэ үед тэлэх бодлогыг удаан хэрэгжүүлэх боломжийг улам хязгаарлаж байна (зураг 7). Мөн түүнчлэн, манай улсын гадаад өрийн дарамтыг тооцож үзвэл дэлхийн бусад улсуудтай харьцуулахад төсвийн хувьд бүр ч хүнд сорилтонд байна (зураг 8). Хатуу хөл хорионы арга хэмжээг эрт авч эхэлсэн нь энэхүү төсвийн дарамтыг улам нэмэгдүүлсэн.



Зураг 8. Гадаад өр, ДНБ-ий харьцаа

Амжилттай даван туулж буй улсуудын авч буй арга хэмжээг харьцуулах нь



Eckstein болон бусад судлаачдын 2020 оны судалгаанд дурдсанаар цар тахлын нөлөөг амжилттай даван туулж буй Тайвань, Өмнөд Солонгос болон Вьетнам улсуудын хувьд халдварын тархалтыг хурдан шуурхай арга хэмжээ авч амжилттай зогсоож чадахын зэрэгцээ эдийн засгаа хэвийн байлгаж чадсан байна. Манай улсын хувьд хэдийгээр халдварыг хэт тархаалгүй, дотооддоо халдвар гаргалтгүй 10 сар болсон хэдий ч эдгээр улсуудтай харьцуулахад эдийн засгийн хувьд маш их хохиролтой хэт хатуу арга хэмжээг удаан хугацаанд хэрэгжүүлээд байна.

Эдгээр улсуудын авч хэрэгжүүлсэн тестлэх-мөшгөх стратеги нь одоогоор эдийн засаг болон эрүүл мэндээ баланстай хамгаалж авч үлдэх оновчтой арга байж болох юм гэж эдийн засагчид болон нийтийн эрүүл мэндийн салбарын эрдэмтэд дүгнэж байна. 2020 оны III улирлын байдлаар Тайвань, Өмнөд Солонгос болон Вьетнамын ДНБ-ний өсөлт эерэг гараад байна. Тухайлбал *Trading Economics* компанийн сайтад мэдээлснээр энэ оны 3-р улирлын байдлаар Тайваны өсөлт 3.9%, Өмнөд Солонгосын өсөлт 2.1% байна.


Зураг 9-д Оксфордын их сургуулийн *Blavatnik School of Government* -с гаргаж буй ковид 19 халдварын эсрэг засгийн газруудын авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний (*stringency*) индексийн тоон мэдээллийг ашиглан Монгол Улсын Ковид цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээг бусад улсуудтай харьцуулж байна. Ингэхдээ Тайвань, Өмнөд Солонгос болон Вьетнам улсуудыг илүү онцгойлон авч үзэв.

Зураг 9-с харахад 2020 оны туршид манай улс бусадтай улсуудтай харьцуулахад харцу арга хэмжээний хувьд бүх шатны сургуулиудыг хаах, олон нийтийн үйл ажиллагааг хязгаарлах, хот хооронд зорчихыг хориглох болон гадаадаас ирэхэд хязгаарлалт тавьсан гэсэн үзүүлэлтээр нэлээд хатуу арга хэмжээ авчээ. Бусад үзүүлэлтүүдийн хувьд харьцангуй дундаж байна. Тухайлбал, бүх шатны сургуулийг хаасан өдрийн тоо бусад дэлхийн улсуудтай харьцуулахад нэлээд өндөр байна. Дэлхийн улсуудын хувьд сургууль хаасан дундаж өдөр нь 141 байна. Энэ тоо манай улсын хувьд 258 болж байна. Харин Өмнөд Солонгосын хувьд 113, Вьетнамын хувьд 153, Тайваны хувьд 23 өдөр байна. Олон нийтийн үйл ажиллагааг хязгаарласан өдрийн тоо манай улсын хувьд 2020 оны туршид нийтдээ 312 өдөр байна. Тайваны хувьд ямар нэг байдлаар олон нийтийн хамарсан үйл ажиллагааг хориглоогүй, Өмнөд Солонгосын хувьд 186 өдөр, Вьетнамын хувьд 190 өдөр байна. Монгол Улсын хувьд хот хоорондын хөдөлгөөний жилийн хугацаанд 208 өдөр тодорхой хэмжээнд хязгаарласан бол, Тайваны хувьд хориглоогүй, Өмнөд Солонгост 28 өдөр, Вьетнамын хувьд 184 өдөр байна. Харин Тайвань Улсын хувьд гадаадаас ирэхэд тодорхой хэмжээнд хязгаарлалт тавьсан өдрийн тоо 331, манай улсын хувьд 330, Өмнөд Солонгосын хувьд 151 өдөр, Вьетнамын хувьд 318 өдөр байна.


Нэн чухал хэрэглээний хүнс үйлдвэрлэгчид, худалдаалагчид, эм, эмнэлэг, түлш эрчим хүчний гэх мэт салбараас бусад салбарын үйл ажиллагааг хориглосон өдрийн тоо манай улсын хувьд 43 байгаа нь бусад улсуудтай харьцуулахад дундаж дээр байна. Энэ нь Тайваны хувьд огт хаагаагүй, Өмнөд Солонгосын хувьд 14 өдөр, Вьетнамын хувьд 84 өдөр байна. Бас нэг сонирхол татаж буй үзүүлэлт нь нийтийн тээврээр зорчиход тавих хязгаарлалт юм. Манай улс болон Өмнөд Солонгост ойролцоо буюу 14 болон 10 өдрүүд тус тус хязгаарласан байна. Харин Тайваны хувьд огт хязгаарлалт тавиагүй, Вьетнамын хувьд харин 126 өдөр хязгаарласан байна.







III. Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон өдрийн тоо



IV. Нийтийн тээврээр зорчихыг хязгаарласан өдрийн тоо







Зураг 9. Хариу арга хэмжээ авсан өдрийн тоо. Эх үүсвэр: Оксфордын их сургуулиас гаргаж буй хариу арга индексийн тоон мэдээллийг ашиглан гаргасан судлаачийн тооцоолол. Хэвтээ тэнхлэгээс доош (дээш) утгууд нь Монголоос цөөн (их) өдрүүдийг илтгэнэ.

Өөр нэг анхаарал татаж буй үзүүлэлт нь тухайн улсуудын засгийн газраас ажлаа алдсан болон ажилгүй байгаа иргэдэд орлогын дэмжлэг үзүүлсэн өдрийн тоо юм. Энэхүү үзүүлэлтийг тооцоходоо огт дэмжлэг үзүүлээгүй, цалингийн 50 хувиас бага дэмжлэг үзүүлсэн болон цалингийн 50 хувиас их дэмжлэг үзүүлсэн гэж гаргажээ. Дээрх 184 улсаас 151 улс ямар нэг хэмжээгээр, хамгийн багадаа цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогын дэмжлэгийг үзүүлжээ. Ажилгүй иргэдэд орлогын дэмжлэг үзүүлсэн өдрийн дундаж нь улсуудын хувьд 183 өдөр, хамгийн их нь Хонг-Конг улсын хувьд 298 өдөр байна (зураг 10, VIII хавтгай). Харин цалингийн 50 хувиас дээш хэмжээний дэмжлэг үзүүлсэн 66 улс байгаа бөгөөд ийм дэмжлэг үзүүлсэн өдрийн дундаж нь 73 өдөр байна. Швед улсын хувьд хамгийн их буюу 286 өдөр цалингийн 50 хувиас дээш хэмжээний дэмжлэгийг ажилгүй болсон иргэдэд үзүүлсэн байна. Швед улс саяхныг болтол ямар нэг хатуу арга хэмжээ огт авахгүй байсан гэдгийг бид мэднэ.

Манай улсын хувьд 2020 оны 3 сараас орлогын албан татвараас чөлөөлөх, үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжийн ажиллагсдад сарын 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэх, НДШ-ийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь цалингийн 50 хувиас бага гэсэн ангиллын дэмжлэгт орж байна. Ажилгүй иргэдэд үзүүлсэн дэмжлэгийг хэрэгжүүлсэн өдрийн тоо манай улсын хувьд 139 өдөр байна. Тайваны хувьд 242, Вьетнамын хувьд 250, Өмнөд Солонгосын хувьд 250 өдөр байна. Энэ гурван улсын хувьд мөн л дэмжлэгийн хэмжээ цалингийн 50 хувиас бага байжээ.

Дэлхийн улсууд эрүүл мэнд, эдийн засгийн энэхүү хямралаас улбаалан бий болж буй оюутан, сурагчдын хичээлийн хоцрогдолд мөн санаа зовж, анхаарлаа хандуулж байна. Эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл болох хүмүүн капитал энэхүү цар тахлын нөлөөгөөр нэлээд ихээр элэгдэх эрсдэл үүсээд байна. Учир нь сургуулийг танхимаар хичээллүүлэхгүй хааснаар энэ үеийн оюутан, сурагчдын хичээл сурлагад нэгдүгээрт хаасан хугацаагаар хичээл хоцрох, хоёрдугаарт өмнө сурсан мэдлэгээ мартаж, гуравдугаарт өрхийн орлого буурснаар сургуулиас завсардах гэсэн алдагдлууд үүснэ. Azevedo et al. (2020)-д дэлхийн 157 улсын тоон мэдээлэл ашиглан сургуулийг 3, 5 болон 7 сар хаасны улмаас сурлагын хоцрогдол болон эдийн засгийн алдагдлыг өөдрөг болон гутранги гэх мэт гурван төрлийн хувилбараар симуляци хийж тооцоолжээ. Тэдний тооцоолсноор дундаж оюутан амьдралынхаа туршид 6,472-25,680 доллартой тэнцэх хэмжээний алдагдал хүлээнэ гэсэн байна. Энэхүү алдагдал бага болон дундаж орлоготой орнуудын хувьд илүү өндөр талдаа байх магадлалтай гэж үзжээ.

Hanushek & Woessmann (2020) ЭЗХТЗ (OECD) орнуудын хувьд энэ үеийнхний сурлагын хоцрогдол нь тэдний ирээдүйн хөдөлмөрийн бүтээмж, орлогыг бууруулж, энэ нь ирэх зуун жилийн хугацаанд ДНБ-ийг жилийн 1.5%-аар багасгана гэж үзжээ. Одоохондоо улсууд зөвхөн өнөөгийн нөхцөл байдалд анхаараад, энэхүү сурлагын хоцрогдлын урт хугацааны нөлөөг тооцоолохгүй байгаа ажээ. Тэдний үзэж буйгаар энэхүү сурлагын хоцрогдол сургууль эргэж нээгдээд, 2019 оны байдалтайгаа байвал урт хугацаанд сөрөг үр дагавартай хэвээр байна. Харин эргэж нээгдэхдээ энэхүү хоцрогдлыг арилгах бодлого явуулбал сөрөг үр дагаврыг багасгаж чадна гэжээ.

Дүгнэлт хэлэлцүүлэг

Монгол Улсын хувьд 2019 оны 12 сарын 31-ны өдөр БНХАУ-д албан ёсоор бүртгэгдээд энэ оны 3 сараас эхлэн дэлхийн улс орнуудад асар хурдацтай тархаж, эрүүл мэнд, эдийн засгийн ихээхэн хохирол учруулаад буй Ковид-19 цар тахлын эсрэг хурдан арга хэмжээ авч, дотоодод халдварын тохиолдол гаргалгүй 10 сар барьж чадсан нь том амжилт гэдгийг дурдах нь зүйтэй.

Харин 11 сарын 10-ны өдөр дотоодод халдварын тохиолдол анх бүртгэгдсэнээс хойш тоо нь өссөөр байна. Энэ нь мөнгөөр хэмжигдэх болон хэмжигдэхгүй асар их зардлаар хамгаалж чадсан ажлын үр дүнг нэлээд буурууллаа. Энд үйл ажиллагааг нь багагүй хугацаагаар царцааснаас аж ахуйн нэгжүүдэд үүссэн доголдол, угаасаа маш их алдагдалтай байсан төсвөөс аж ахуйн нэгж, өрхүүдэд үзүүлсэн дэмжлэгийн зардал, гадаадад байсан олон монгол иргэдэд учруулсан төвөг чирэгдэл, сэтгэл санааны хохирол, бүх шатны сургуулийг хааснаар оюутан, сурагчдад бий болсон боловсролын хоцрогдол гээд олон зүйлийг дурдаж болно.

Одоо бид дотооддоо халдвар алдаагүй үед байснаас илүү тодорхой бус орчинд бодлого, зохицуулалтаа хийх ёстой болж байна. Ингэхдээ эрүүл мэндийн салбарын дэд бүтэц, хуулиа дээдлэх байдал (rule of law), институцийн чадавх, жишээ нь Транспаренси Интернэйшнл байгууллагын авилгатай тэмцэх чадварын хамгийн сүүлийн үнэлгээгээр 100-аас 35 оноо авч, 180 улсаас 106 дахь эрэмбэлэгдсэн байдал, төсвийн хяналт, сахилга батын төвшин зэрэг дотоодын нөхцөл байдлаа сайтар бодолцох хэрэгтэй.

Одоогоор эдийн засаг болон эрүүл мэндийн хувьд аль алиныг нь хохирол багатай даван туулсан Тайвань, Өмнөд Солонгос, Вьетнам улсуудын туршлагыг сайтар судалж тестлэх-мөшгөх-тусгаарлах стратегийг хэрэгжүүлэх боломжийг даруй судалж, шаардлагатай тоног төхөөрөмж, боловсон хүчин, дэд бүтцийг бэлтгэх нь оновчтой юм. Ингэхдээ өмнө дурдсан ёс суртахууны аюулыг тооцож үзэх нь чухал. Оксфордын их сургуулиас гаргасан хариу арга хэмжээний индексийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн үзүүлэлтүүдтэй хэр уялдаж байгааг илүү нарийн шинжлэн гаргах шаардлагатай байж болох юм. Тодруулбал, эдийн засгийн дэмжлэг нь өсөлтөнд хэрхэн нөлөөлж байгааг, бусад 8 төрлийн хатуу арга хэмжээний аль нь эдийн засгийн өсөлтийг илүү сааруулж буйг тодорхой судлах боломжтой.

Өрхүүд болон аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн эдийн засгийн дэмжих бодлогыг илүү зорилтот бүлэгт чиглүүлэн хэрэгжүүлэхэд анхаарах нь зохистой. Ингэхдээ бусад улсын туршлагаас суралцан, зомби компаниудыг аль болох дэмжихгүй байхаар, ажилгүйдлийн тэтгэмжийн тогтолцоог сайжруулж, уян хатан болгох хэрэгтэй байна. 2021-2022 онд 25-59 насныхны ажил эрхлэлтийг эхэлж хангах хөдөлмөрийн зах зээлийн бодлого хэрэгжүүлэх, их дээд сургууль, коллежийн бакалаврын төгсөгчдийг үргэлжлүүлэн суралцуулах бодлого баримтлах, цахим боловсролын чанарыг нь эрс сайжруулан, Дэлхийн хэмжээнд хүргэх шаардлагатай байна.

Монгол хүүхдүүдийн хувьд 2020 онд дэлхийн бусад орнуудтай харьцуулахад хичээлийн хоцрогдол илүү ихтэй байж болохыг анхааралдаа авах, ялангуяа орлого багатай өрхийн хүүхдүүдийн сурлагын хоцрогдлыг арилгах тал дээр тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Залуу үеийнхний ажлын байр, цаашдын хөгжилд болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлага, хөгжилд энэхүү цар тахал ямар нөлөө үзүүлэхийг судалж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг өрнүүлж, урт хугацаанд баримтлах бодлогын зөвлөмж боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн дундаж оюутан, сурагчийн хоцрогдлоос үүдэлтэй хувийн орлогын болон нийт эдийн засгийн алдагдлаас гадна боловсролын тэгш бус байдал даамжирч байгаа нь урт хугацаанд орлогын ялгаатай байдлыг нэмэгдүүнэ. Сурлагын хоцрогдлоос сэргийлж зайны сургалтыг ТВ болон цахимаар зохион байгуулж байгаа ч энэ нь орлого бага өрхийн хүүхдүүдэд тэр бүр хүрэх боломжгүй. Тиймээс цар тахлын дараа энэхүү хоцрогдлын ялгааг арилгахад анхаарах нь зайлшгүй чухал юм.

Ковид-19-ээс үүдэлтэй эдийн засгийн уналтыг Ковид-19-ийг дарж байж л зогсоох боломжтой. Гэвч энэхүү уналтыг сунжирсан хямрал болгочихгүйн тулд Засгийн газраас хэрэгжүүлсэн (хэрэгжүүлээгүй) аливаа арга хэмжээний шийдвэр гаргалтын процесс, түүнд ашиглагдсан өгөгдөл, загвар, боломжит хувилбарууд нь ил тод байхын ач холбогдол хэзээ хэзээнээс илүү чухал байна. Иргэд, аж ахуйн нэгжүүд хэн, хэзээ, яагаад ийм шийдвэрүүдийг гаргасныг сайтар ойлгосон үед л бид хамтын хүчээр энэ үеийг даван гарах болно.

Ашигласан материалууд

- Andrews, D., Deutscher, N., J. Hambur, & D. Hansell. 2020. *The career effects of labour market conditions at entry*. Australian Treasury Working Paper No. 2020-01
- Argente, David O., Chang-Tai Hsieh and Munseob Lee. 2020. *The Cost of privacy: Welfare effect of the disclosure of Covid-19 cases*, NBER Working Paper, 27220.
- Aum, Sangmin, Sang Yoon (Tim) Lee and Yongseok Shin. 2020a. *Inequality of fear and self-quarantine: Is there a trade-off between GDP and public health?*, NBER Working Paper, 27100.
- Aum, Sangmin, Sang Yoon (Tim) Lee and Yongseok Shin. 2020b. *Covid-19 doesn't need lockdowns to destroy jobs: the effect of local outbreaks in Korea*, NBER Working Paper, 27264.
- Azevedo P, Joao, Hasan A, Goldemberg D, Iqbal, S.A., Geven K, 2020. *Simulating the potential impacts of COVID-19 school closures on schooling and learning outcomes: a set of global estimates*, Conference Edition, 2020, World Bank Group.
- Card D, Cardoso, A. R., Heining, J. & Kline, P. 2018. *Firms and labour market inequality: Evidence and some theory*, *Journal of Labor Economics* 36(S1): 13-70.
- Genda, Y., Kondo, A. & Ohta, S. 2010. *Long-term effects of a recession at labor market entry in Japan and the United States*, *Journal of Human Resources* 45(1): 157-196.
- Chetty, Raj, John Friedman, Nathaniel Hendren, Michael Stepner, *The Economic Impacts of COVID-19: Evidence from a New Public Database Built Using Private Sector Data*.
- Zvi Eckstein, Benjamin Bental and Sergei Sumkin. 2020. *What can be learned from the economic policies of other countries in response to the Coronavirus pandemic? Lessons from the first wave*. *Israel Economic Review* 18(1), 33-46.
- Eichenbaum, Martin S., Sergio Rebelo and Mathias Trabandt. 2020a. *The Macroeconomics of epidemics*, NBER Working Paper, 26882.
- Eichenbaum, Martin S., Sergio Rebelo and Mathias Trabandt. 2020b. *The Macroeconomics of testing and quarantining*, NBER Working Paper, 27104.
- Goolsbee, Austan and Chad Syverson. 2020. *Fear, Lockdown, and Diversion: Comparing Drivers of Pandemic Economic Decline 2020*, NBER Working Paper 27432.

- Hamilton, J.D. 2018. *Why you should never use the Hodrick-Prescott filter*, *Review of Economics and Statistics* 100(5), 831-843
- Hanushek, A, E., Woessmann L, *The Economic impacts of learning issues*, OECD Report, 2020.
- Herzog-Stein, Alexander, Fabian Lindner and Simon Sturn. 2018. *The German employment miracle in the Great Recession: The significance and institutional foundations of temporary working-time reduction*, *Oxford Economic Papers* 70(1), 206–224.
- Hoffmann, Sandra, Ping Qin, Alan Krupnicka, Burmaajav Badrakh, Suvd Batbaatar, Enkhjargal Altangerel, Lodoysamba Sereeter. 2012. *The willingness to pay for mortality risk reductions in Mongolia*. *Resource and Energy Economics* 34, 493–513
- Jones, Callum J., Thomas Philippon and Venky Venkateswaran. 2020. *Optimal mitigation policies in a pandemic: Social distancing and working from home*, NBER Working Paper, 26984.
- Kahn, L B (2010), *The long-term labor market consequences of graduating from college in a bad economy*. *Labour Economics* 17(2): 303-316.
- Oreopoulos, P., T.von Wachter & Heisz, A. 2012. *The short- and long-term career effects of graduating in a recession*, *American Economic Journal: Applied Economics* 4(1): 1-29.
- Raaum, O. & K. Røed. 2006, *Do business cycle conditions at the time of labor market entry affect future employment prospects?* *Review of Economics and Statistics* 88(2). 193-210.
- Rothstein, J. 2020. *The Lost generation? Labor market outcomes for post Great Recession entrants*. NBER working paper, w27516
- Sax C, & Eddelbuettel D. 2018. *Seasonal adjustment by X-13ARIMA-SEATS in R*. *Journal of Statistical Software* 87(11), 1-17

ЗАРИМ УЛС ОРНЫ КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ТУРШЛАГА СУРГАМЖ, ЗӨВЛӨМЖ

Зохиогч:

• *Р. Нямдаваа МА*



УДИРТГАЛ

2020 онд дэлхий дахинд сүүлийн 100 орчим жилийн түүхэн дэх хамгийн аюулт цар тахал дэгдэж, дэлхийн улс орнууд Дэлхийн хоёрдугаар дайнаас хойших хамгийн хүнд сорилттойгоо тулгарлаа. Шинэ төрлийн коронавирусийн гаралтай Ковид-19 өвчний халдварын эхний томоохон голомт БНХАУ -ын Хубэй мужийн Ухань хотод үүссэнээс хойш дэлхийн бараг бүх улсад халдвар бүртгэгджээ.

Одоогоор дэлхийн 9 улсад Ковид-19 өвчний халдвар огт бүртгэгдээгүй байгаагийн 7 нь Номхон далайн арлын бичил улсууд байгаа бол үлдсэн хоёр нь БНАСАУ, Туркменистан гэсэн харьцангуй хаалттай дэглэмтэй улсууд байна.

Дэлхийн улс орнуудын цар тахалтай тэмцэх чиглэлд баримталсан бодлого болон, цар тахлын үеийн ерөнхий стратеги харилцан адилгүй байна. Улс орнуудын бодлого, стратеги, тэр хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ харилцан адилгүй байсныг тухайн улс орны удирдлагын бүтэц, чадавх, эрх зүйн зохицуулалт, эдийн засаг, техник технологийн хүчин чадал болон бодлого, үйл ажиллагаандаа удирдлага болгодог тэргүүлэх чиглэлээ хэрхэн тодорхойлсонтой нь холбон авч үзэж болох юм.

Түүнчлэн дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүс нутгаар нь ангилан авч үзвэл нэг бүс нутгийн орнуудын хэрэгжүүлсэн бодлого зарим талаараа нийтлэг, зарим талаараа ялгаатай байгаа нь ажиглагдаж байна.

Дэлхийн улс орнууд хөл хорио тогтоох, тусгаарлалтын журам мөрдүүлэх, хилээ нээх, хаахдаа ч харилцан адилгүй чиглэл баримталж, түүнийг дагаад цар тахлын үед амссан хохирол нь харилцан адилгүй байна.

Улмаар цар тахлын үед Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн нь улс төрийн уур амьсгал, олон улсын харилцаанд ч шууд нөлөө үзүүлснийг дурдах нь зүйтэй.

Энэхүү судалгаанд Ковид-19 цар тахлын үед дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон баримталсан бодлого, түүнээс үүдэн гарсан эерэг, сөрөг үр дагаврыг нэгтгэн дүгнэж, тодорхой зөвлөмж боловсруулахыг эрмэлзэж байна.

Судалгааг хийхдээ дэлхийн улс орнуудыг бүсчилсэн байдлаар ангилан үзэж цар тахлын үед нийтийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийн хүндрэлээс сэргийлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тусгахыг зорилоо.

Энэхүү судалгаанд дэлхийн улс орнуудыг цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзэхдээ 1) нийтээрээ харьцангуй амжилттай ажиллаж чадсан Ази, Номхон далайн орнууд, 2) цар тахлын улмаас хамгийн хүнд хохирол амсаад байгаа Умард, Төв, Өмнөд Америкийн орнууд болон 3) Европын орнууд гэсэн гурван үндсэн бүсийг онцлон авч үзлээ.

Чингэхдээ тухайн бүс нутаг тус бүрээс цар тахалтай амжилттай тэмцэж чадсан улс орнуудын эерэг жишээ туршлагыг ч, харьцангуй тааруу ажилласанд тооцогдож буй улс орнуудын зарим алдаа дутагдлыг ч багтааж, тодорхойлохыг оролдсон.

Мөн тухайн улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг авч үзэхдээ цар тахлын үед хамгийн хурцаар тавигдаж буй асуудлууд болох нийтийн эрүүл мэнд болон эдийн засгийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хэмээн ангилан авч үзсэн болно.

Судалгаанд эдгээр орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон тусгаснаас гадна зарим орны хэрэгжүүлсэн онцлох бодлого, арга хэмжээг дэлгэрүүлэн авч үзлээ.

КОВИД-19 ЦАР ТАХЛААС ҮҮДЭН ДЭЛХИЙ НИЙТЭД УЧИРЧ БУЙ СОРИЛТ

Дэлхий даяар шинэ төрлийн коронавирусийн гаралтай Ковид-19 цар тахал дэгдсэн цагаас хойш нийтдээ 76 сая халдвар бүртгэгдэж, үүнээс 1.7 сая орчим нь амиа алдаад байна. Гэхдээ олон хүн халдвар авсан ч ямар нэг шинж тэмдэг илрэлгүйгээр эдгэрч байгаагаас шалтгаалан нийт халдварын тоо хавьгүй өндөр байх боломжтой гэх таамаглал гарч буй бөгөөд энэ оны 10 дугаар сард ДЭМБ-аас гаргасан таамаглалаар дэлхийн нийт хүн амын 10 хүртэл хувь нь халдвар авсан байж болзошгүй гэж үзэж байна.

Энэхүү цар тахал нэн түрүүнд дэлхийн улс орнуудын нийтийн эрүүл мэндийн салбарт томоохон сорилтыг учрууллаа. Мөн цар тахлын тархцыг хянах, хязгаарлахын тулд тогтоосон хөл хорио, хязгаарлах арга хэмжээнээс үүдэн олон улс орны эдийн засагт хүнд цохилт учирлаа.

ОУВС-ийн сүүлийн тооцоогоор энэ онд дэлхийн эдийн засаг буюу дотоодын нийт бүтээгдэхүүн 4.4 хувиар ширгэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл энэ онд дэлхийн эдийн засагт 1930-аад оны "Их Хямрал"-аас хойших хамгийн хурдацтай уналт тохиож байна.

Сүүлийн саруудад гарч буй тоо баримтаас үзэхэд БНХАУ тэргүүтэй цар тахлыг амжилттай хянаж чадаж байгаа зарим улсын эдийн засаг өмнө нь тооцоолж байснаас илүү хурдан сэргэж байгаа ч дийлэнх улс орнуудын эдийн засаг сэргэхэд олон жилийн хугацаа шаардагдах магадлалтай байна. Зарим тооцооллоос үзэхэд зарим орны эдийн засаг бүрэн сэргэхэд 5 жил хүртэлх хугацаа шаардагдах магадлалтай байна.

Тэр дундаа цар тахал, хөл хорионоос шалтгаалан аялал жуулчлал, иргэний агаарын тээвэр тэргүүтэй тодорхой салбарууд онцгой хохирол амссан тул дэлхийн улс орнууд тухайн салбаруудыг бодлогоор дэмжих чиглэлийг нийтээрээ баримталж байна.

Мөн орчин цагийн түүхэнд тохиогоогүй аюулт цар тахал тохиож байгаа, эдийн засгийн хүндрэлээс үүдэн олон сая ажлын байр үгүй болж байгаа зэргээс үүдэн иргэд сэтгэл гутралд орох нь ч эрс нэмэгдэж, үүнээс үүдэн зарим орнуудад амиа хорлолтын төвшин нэмэгдсэн тоо баримтууд гарчээ.

Жишээлбэл Япон Улсад сүүлийн жилүүдэд Засгийн газар, холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд амиа хорлолтын төвшин буурч байсан ч энэ оны хоёр, гуравдугаар улиралд эргэн огцом нэмэгдсэн тоо баримт гарчээ. Тухайлбал Япон улсад зөвхөн аравдугаар сард 2,153 хүн амиа хорлосон нь анх цар тахал дэгдсэн цагаас хойш тус улсад Ковид-19 өвчний халдвар аваад, амиа алдсан хүний тооноос ч даваад байна. Үүнийг цар тахал, хөл хорио, эдийн засгийн хүндрэлтэй шууд холбоотой гэж үзэж байгаа.

Тэр дундаа Япон улсад эмэгтэйчүүдийн амиа хорлох үзэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 83 хувиар хувиар нэмэгдсэн байгааг цар тахлаас үүдэн үгүй болсон ажлын байрууд буюу зочид буудал, хүнсний үйлчилгээний салбарт эмэгтэйчүүд голлон ажилладаг байсантай холбоотой гэж таамаглаж байна.

Япон Улс нь амиа хорлолтын талаарх тоон мэдээллийг сар тутмаар, нарийвчлан гаргадаг цөөн улсын нэг тул энэ төрлийн мэдээлэл нь одоогоор тодорхой болоод байна. Харин он дууссаны дараа бусад улс орнууд энэ талаарх мэдээллээ нэгтгэхэд үүнтэй төстэй үр дүн гарахыг үгүйсгэх аргагүй.

Бусад улс оронд амиа хорлолт нэмэгдээгүй байж болох ч иргэдийн дунд сэтгэл гутралд орох, цар тахлаас хэт эмээх үзэгдэл газар авч, нийгмийн сэтгэл зүйд ноцтой сөрөг өөрчлөлт гарсан байх магадлал өндөр юм.

Цар тахлын үед Ковид-19 өвчин, коронавирусийн талаар зах замбараагүй худал, шинжлэх ухааны болон логик үндэслэлгүй мэдээллүүд тархаж байгаа нь ч хүн төрөлхтний өмнө бодит сорилтыг учруулж буй билээ.

Үүний зэрэгцээ цар тахлын үед зарим улс оронд гарсан тодорхой шийдвэр, үйл явдлууд нь ардчилал, хүний эрхийн зарчимд маш том сорилтыг учруулж байна ч гэж үзэж болох юм. Мөн олон нийтийн дунд харьцангуй авторитар засаглал бүхий улс орнуудад цар тахалтай тэмцэх ажил амжилттай явагдсан гэж үзэх ташаа хандлага ч гараад буйг анхаарахгүй өнгөрч болохгүй юм.

Дэлхий даяар цар тахал, хөл хорионоос үүдэн бүх шатны сургалт цахим хэлбэрт шилжсэнээр боловсролын тэгш хүртээмжтэй байдал алдагдаж, дэлхий даяар нийт сурагчдын 1/3 орчим нь буюу 463 сая хүүхэд цахим болон алсын зайн сургалтад огт хамрагдаж чадаагүй байна.

Цаашлаад дэлхийн зарим бүс нутаг, улс оронд өлсгөлөн, хүмүүнлэгийн хямрал улам бүр газар авч, зарим улс орнуудын хоорондын зөрчил, үл ойлголцол даамжирч, олон улс, бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад чухал нөлөө үзүүлж байсан зарим олон талт болон хоёр талт яриа хэлэлцээ зогсонги байдалд орж, удааширсан зэргийг ч дурдаж болох юм.

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Дэлхийн улс орнуудын цар тахлын үеэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь харилцан адилгүй байна.

Зарим улс орнууд халдварын тархцыг хязгаарлахын тулд хэт хатуу хөл хорио тогтоосноор эдийн засгаа эрсдэлд оруулах хандлага ажиглагдаж байгаа бол зарим улс анхнаасаа эдийн засагтаа хэт ач холбогдол өгснөөс үүдэн халдварын олон удаагийн давлагаа дэгдэх, олон сая хүн халдвар авч, олон мянган хүн амиа алдах үзэгдэл гарсаар байна. Тиймээс цар тахлын үед нийтийн эрүүл мэнд, эдийн засаг болон бусад салбарт хохирол багатайгаар даван туулах зохистой тэнцвэрийг олох нь дэлхийн улс орнуудын өмнө тулгамдаад буй нийтлэг сорилт болоод байна. Ерөнхий дүр зургаараа дэлхийн улс орнууд харьцангуй нийтлэг авч хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээнүүд бий.

Тухайлбал дэлхийн бараг бүх улс орнууд цар тахлын аль нэг цаг үед, харилцан адилгүй хугацаагаар олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах, гаднаас ирсэн иргэдийг тодорхой хугацаанд тусгайлсан байранд тусгаарлах эсвэл өөрийгөө тусгаарлах чиглэл өгөх зэрэг алхмыг авч хэрэгжүүлсэн.

Түүнчлэн үйлчилгээний байгууллагуудыг ач холбогдлоор эрэмбэлж, онц шаардлагагүй гэж үзсэн үйлчилгээний байгууллага, олон нийтийн газруудыг хаах, үйл ажиллагааг хязгаарлах зэрэг алхмыг авч хэрэгжүүлсэн.

Дэлхийн ихэнх орон хүнсний дэлгүүр, эмийн сан зэрэг үйлчилгээний байгууллагууд, төрийн үйлчилгээний тодорхой байгууллагуудыг хатуу хөл хорионы үед ч ажиллуулах чиглэлийг баримталж байлаа.

Дэлхийн улс орнууд нийтээрээ Ковид-19 өвчний оношлуур, халдвар хамгааллын бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхийг оролдож, энэ төрлийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч зарим улс халдварын эхэн үед экспортыг хязгаарласан зэргээс шалтгаалан зарим улс хомстол үүсэх хандлага ажиглагдаж байсан.

Мөн зарим улс орнууд халдварын эхэн үед “амны хаалт зүүх” журам гаргаагүй ч “зай барих” журмыг нийтээрээ мөрдүүлж байсан. Түүнчлэн халдвар идэвхтэй тархсан улс орнууд нийтээрээ ид дэгдэлтийн үед иргэд олноор бөөгнөрөх магадлалтай үйлчилгээний газруудыг хаах, бүх шатны сургалт, боловсролын байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх шийдвэрийг авч хэрэгжүүлжээ.

Гэхдээ улс орнууд хөл хорио тогтоох, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлахдаа харилцан адилгүй цаг хугацаанд шийдвэр гаргасан нь мөн цар тахлын тархцад чухал нөлөө үзүүлжээ. Тухайлбал эрдэмтдийн тооцоогоор цар тахлын эхэн болон сүүл үед зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах нь бодит үр дүнтэй ч зарим улсад цар тахлын ид дэгдэлтийн үе эхэлсэн хойно хөдөлгөөн хязгаарласан тул цар тахлын тархцыг хязгаарлахад бодитоор нөлөөлж чадаагүй гэж дүгнэжээ. Мөн дэлхийн улс орнууд нийтээрээ цар тахлын үед халдвар дэгдсэн бүсээс иргэдээ татан авах, ингэхдээ тусгай үүргийн нислэг гүйцэтгэх алхмыг авч хэрэгжүүлсэн. Анх БНХАУ-ын Ухань хотод халдвар дэгдэх үед дэлхийн улс орнууд нийтээрээ тухайн бүсээс иргэдээ татан авсан бол хожим нь халдвар дэгдсэн бусад газраас ч иргэдээ татан авах ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү судалгаанд дэлхийн улс орнуудын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг авч үзэхдээ “нийтийн эрүүл мэнд”, “эдийн засаг” гэсэн хоёр үндсэн болон бусад чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг авч үзлээ. Дэлхийн улс орнууд цар тахлын үед нийтийн эрүүл мэндийг хамгаалахын тулд нэн түрүүнд халдварын тархцыг хумих, хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эдгээр улс орнуудын Засгийн газар, холбогдох байгууллагууд халдварын эхэн үед зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах, иргэдээ татан авах зэрэг нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээс гадна өөр хоорондоо харилцан адилгүй арга хэмжээг ч авч хэрэгжүүлсэн билээ. Энэхүү судалгаанд дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, баримталсан бодлогыг бүсчилсэн байдлаар ангилан авч үзлээ. Ерөнхий дүр зургаараа тухайн улсын нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр баримталсан бодлого үр дүнд хүрсэн эсэхийг бүртгэгдсэн халдварын тоо болон халдварын улмаас амиа алдсан хүний тоогоор авч үзэх нь зохистой юм.

Халдварын тоог нийтэд нь авч үзвэл АНУ, Энэтхэг, Бразил, ОХУ, Францад хамгийн олон халдвар бүртгэгдээд байна. Гэхдээ халдварын тоогоор халдварыг хэмжих нь зарим талаар өрөөсгөл байх боломжтой. Учир нь улс орнуудад бүртгэгдэж буй нийт халдварын тоо нэг талаасаа халдварын тархцыг илэрхийлэх ч нөгөө талаасаа улс орнуудын шинжилгээний хүчин чадлыг илтгэх юм. Тухайлбал зарим өндөр хөгжилтэй оронд иргэдийг нийтээр нь шинжилгээнд хамруулж байгаагаас шалтгаалан халдварын тоо харьцангуй өндөр буюу бодит халдварын тоотой ойролцоо байгаа бол зарим оронд халдварын тоо бага байгаа нь халдвар авсан хүмүүсийг шинжилгээнд хамруулж чадахгүй байгаатай холбоотой юм. Тиймээс бүртгэгдсэн халдварын тоог судалгаанд гол параметр болгон авч үзэх нь өрөөсгөл гэж үзэж байна. Жишээлбэл Мексик Улсад Ковид-19 өвчний улмаас нас барсан хүний тоог нийт бүртгэгдсэн халдварын тоотой харьцуулахад дэлхийн дунджаас 5 дахин өндөр буюу нийт бүртгэгдсэн халдварын 9.4 хувь нь нас баржээ. Үүнийг тус улс халдвар авсан бүх хүмүүсээ шинжилгээнд хамруулж чадаагүйтэй холбоотой гэж үзэх нь илүү зохистой. Харин энэ тоо Их Британид 3.6, Италид 3.5 байхад АНУ-д 1.9, ОХУ-д 1.8, ХБНГУ-д 1.6, Энэтхэгт 1.5 байна. Энэ тоонд тухайн улс орны эмчилгээний тоног, төхөөрөмжийн хүчин чадал, эмнэлгийн хүртээмж нөлөөлсөн нь тодорхой. Мөн нийт хүн ам, тэр дундаа халдвар авсан хүмүүсийн дунд Ковид-19 өвчний эрсдэлт бүлэг буюу өндөр настнуудын эзлэх хувь өндөр байх нь энэ тоонд тодорхой хэмжээнд нөлөөлсөн нь ойлгомжтой.

Мөн тухайн улс, үндэстний амьдралын ерөнхий хэв маяг ч энэ мэтийн тоон үзүүлэлтэд шууд болон дам нөлөө үзүүлсэн нь гарцаагүй. Тухайлбал ахмадын асрах газрууд хөгжссөн буюу өндөр настнуудыг асрах газарт өгөх үзэгдэл түгээмэл байдаг газруудад өндөр настнуудын дунд халдвар голомтлон тархах үзэгдэл гарч буй нь нас баралтын тоонд нөлөөлж буйг ч дурдах нь зүйтэй.


Хэдий тийм ч Мексик гэх мэт зарим улсын жишээг авч үзэхэд халдварын тоо цөөн байгаа гол хүчин зүйл нь шинжилгээний хүчин чадал гэж дүгнэхэд хүрч байна.

Тиймээс улс орнуудад нийтийн эрүүл мэндийн чиглэлд учирсан хохирлыг тооцохдоо бүртгэгдсэн халдварын тоог ашиглахаас илүүтэй нас баралтын тоог авч үзэх нь зохистой гэж үзлээ.

Нас баралтын тоог авч үзэхдээ тухайн улсын нийт хүн амын тоотой харьцуулан авч үзсэн болно. Ковид-19 цар тахлын улмаас амиа алдсан хүний тоог нийт хүн амын тоотой нь харьцуулж үзэхэд Бельги, Сан Марино, Андорра, Испани, Итали тэргүүтэй Европын орнууд болон Перу, Аргентин тэргүүтэй Өмнөд Америкийн, АНУ, Мексик гэсэн Умард Америкийн орнууд хамгийн их хохирол амссан гэж үзэж болохоор байна. Харин Ази, Номхон далайн болон Африкийн зарим орнууд халдварыг амжилттай хянаж, хязгаарлаж, нийтийн эрүүл мэндийн салбартаа анхаарч чадсан гэж дүгнэж болохуйц байна.

Үүнээс Сан Марино, Андорра гэсэн харьцангуй цөөн хүн амтай улсуудыг хасч тооцвол 100,000 тутамд Бельгид 165 хүн, Перуд 116 хүн, Испанид 106 хүн, Италид 116 хүн, Их Британид 104 хүн, Аргентинд 95 хүн, Мексикт 95 хүн, АНУ-д 100 хүн тус тус Ковид-19 өвчнөөс үүдэн нас баржээ. Харин энэ тоо Тайваньд 0.03, Вьетнамд 0.04, Тайландад 0.09, Папуа Шинэ Гвинейд 0.08, БНХАУ-д 0.34, Шинэ Зеландад 0.51, Сингапурт 0.51, Шри Ланкад 0.6 байгааг үзвэл халдварын эхний шатны давлагаа Ази, Номхон далайд явагдсан ч бүс нутгийн орнууд оновчтой бодлого хэрэгжүүлж, халдварын тархцыг хязгаарлаж чадсан гэж дүгнэж болох юм.

Мөн Африкийн орнуудыг авч үзвэл 100,000 хүн тутамд Танзанид 0.04, Ардчилсан Конгод 0.11, Нигерт 0.34, Буркина Фасод 0.34, Бенинд 0.38, Руандад 0.41, Мозамбикт 0.45, Угандад 0.48 хүн Ковид-19 өвчний улмаас нас барсан нь нэг талаасаа бүс нутгийн орнууд халдварын давлагааг хумих, хязгаарлах чиглэлд амжилттай ажиллаж чадсантай, нөгөө талаасаа тухайн бүсэд халдвар харьцангуй сүүлд дэгдсэнтэй холбоотой гэж үзэж болох юм.



Зураг 1. 1 сая хүн тутамд Ковид-19 өвчний улмаас нас барсан хүний тоо. /улсаар/

Мөн бүс нутгийн дундаж үзүүлэлтээр авч үзвэл нэг сая хүн ам тутамд Ковид-19 өвчний улмаас амиа алдаж буй хүний тоогоор Өмнөд болон Умард Америк хамгийн өндөр байна. Тухайлбал Өмнөд Америкт энэ тоо 756, Умард Америкт 755, Төв Америкт 661, Европын холбоо болон Их Британид 610 байна. Харин зарим бүс нутагт энэ тоо дундаж буюу Ойрхи Дорнодод 263, Европын бусад хэсэгт 246, Орос, Төв Азийн бүсэд 199, Умард Африкт 107, Карибын тэнгисийн орнуудад 103 байна. Харин Өмнөд Азид 84, Номхон далайн болон Зүүн Азийн арлын орнуудад 49, Өмнөд Африк буюу Сахараас өмнөд Африкт 29, Зүүн Азид 4 буюу харьцангуй доогуур байна. Өөрөөр хэлбэл дэлхийн бүс нутгуудад Ковид-19 цар тахлын халдвар тархсан төвшин болон халдвараас үүдэн нас барсан хүний тоо ялгаатай, тэр дундаа нийт хүн амын тоотой харьцуулахад эрс зөрүүтэй байгаа нь дэлхийн улс орнуудын цар тахлын үед нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүсчилсэн байдлаар авч үзэх боломжтойг илтгэж байна.

Бүс нутаг	Нийт халдвар	Нийт нас баралт	Халдвар (1 сая хүнд)	Нас баралт (1 сая хүнд)	Нийт хүн ам
Өмнөд Америк	10,967,678	322,631	25,708	756	420,617,930
Умард Америк	13,451,064	276,762	30,697	755	360,544,471
Төв Америк	1,690,027	117,410	9,291	661	177,586,525
Европын холбоо ба Их Британи	12,663,832	313,393	21,168	610	513,171,878
Ойрхи Дорнод	3,331,462	79,211	11,081	263	300,634,907
Европын бусад орнууд	2,185,700	41,017	13,130	246	166,471,088
Орос, Төв Ази	2,918,181	18,001	12,212	199	211,151,031
Умард Африк	635,151	16,556	1,089	107	155,332,018
Кариббын тэнгис	290,093	1,535	8,807	103	13,909,183
Өмнөд Ази	10,512,070	154,106	5,728	84	1,835,297,503
Номхон далайн болон Зүүн Азийн арлууд	1,142,826	27,987	1,994	49	573,046,988
Сахараас өмнө зүгийн Африк	1,115,862	32,277	1,277	29	1,108,883,833
Зүүн Ази	338,260	7,500	188	4	1,795,327,024
Нийт (дундаж)	61,433,517	1,441,485	7,974	187	7,704,374,158

Эдийн засгийн талаас авч үзвэл цар тахлын үеийн хөл хорио ихэнх улс орнуудын санхүүгийн нөөц султай, жижиг, дунд аж ахуй нэгжүүдэд хүнд цохилт учруулах өндөр эрсдэлтэй тул улс орнууд нийтээрээ жижиг, дунд аж ахуй нэгжүүдээ хамгаалах, тэгэхийн тулд татварын тодорхой хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Мөн өрхийн амьжиргааны асуудал цар тахлын үед хурцаар тавигдаж байгаа учраас улс орнууд харилцан адилгүй хэлбэрээр өрхийн амьжиргааг дэмжиж байна. Тухайлбал зарим хэсэг нь иргэдийн гарт бэлэн мөнгө тараах бодлогыг сонгосон бол нөгөө хэсэг нь ажлын байрыг хангах, зарим төрлийн татвар, зээлийн төлөлтийг чөлөөлөх, хойшлуулах зэрэг алхмыг авч хэрэгжүүлжээ.

Түүнчлэн улс орнууд нийтээрээ цар тахалтай тэмцэх ажилд голлох үүрэгтэй ажилласан ажилтан, алба хаагчдад санхүүгийн хөшүүрэг болох зорилгоор нэмэлт мөнгөн урамшуулал олгох, ажлын байраа хадгалсан аж ахуй нэгжүүдийг урамшуулах зэрэг алхмыг авч хэрэгжүүлэх нь нийтлэг байна.

Эдийн засгийн хохирлыг улс орнуудаар тооцож үзвэл мэдээж халдварын тархцыг амжилттай, богино хугацаан хумьж чадсан, түүндээ уялдуулан хөл хориогоо оновчтой цагт суллаж чадсан улс орнуудын эдийн засаг богино хугацаанд эргэн сэргэх хандлагатай байгаа бол анхнаасаа эдийн засгийн үзүүлэлтэд хэт ач холбогдол өгсөн халдвар хяналтгүй тархсан улс орнуудад эсрэгээрээ хожим нь хөл хорио тогтоохоос өөр аргагүйд хүрч байна.

Тиймээс цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг даван туулах нь халдварын тархцыг хумих, хязгаарлахаас шууд хамааралтай байгаа нь харагдаж байна.

1. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЗАРИМ ОРНЫ ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Халдварын эхний томоохон дэгдэлтүүд БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хот болон БНСУ-ын Тэгү хотод буюу Зүүн хойд Азийн томоохон орнуудад явагдсан. Тэр утгаараа халдварын эхэн үед хамгийн бодит эрсдэлд байсан орнууд нь тухайн орнууд болон газар зүйн хувьд тэдгээртэй ойр байрладаг, Зүүн өмнөд Ази, Зүүн хойд Азийн бүс нутгийн орнууд байсан.

Харин анх халдвар дэгдэх үед энэ бүс нутгийн орнууд нийтээрээ маш шуурхай, үр дүнтэй ажиллаж чадсан нь өдгөө харагдаж байна.

Энэхүү судалгаанд анх халдвар хурдацтай дэгдэх бодит эрсдэл байсан ч түүнээс сэргийлж чадсан БНХАУ, БНСУ, Япон улсууд, шуурхай, оновчтой шийдвэрүүдийн үр дүнд харилцан адилгүй арга замаар халдварыг амжилттай хумиж чадсан Вьетнам, Шинэ Зеланд болон бүс нутгийн орнуудтай харьцуулахад халдварыг хумих, хязгаарлах чиглэлд тааруухан ажилласан тооцогдож байгаа Филиппин, Энэтхэг улсуудыг жишээлэн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нь тоймлон авч үзлээ.

1.1. БНХАУ

БНХАУ-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дагаврыг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хангах чиглэлээр:

- Анх халдвар дэгдэх үед шинэ төрлийн коронавирусийн гарал үүслийг тодорхойлох, хүнээс хүнд халддаг эсэхийг нь эцэслэн тогтоох чиглэлд голлон анхаарсан
- Халдвар хүнээс хүнд халддаг нь тогтоогдсоны дараагаас халдварын эхний голомт болох Ухань хот болон Хубэй мужийн бусад хотод хатуу хөл хорио тогтоож, тус хотуудад хөл хорио дунджаар 2 сар орчмын хугацаанд үргэлжилсэн .
- Ухань хот дахь хөл хорионы үед эмнэлэг, дэлгүүр, шатахуун түгээх станц, эмийн сангаас бусад бүх үйлчилгээний газрыг хааж, Ухань хотод нийтийн тээврийн хөдөлгөөнийг зогсоогоод, тусгай захиалгаар үнэгүй үйлчлэх такси үйлчилгээг бий болгосон
- Хубэй мужид хөл хорио тогтоох нь оновчтой шийдэл байсан ч цаг хугацааны хувьд хожимдсон нь халдвар БНХАУ-ын бусад муж болон дэлхийн бусад орнуудад тархахад хүргэсэн гэж үзэж байна /Шийдвэр хожимдож гарахад нөлөөлсөн хүчин зүйлсийг доор авч үзнэ/
- Ухань хотод эмнэлэг хүрэлцэхгүй болсон тул хоёр эмнэлгийг богино хугацаанд барьж, хээрийн эмнэлэг нээж, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд бусад мужаас дайчилсан
- Халдвар хамгааллын бүтээгдэхүүний хомстол, үнийн хөөрөгдөл үүсэхээс сэргийлж амны хаалт зэрэг халдвар хамгааллын бүтээгдэхүүний экспортыг хязгаарлаж, үнээ огцом нэмсэн аж ахуй нэгжийг торгосон
- Ухань хот болон Хубэй мужаас бусад хот, муж руу чиглэсэн зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарласан
- Хубэй мужаас бусад муж, хотуудад иргэдийн халууныг хэмжих, амны хаалт зүүхийг журамласан /Хятадын насанд хүрсэн иргэдийн дийлэнх нь САРС цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм сахисан туршлагатай тул Ковид-19-ийн үед ч дэглэм сайн сахисан гэж мэргэжилтнүүд үзэж байна./
- Хөл хорионы үед шинжилгээний хүчин чадлыг эрс нэмэгдүүлсний үр дүнд хөл хорионы дараагаар Ухань хотын бүх иргэдийг шинжилгээнд хамруулсан
- Харилцан адилгүй хугацаанд орон нутгийн удирдлагууд ухаалаг, дэвшилтэт технологи дээр суурилсан, иргэдийн хөл хөдөлгөөн, халдварын тархцыг хянах системийг нэвтрүүлсэн.
- Шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлж, ухаалаг технологи ашигласны үр дүнд хожим Чиндао, Бээжин болон бусад хотод дэгдсэн халдварыг богино хугацаанд хумьж чадсан

Эдийн засгийн чиглэлээр:

- Халдварын тархцыг хянах, хязгаарлах чиглэлийн төсвийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлд нийт 4.8 их наяд юанийн багцыг төсөвлөсөн нь ДНБ-ы 4.7 хувьтай тэнцэх үзүүлэлт.
- Аж ахуй нэгжүүдийн авсан зээлийг нэмэлт нөхцөлгүйгээр сунгах шийдвэрийг Төв банкнаас гаргасан. Үүнээс гадна зээлийн болон эргэн төлөлтийн нөхцөлийг суллах, зээлийн санг нэмэгдүүлэх олон удаагийн шийдвэр Төв банкнаас гарсан.

- БНХАУ-ын зарим хэсэгт хөл хорионы дэглэм үргэлжилж байх үед буюу 3 дугаар сард улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон барилга, бүтээн байгуулалтын 79 хувийг сэргээсэн
 - Засгийн газраас жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг үйл ажиллагаагаа цахим хэлбэрт шилжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргасан. Мужийн удирдлагын төвшинд ч жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг дэмжих шийдвэрүүд гарсан.
 - Аж ахуй нэгжүүдээс авах нийгмийн даатгалын төлбөрийг нийтдээ 1 их наяд юаниар хэмжигдэх дүнгээр хөнгөлөх замаар ажлын байр хадгалах үндсийг бүрдүүлсэн
 - Сангийн яам цар тахалтай нүүр тулан ажиллаж байхдаа халдвар авсан эмч, эмнэлгийн ажилтнуудад нөхөн олговор олгох шийдвэр гаргаснаас гадна зарим орон нутгийн удирдлагууд эмч, эмнэлгийн ажилтнуудад өдөр тутмын мөнгөн урамшуулал олгосон.
 - Томоохон хотуудад цар тахлаас үүдэн үйл ажиллагаа нь доголдсон ч ажлын байраа хадгалсан аж ахуй нэгжүүдэд ажилгүйдлийн даатгалын сангаас урамшуулал олгосон
 - Төрийн зөвлөлөөс банкны удирдлагуудад хандан тодорхой хэмжээнд санхүүгийн золиос гаргаж, жижиг зээлүүд гаргахыг уриалсан
 - Цар тахлын нөхцөл байдал тогтворжсоны дараагаас иргэдийг дотооддоо аялахыг идэвхтэй уриалж, аялал, жуулчлалын бүсүүдийн эдийн засгийг дэмжсэн
- Дэлгэрэнгүй мэдээлэл:**

БНХАУ-ын хувьд анх цар тахал дэгдэх үед зарим талаар алдаа гаргасан, цар тахал хяналтаас гарахад тодорхой хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэх хандлага шинжээчдийн дунд давамгайлж эхэллээ.

Тухайлбал БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод анх шинэ төрлийн коронавирусийн гаралтай халдварт өвчин дэгдсэн байж болзошгүй нөхцөл байдал үүсэх үед буюу 2019 оны 12 дугаар сар болон 2020 оны 1 дүгээр сарын эхэн үед муж, хотын удирдлагууд шуурхай арга хэмжээ авч чадаагүй нь халдвар БНХАУ-ын бусад мужуудад болон дэлхий даяар тархахад нөлөөлсөн гэж үзэх хандлага байна.

Хубэй мужийн удирдлага энэ оны нэгдүгээр сард нэн түрүүнд шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх, сэжигтэй болон батлагдсан тохиолдлууд, тэдгээрийн хавьтлыг нэн даруй тусгаарлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Харин 1 дүгээр сарын 23-нд Ухань хотод хөл хорио тогтоож эхэлсэн билээ. Мөн Хубэй мужийн бусад бүх хотод хөл хорио тогтоосон. Гэвч Хубэй мужид хөл хорио тогтоох арга хэмжээ нь оновчтой байсан ч цаг хугацааны хувьд бага зэрэг хожимдсон гэж мэргэжилтнүүд үзэж байна. Одоо байгаа албан мэдээллээр Ковид-19 өвчний гарал, үүсэл эцэслэн тодорхой болоогүй ч Ухань хотын эмнэлэг анх 2019 оны 12 сарын 27-нд үл мэдэх вирусийн гаралтай өвчлөлийн талаар мэдээг орон нутгийн халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагад өгчээ. Харин энэ талаарх мэдээлэл 12 сарын 31-нд нийтэд ил болсон.

Үүний дараагаас БНХАУ-ын Үндэсний эрүүл мэндийн хороо Уханьд мэргэжилтэн илгээх, ДЭМБ-д мэдэгдэх зэрэг зохих алхмуудыг авч хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү халдварт өвчин нь коронавирусийн гаралтай болохыг 1 сарын 8-нд тогтоосон билээ.

Өдгөө мэргэжилтнүүд тухайн үед БНХАУ-ын Үндэсний эрүүл мэндийн хороо болон Хубэй мужийн удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн дүгнэхдээ арга нь зөв байсан ч цаг хугацааны хувьд хожимдсон, сунжирсан гэж дүгнэж эхлээд байна.

Өөрөөр хэлбэл Хубэй мужид 1 сарын 23-нд хөл хорио тогтоосон нь бодит үр дүнгээ өгөөгүйн илрэл нь 1 сарын сүүл үе гэхэд БНХАУ-ын бүх мужид болон зарим улс оронд халдвар тархаад байсан явдал юм.

Өмнөх хэсэгт дурдсанчлан халдварын дэгдэлтийн эхэн болон сүүл үед хөл хорио тогтоох нь үр дүнгээ өгч болох ч ид дэгдэлтийн үед хөл хорио тогтоох нь үр дүн багатай гэдэг нь Хубэй мужийн жишээнээс харагдаж байна.

Уханьд хөл хорио тогтоох шийдвэр гаралгүй цаг хугацаа алдсаныг хэд хэдэн үндэслэлээр тайлбарлах боломжтой. Үүнд.

- Орон нутгийн удирдлагын чадавх сул тул нөхцөл байдлыг буруу үнэлсэн.
- БНХАУ-д Хаврын баяр буюу Цагаан сар дөхөж байсан. Эдгээр баярын өдрүүдээр эдийн засгийн эргэлт илт идэвхэждэг тул эрх баригчид аль болох хатуу хөл хорио тогтоолгүйгээр халдварыг хумих, хязгаарлахыг оролдсон
- Авторитор засаглалтай улс орнуудад гардаг нийтлэг алдаа дахин гарсан. Өөрөөр хэлбэл орон нутгийн удирдлагууд харцуцлага хүлээхгүйн тулд дээд удирдлагадаа мэдэгдэлгүйгээр нөхцөл байдлыг хянахыг оролдсон ч тэгэх боломж байгаагүй.
- Вирус хүнээс хүнд халддаг нь харьцангуй сүүлд буюу 1 сарын 20-нд бүрэн тодорхой болсон. Энэ үед нь Бээжин тэргүүтэй том хотуудад халдвар хэдийн тархаад байлаа.
- Ухань хотод ПСР оношлуур дутмаг байснаас вирус ид дэгдэх үед бүртгэгдсэн халдварын тоо нэмэгдэхгүй байсан нь эрх баригчдыг эргэлзэхэд хүргэсэн.

Дээрх хүчин зүйлсээс хамааран Хятадын том хотуудад халдвар хэдийн дэгдсэн, Ухань хот болон Хубэй мужийн бусад хотуудад нөхцөл байдал хэдийн хүндэрсний дараа буюу 1 сарын 23-нд хөл хорио тогтоох арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.

Хугацаа алдсан нь нөхцөл байдлыг эрс хүндрүүлсэн ч БНХАУ-ын Төв Засгийн газар болон муж, хотын удирдлагууд 1 сарын 23-наас шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгсөн. Ухань хотод хатуу хөл хорио тогтоосноос гадна халдварыг хязгаарлах бусад алхмуудыг ч авч хэрэгжүүлсэн.

Хөл хорио тогтоохоос өмнө буюу 1 дүгээр сарын дунд үеэс эхлэн Ухань хотоос гарах бүх төрлийн нийтийн тээврээр зорчих хүмүүсийн халууныг шалгаж, өндөр халуунтай бол нарийвчилсан шинжилгээнд хамруулах журам мөрдөгдөж байсан ч тухайн хүмүүсийн дунд халдвар аваад, нууц үе нь үргэлжилж байсан хүмүүс олноороо багтаж байсан гэх таамаг одоо зонхилж байна. Мөн 1 сарын 20-нд нэг талаас БНХАУ-ын эрдэмтэд иргэдийг онц шаардлагагүй нөхцөлд Ухань руу зорчихгүй байхыг зөвлөж, нөгөө талаас Ухань хотын удирдлага ч иргэдээ хотоос гарахгүй байхыг уриалж эхэлсэн.

Харин хөл хорио тогтоох шийдвэр гарсан өдөр Хятадын Төмөр Замын компани болон Ухань хотын олон улсын нисэх онгоцны буудлын удирдлага хотоос гарах, орох хөдөлгөөнийг зогсоож, урьдчилан тасалбар захиалсан хүмүүст төлбөрийг нь эргүүлж олгосон.

БНХАУ-ын Төв Засгийн газар Уханьд хөл хорио тогтоох шийдвэр гаргасан даруйд бусад муж, хотын удирдлагууд ч маш шуурхай ажиллаж, ижил төстэй алхмыг авч хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 3 хоногийн дотор Хубэй мужийн бүх хот хөл хорио тогтоожээ. Эдгээр хотуудад хатуу хөл хорио тогтоохдоо эмнэлэг, дэлгүүр, шатахуун түгээх станц, эмийн сангаас бусад бүх үйлчилгээний газрыг хаажээ.

Хатуу хөл хорио тогтоосны дараагаар Ухань хотод эмнэлгийн ор болон хамгаалах хэрэгсэл хүрэлцэхгүй болж эхэлсэн тул хангалт зохион байгуулахад бусад мужийн эмнэлгийн албыг дайчилснаас гадна 1,000 болон 1,600 ортой хоёр эмнэлгийг 10 хоногийн дотор барьж, ашиглалтад оруулсан.

Энэ мэтээр Ковид-19 өвчний халдварын эхний том голомт болох Ухань хотод халдварын эхний үед хариуцлага үүдэн халдвар хилийн чанадад болон бусад мужуудад тархсан ч вирусийн халдвар хүнээс хүнд халддаг нь тогтоогдсон даруйд мужийн хэмжээнд хатуу хөл хорио тогтоосны үр дүнд халдварын давлагааг харьцангуй амжилттай хумьж чадсан.

Үндсэндээ БНХАУ-ын Хубэй мужийн хотууд дунджаар 2 сар орчмын хугацаанд хатуу хөл хорио тогтоогоод 3 дугаар сараас эргэн сулласан билээ. Нийтдээ Хубэй мужийн 17 хотод Ковид-19 цар тахлаас үүдэн хөл хорио тогтоосноос эхний хоёр хотод 3 сарын 13-нд, 1 хотод 3 сарын 17-нд, 13 хотод 3 сарын 25-нд хөл хориог суллажээ. Харин халдварын голомт Ухань хотод 4 сарын 5-нд хөл хориог сулласан.

БНХАУ-ын хамгийн томоохон мужуудын нэг болох Хубэй мужид 2 сар орчмын турш үргэлжилсэн хөл хорионы үеэр мэдээж тодорхой асуудал үүсч байсан. Тиймээс БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн төвшинд эдгээр тулгамдсан асуудлыг шийдэх чиглэлд онцгойлон анхаарч байлаа. Тэр дундаа бусад мужаас Төмөр замаар тогтмол хүнс зөөж, хүнсний хомстлоос сэргийлсэн, шаардлагатай нөхцөлд иргэдэд тусгай зөвшөөрлийг үндэслэн үнэ төлбөргүй үйлчлэх 6,000 гаруй таксиг хөдөлгөөнд оролцуулж, бөөгнөрөл үүсэхээс сэргийлсэн зэргийг дурдаж болно.

Харин Ухань хотод халдварын давлагааг хяналтад авсны дараагаар дахин давлагаа дэгдэхээс сэргийлж тавдугаар сард хот даяар иргэдийг шинжилгээнд хамруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүний үр дүнд цөөн хоногийн дотор 6 сая 500 мянга орчим хүнийг шинжилгээнд хамруулсан бөгөөд халдварын эхний үед Ухань хот дахь лабораториуд өдөрт 46,000 шинжилгээ авах хүчин чадалтай байсан бол тавдугаар сар гэхэд өдөрт 1.7 сая шинжилгээ авах боломжтой болжээ.

БНХАУ-д улсын хэмжээнд болон бусад муж хотуудад 1 дүгээр сарын сүүл үеэс халдварын тархцыг хянах, хязгаарлах чиглэлд онцгой анхаарч эхэлсэн. Зарим хотууд 1 дүгээр сарын 25-нд тохиосон Хаврын баярын арга хэмжээг хориглосон.

Мөн Хөнан мужийн удирдлага Төв Засгийн газраас чиглэл өгөхөөс өмнө буюу 2019 оны сүүл үеэс Ухань хоттой хийх галт тэрэгний зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоох, олон нийтийн газруудад ариутгал, халдваргүйжүүлэлт хийх зэрэг алхмыг авч хэрэгжүүлж байсан.

Харин халдвар хүнээс хүнд дамждаг нь бүрэн нотлогдсоны дараагаар БНХАУ-ын Засгийн газар иргэдэд хандан халдвар авсан бол нуухгүй байхыг анхааруулж, БНХАУ-ын мужууд ээлж дараалан Нийтийн эрүүл мэндийн онц байдал зарласан.

БНХАУ-д Нийтийн эрүүл мэндийн онц байдлын үед орон нутгийн удирдлагууд цар тахлыг хязгаарлахын тулд нөөц бүрдүүлэх, халдвар авсан иргэдийн эмчилгээг зохион байгуулах, цар тахлын талаар хяналт, шалгалт явуулах, тодорхой бүсийг голомтот халдварын бүс гэж зарлах, тодорхой асуудлаар иргэдэд үүрэг өгөх, хөл хөдөлгөөнийг зохицуулах, голомтот халдварын талаар мэдээлэл, тайланг бэлтгэн нийтлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангах зэрэг тодорхой эрх, үүргийг гүйцэтгэдэг.

Харин БНХАУ-ын Төв Засгийн газрын зүгээс цар тахлын эхний үед зайлшгүй тулгарсан гол сорилт нь цар тахлын эхний давлагаа дэлхийн хамгийн идэвхтэй шилжилт хөдөлгөөн явагддаг өдрүүд буюу Хятадын Цагаан сартай давхацсан явдал юм.

Үндсэндээ Хятадын Цагаан сарын үеэр 40 орчим хоногийн туршид идэвхтэй шилжилт хөдөлгөөн явагддаг. Энэ оны хувьд энэхүү шилжилт хөдөлгөөн 1 сарын 10-нд эхэлж, 2 сарын 18-нд дуусах төлөвтэй байсан. Харин энэхүү шилжилт хөдөлгөөн идэвхтэй үргэлжлэх үед голомтот халдвар дэгдсэн нь нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн.

БНХАУ-ын Иргэний Агаарын тээврийн удирдах байгууллага цар тахлын тухай мэдээлэл анх гарах үеэс эрүүл мэндийн удирдах байгууллагуудтай нягт хамран ажиллаж, нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж байгаагаа мэдэгдсэн.

Харин халдвар хүнээс хүнд дамждаг нь тогтоогдсоны дараа Засгийн газар иргэдэд хандан Ухань хот руу аялахгүй байхыг удаа дараа уриалж байв.

Мөн Ухань хотын Соёл, Аялал жуулчлалын товчоо хотдоо жуулчдыг хүлээн авах зорилготой бүх арга хэмжээ, сурталчилгааг зогсоож, музей, нийтийн номын сан, соёлын төв болон бусад олон нийтийн газрыг хагас сарын хугацаатай хаасан.

Энэ мэтээр халдварын эхэн үед БНХАУ-ын муж, хотын удирдлагууд иргэдийн шилжилт, хөдөлгөөнийг хүчээр хаахаас илүүтэйгээр аялал, жуулчлалыг татах зорилготой нийтийн арга хэмжээг цуцлах, олон нийтийн газрыг хаах зэрэг арга хэмжээг улс даяар авч хэрэгжүүлжээ. Хубэй мужид хатуу хөл хорио тогтоосны дараагаас Шанхай, Жиансү, Хайнан тэргүүтэй зарим орон нутгийн удирдлагууд Хубэй мужаас ирсэн хүмүүсийг 14 хоног тусгаарлах журам мөрдүүлж эхэлсэн бол Чунчин хот он гарснаас хойш Ухань хотоос ирсэн бүх хүмүүсийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Харин Жэжян мужийн Вэньжоу хотод ихэнх авто замыг хааж, нэг өрхөөс нэг хүн хоёр хоног тутамд нэг удаа гарч болох журам мөрдүүлж эхэлсэн.

БНХАУ Төв Засгийн газрын харьяа байгууллагууд төрийн албаны шалгалтыг хойшлуулах, орон нутгийн удирдлагууд тухайн орон нутагтаа боловсролын үйл ажиллагааг түр зогсоох зэрэг шийдвэрийг нөхцөл байдал хүндэрсэн даруйд гаргасан.

Мөн голомтот халдвар дэгдэж эхлэх үед БНХАУ-ын мужууд БХАТИХ-ын төлөөлөгчдийг сонгох хурлуудаа хойшлуулж, хожим нь БХАТИХ ч хойшлогдсон билээ.

Голомтот халдварын эхэн үед БНХАУ-ын томоохон хотуудад амны хаалтны хомстол үүсэх хандлага ажиглагдаж эхэлсэн тул Эрүүл мэндийн хороо улсын хэмжээнд амны хаалт үйлдвэрлэх хүчин чадлыг эрс нэмэгдүүлэх алхмыг авч хэрэгжүүлсэн.

Мөн энэ төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ хөөрөгдөхөөс сэргийлж, үнэд хяналт тогтоосноос гадна нөөцийн хомстлоос сэргийлж, хамгаалах хэрэгслийн экспортыг хориглож, эсрэгээрээ 1 сарын 24-нөөс 2 сарын 29-ний хооронд 2 тэрбум гаруй ширхэг амны хаалт, 25 сая хамгаалалтын хувцсыг хилийн чанадаас худалдан авчээ.

Дотооддоо ч амны хаалт, бусад хамгаалах хэрэгслийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан бөгөөд үүний үр дүнд гуравдугаар сар гэхэд БНХАУ-д өдөрт 100 сая ширхэг амны хаалт үйлдвэрлэж байв.

Хоёрдугаар сараас ихэнх орон нутгийн удирдлагууд ямар нэг байдлаар ухаалаг, дэвшилтэт технологи дээр суурилсан, иргэдийн хөл хөдөлгөөн, халдварын тархцыг хянах системийг нэвтрүүлсэн билээ.

Үндсэндээ БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод дэгдсэн голомтот халдварын дэгдэлтийн эхний үед орон нутгийн удирдлага зарим талаар алдаатай гэж үзэж болохуйц шийдвэрийг гаргасан. Үүнийг ямар зүйлстэй холбоотой байсныг дээр дурдсан.

Харин халдвар хүнээс хүнд халддаг нь тогтоогдсон даруйд Хубэй мужийн бүх хотод, тэр дундаа Уханьд хатуу хөл хорио тогтоож, тэр хүрээндээ тус хот дахь эмнэлгийн хүчин чадлыг эрс нэмэгдүүлэх, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байх алхмыг авч хэрэгжүүлсэн нь үр дүнд хүрч, хөл хорио 2 сар орчмын хугацаанд үргэлжлээд тавигджээ.

Харин Хятадын бусад хотууд нийтээрээ Ухань хотоос ирсэн иргэдийг тусгаарлах, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, сургалтыг зогсоох, олон нийтийн газрыг хаах зэрэг алхмыг авч хэрэгжүүлсэн.

Чингэхдээ халдварын тархцыг хязгаарлахад чиглэсэн аливаа шийдвэрийг БНХАУ-ын Үндэсний Эрүүл мэндийн хорооны зөвлөмжийг үндэслэн орон нутгийн удирдлагууд гаргаж байв. БНХАУ-ын Хубэйгээс бусад мужид нөхцөл байдал хатуу хөл хорио тогтоох шаардлага тулгартал хүндрээгүйг мэргэжилтнүүд БНХАУ-ын иргэдтэй шууд холбон тайлбарлажээ. Тухайлбал БНХАУ-ын иргэдийн дийлэнх нь өмнө 2002-2004 онд дэгдсэн САРС-ын халдварын үед амьдарч, тухайн өвчнийг даван туулсан тул голомтот халдварын үед ямар дэглэм мөрдөх ёстойг мэдэж байсан гэж үзэж болох юм. БНХАУ-ын холбогдох байгууллагууд амны хаалт зүүх албан шийдвэр гаргаагүй байхад иргэд амны хаалт худалдан авч, улсын хэмжээнд хомстол үүсэх эрсдэл тулгарсныг үүнтэй холбон тайлбарлаж болох юм. Мөн БНХАУ-ын нийгмийн ерөнхий чиг хандлагыг харахад ахмад хүмүүс гэр бүлтэйгээ амьдрах нь түгээмэл байдаг, Хятадын ахмад настнуудын ердөө 3 хувь нь асрах газарт оршин суудаг нь хожим барууны орнуудад тохиосон шиг асрах газрууд халдварын голомт болох эрсдэлээс хамгаалсан гэж мэргэжилтнүүд үзжээ. БНХАУ-д халдварын эхний давлагааг амжилттай хяналтад авснаас олон нийтийн газруудад халдвараас сэргийлэх тодорхой журам мөрдүүлж эхэлсэн. Энэ төрлийн журмууд нь муж, хот тус бүрт харилцан адилгүй байсан ч үнсэндээ халуун хэмжих, гар угаах, халдваргүйжүүлэх, амны хаалт зүүх, ухаалаг утсан дээр суурилсан технологи ашиглан иргэдийн хөдөлгөөнийг хянах, нийтийн тээврээр зорчихоос зайлсхийхийг зөвлөх, зай барих зэрэг арга хэмжээнүүд зонхилж байв. Хэдий тийм ч эхний давлагаанаас хойш БНХАУ-д хилийн чанадаас ирсэн хүмүүсээс шалтгаалан хэд хэдэн удаа голомтот халдвар үүссэн. Орон нутгийн удирдлагууд тухай бүрт нь богино хугацаанд бүсчилсэн хатуу хөл хорио тогтоож, богино хугацаанд халдварыг хумих бодлого баримталж байлаа. Ийм шийдвэр 4 дүгээр сард Хөнан мужийн Жиа гэх газарт, 5 дугаар сард Харбин хотод, 7 дугаар сард Шиньжян Уйгурын Өрөмч хотод гарсан бөгөөд тухай бүрт нь халдварын голомтыг цөөн хоногт амжилттай хумьж, хязгаарлаж чадсан. Эдгээрээс хамгийн томоохон нь 6 дугаар сард Бээжин хотын Шинфади захад гарсан дэгдэлт байсан. Энэ үед хотын удирдлага тус захыг болон ойролцоох сургуулиудыг хааж, зах байрладаг Фентай дүүрэгт хөл хорио тогтоосон. Энэ үед БНХАУ-ын Засгийн газар болон Бээжин хотын засаг захиргаа шуурхай ажилласны үр дүнд үндсэндээ 10 хоногийн дотор халдварыг хяналтад авсан. Халдварын эхний давлагаанаас хойш нөхцөл байдал тогтвортой байх үед Ковид-19 цар тахал дахин голомтлон дэгдвэл ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх чиглэлд мэргэжлийн байгууллага онцгой анхаарч байсан нь Бээжин хотод гарсан дэгдэлтийг хязгаарлахад онцгой нөлөө үзүүлсэн. Тухайлбал Бээжин хот дахь дэгдэлтийн үед QR кодыг ашиглан зөвхөн халдваргүй нь тогтоогдсон хүмүүсийг хотоос гаргах, түргэвчилсэн оношлуураар халдвар илрээгүй хүмүүсийг нийтийн тээврээр зорчуулах журам мөрдөгдөж байлаа. Мөн халдвар илэрсэн даруйд өдөрт 1 сая шинжилгээ авсан нь халдварын нөхцөл байдлыг богино хугацаанд тогтооход түлхэц болсон.

Үүнтэй ижил, төстэй арга хэмжээг 10 сард Чиндао хотод хэрэгжүүлж, Чиндао хот 9 сая иргэнээ бүгдийг нь шинжилгээнд хамруулж байв.

Түүнчлэн цар тахлын үе болон халдварын нөхцөл байдал тогтворжсон үед БНХАУ эдийн засгийн үйл ажиллагааг сэргээхэд тогтмол анхаарч байлаа. Тухайлбал анх цар тахал дэгдэх үеэс хөл хорионоос үүдэн тулгамдаж болзошгүй гол аюул болох жижиг, дунд аж ахуй нэгжүүд санхүүгийн хүндрэлд орох, дампуурах, иргэд ажлын байраа алдахаас сэргийлсэн алхмыг авч хэрэгжүүлсэн. Цар тахлаас шалтгаалан хойшлогдоод тавдугаар сард зохион байгуулагдсан БХАТИХ-ын үеэр тус улсын Ерөнхий сайд Ли Көцян энэ онд эдийн засгийн өсөлтийн ямар нэг тодорхой зорилт тавиагүй, оны эхний хагаст улсын эдийн засагт хүнд цохилт учирсан боловч цар тахлыг харьцангуй эрт, амжилттай хумьж чадсан, эдийн засгийн оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд БНХАУ-ын эдийн засаг богино хугацаанд сэргэж байна.

Үүнд нэн түрүүнд БНХАУ-ын Төв Банкны авч хэрэгжүүлсэн зээлийн нөхцөлийг хөнгөрүүлэх, зарим зээлийг нэмэлт нөхцөлгүйгээр сунгах шийдвэрүүд чухал нөлөө үзүүлжээ. Мөн зээлийн санг нэмэгдүүлж банкнуудыг санхүүжүүлснээр аж ахуй нэгжүүд хүндрэлийн үед зээл авах боломж нэмэгдсэн.

Улмаар Төв банкнаас зарим орон нутгийн жижиг банкны жижиг, дунд аж ахуй нэгжүүдэд олгосон бага дүнтэй зээлийг хариуцах бодлого баримталж нийтдээ 400 тэрбум юань зарцуулж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн авсан баталгаагүй зээлийн 40 орчим хувийнх нь хагас жилийн төлөлтийг төрөөс хариуцсан.

Мөн цар тахлын үед жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг үйл ажиллагаа хэвийн үргэлжлүүлэхийн тулд тодорхой цахим болон дэвшилтэт технологи ашиглахыг төрөөс бодлогоор дэмжиж, энэ төрлийн шилжилт хийхэд нь тодорхой хэмжээгээр санхүүжүүлсэн. Түүнээс гадна БНХАУ-ын хэмжээнд жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг дэмжих бодлого Төв Засгийн газраас хэрэгжсэнээс гадна орон нутгийн удирдлагууд ч үүнд онцгой анхаарал хандуулж байв.

Үндсэндээ зарим улс орны туршлагаас харахад хөл хорионоос үүдэн нэн түрүүнд дампуурах эрсдэлтэй аж ахуй нэгжүүд нь жижиг, дунд бизнес эрхлэгчид байна. Жижиг, дунд аж ахуй нэгжүүд томоохон корпорацуудын нэгэн адилаар олон мянга, зуугаар тоологдох ажлын байрыг дангаар бий болгодоггүй ч бүх жижиг, дунд бизнес эрхлэгчид нийтдээ улс орнуудын эдийн засагт жинтэй хувь нэмэр болдог нь гарцаагүй.

Тиймээс БНХАУ-ын Засгийн газар аж ахуй нэгжүүдээс авах нийгмийн даатгалын төлбөрийг хөнгөлсөн бөгөөд энэ хүрээндээ нийтдээ 1 их наяд юаниар хэмжигдэх хөнгөлөлт үзүүлсэн гэж тайлбарлаж байгаа. Энэ арга хэмжээг авч хэрэгжүүлснээр жижиг, дунд аж ахуй нэгжүүдэд ажлын байраа хадгалахад нь түлхэц үзүүлсэн.

БНХАУ-ын Сангийн яам цар тахалтай нүүр тулан ажиллаж байхдаа халдвар авсан эмч, эмнэлгийн ажилтнуудад нөхөн олговор олгох шийдвэр гаргаснаас гадна зарим орон нутгийн удирдлагууд цар тахалтай тэмцэх ажиллагаанд шууд оролцож буй ажилтан, алба хаагчдад өдөр тутмын мөнгөн урамшуулал олгож эхэлсэн.

Бээжин, Шанхай тэргүүтэй томоохон хотуудад цар тахлаас үүдэн үйл ажиллагаа нь доголдсон ч ажлын байраа хадгалсан аж ахуй нэгжүүдэд ажилгүйдлийн даатгалын сангаас урамшуулал олгосон нь ч аж ахуй нэгжүүд ажлын байраа хадгалах, цаашлаад өрхийн амьжиргаанд доголдол үүсэнгүй байхад нөлөөлсөн гэж үзэж болно.

Түүнчлэн БНХАУ анхнаасаа цар тахалтай тэмцэхдээ зөвхөн эрсдэлт бүсүүдэд хөл хорио тогтоох, дундаж болон бага эрсдэлтэй муж, хотуудад халдвар хамгааллын дэглэмийг сахиулаад, эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх чиглэл баримталж байв.

Тухайлбал БНХАУ анх зөвхөн халдварын голомт Хувэй мужид хатуу хөл хорио тогтоосон, харин улсын бусад хэсэгт зарим төрлийн, хүн олноор цуглах эрсдэлтэй зарим үйлчилгээний байгууллагыг хаасан ч зарим бизнесийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж байснаас харагдаж байна.

Мөн БНХАУ-ын эрх баригчид харьцангуй эрсдэл багатай бизнесийн салбаруудыг хэвийн ажиллуулах чиглэлийг баримталж байсан нь улсын зарим хэсэгт хөл хорионы дэглэм үргэлжилж байхад буюу 3 дугаар сард улсын хэмжээнд явагдаж байсан барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны 79 хувийг сэргээснээр харагдаж байна.

Харин БНХАУ-ын эрх баригчид халдварын нөхцөл байдал тогтворжсон цагаас цар тахлаас үүдэн хүнд цохилт амссан эдийн засгаа эргэн сэргээхэд онцгой анхаарсан.

Үүний нэгэн томоохон жишээ нь улсын хэмжээнд цар тахлын нөхцөл тогтворжсоны дараагаас иргэдийг халдвар хамгааллын дэглэмийг сахиж дотооддоо аялахыг зарим албан тушаалтнууд болон мэргэжилтнүүд уриалснаас харж болно.

Үүний үр дүнд БНХАУ-ын Үндэсний баярын долоо хоногт улсын хэмжээнд аялал, жуулчлал, иргэний агаарын тээврийн салбарт сэргэж, эдгээр өдрүүдэд аялал, жуулчлалын салбарын нийт орлого 466 тэрбум юаньд хүрсэн нь өмнөх оны мөн үе буюу хэвийн үетэй харьцуулахад бага ч оны эхний хагаст хүнд цохилт амссан аялал, жуулчлалын салбарт том дэм болсон.

Мөн Хайнань тэргүүтэй аялал жуулчлалын цогцолбор бүсүүдэд ч сүүлийн саруудад цар тахлын халдвар огт бүртгэгдээгүй тул дотоодын жуулчдын хөдөлгөөн илт нэмэгдэж, тухайн бүсийн эдийн засагт томоохон ахиц гарч байна.

Нийтдээ БНХАУ-ын Засгийн газар цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлийг давах, чингэхийн тулд халдвараас сэргийлэх, хянах, хязгаарлах төсвийг нэмэх, эрүүл мэндийн зориулалттай бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн даатгалын нөхөн олговор олгох, зарим иргэн, аж ахуй нэгжийг татвараас чөлөөлөх зэрэг чиглэлд 4.8 их наяд юанийг зарцуулсан нь тус улсын ДНБ-ын 4.7 хувьтай тэнцэх өндөр үзүүлэлт юм.

Түүнчлэн БНХАУ-ын Төрийн зөвлөл банкнуудад хандан цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад зориулж жижиг зээлийг санхүүжүүлэх замаар 1.5 их наяд юанийн орлогоосоо татгалзахыг уриалсан. БНХАУ-ын Засаглалын тогтолцоо, загвар болон бусад хүчин зүйлсийг харгалзан үзвэл үүнийг “уриалга” гэж үзэхэд бэрх тул бусад улс орнуудад, тэр дундаа ардчилсан улсуудад зохицно гэж үзэхэд бэрх юм.

Ямартай ч БНХАУ-ын эдийн засаг оны эхний улиралд буюу хөл хорионы үед 6.8 хувиар ширгэсэн ч оновчтой арга хэмжээний үр дүнд жилийн эцсээр эдийн засаг нь өсөлттэй гарах цөөн улсын нэг нь БНХАУ байх төлөвтэй байна.

БНХАУ-ын эрх баригчид Ковид-19 өвчний вакцины зах зээлд мөн идэвхтэй ажиллаж буй бөгөөд албан мэдээллээр одоогоор БНХАУ-д нийт 5 нэр төрлийн вакцины 3 дугаар шатны клиникийн туршилт үргэлжилж байгаа. Эдгээр вакцины заримыг нь Бразил, Индонези тэргүүтэй орнууд хэдийн авч, дотооддоо туршиж эхлээд байгаа.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс Ковид-19 өвчний вакциныг боловсруулж, туршихдаа маш хатуу чанарын шаардлага тавих, тээвэрлэлт, хүргэлтийг горимын дагуу зохион байгуулах зэрэг тодорхой чиглэл өгөөд байгаа.

Одоогоор БНХАУ-ын төрийн өмчит Синофарм компани болон Синовак Биотек компаниудын вакцинуудын талаарх мэдээлэл хамгийн ихээр гарч байгаа бөгөөд энэ хоёр вакцины туршилт одоогоор олон улсын хэмжээнд явагдаж, хилийн чанадад нийт 75,000 хүн дээр вакциныг туршиход эерэг үр дүн гарч эхлээд байна.

БНХАУ-ын эрх баригчид болон мэргэжлийн байгууллагууд цаашдаа дэлхий нийтэд вакцинаа нийлүүлэх түгээх боломжтой гэдгээ удаа дараа мэдэгдэж буй бөгөөд олон хүчин зүйлийг харгалзан үзвэл олон улсын, тэр дундаа хөгжиж буй орнуудын зах зээлд БНХАУ-ын зарим компанийн боловсруулсан вакцин хамгийн идэвхтэй нэвтрэх боломжтой юм.

1.2. БНСУ

БНСУ-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хангах чиглэлээр:

- Халдварын тархцыг хязгаарлахад дэвшилтэт технологийг голлон ашиглах чиглэл баримталсан
- Иргэдийн хөдөлгөөнийг хянахдаа төлбөрийн картын мэдээлэл, хяналтын камерын бичлэгийг голлон ашигласан
- Халдвар дэгдсэн байж болзошгүй бүсийн иргэдийг нийтээр нь, эрсдэлгүйгээр шинжилгээнд хамруулахын тулд иргэдийг машинаасаа шинжилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлсэн
- Машинаас хавьталд оролгүй шинжилгээнд хамруулах хөтөлбөр амжилттай хэрэгжсэний дараагаар явган хүнд зориулсан “шинжилгээний бүхээг” байгуулсан
- Тэгү, Бучеон хотууд болон Сөүл хотын Итаевон дүүрэгт гарсан томоохон дэгдэлтүүдийг хязгаарлахдаа хөл хорио тогтоолгүйгээр, иргэдийн хөдөлгөөнийг тодорхойлох, шинжилгээнд хамруулах гэсэн үндсэн хоёр аргыг ашигласан
- БНСУ-ын Засгийн газар амжилттай ажиллаж чадсаныг өмнөх цар тахал, халдварт өвчнүүдээс сургамж авч, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, хууль батлаад байсантай холбож байна
- Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ашиглаж, зарим томоохон аж ахуй нэгжүүд хамгаалалтын хувцас, хэрэглэл үйлдвэрлэсэн
- Иргэдэд халдвар авсан хүнтэй хавьталд орсон эсэхийг нь мэдээлэх аргыг цахим технологийн дэвшлийг ашиглан нэвтрүүлснээр иргэд шинжилгээнд хамрагдах шаардлагатай эсэхээ мэдэх боломжтой болсон

Эдийн засгийн чиглэлээр:

- Халдвар тархсан даруйд буюу 3 дугаар сард парламент төсвийн тодотгогол хийж, цар тахалтай тэмцэх, цар тахлаас үүдэн хохирол амссан аж ахуй нэгжүүдэд зээл, батлан даалт олгох, өрхөд дэмжлэг үзүүлэхэд 10.9 их наяд вон төсөвлөсөн
- Үүний дараагаар Засгийн газраас аж ахуй нэгжүүдэд зээлийн батлан даалт өгч эхэлсэн
- Жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг дэмжихийн тулд түрээсийн хөнгөлөлт хэрэгжүүлсэн

- Аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх уриалга гаргасан
- Бодлогын хүүг 0.75 хувь хүртэл бууруулсан.
- 4 дүгээр сард хоёр дахь төсвийн тодотголыг хийж гамшигийн удирдлагын чиглэлд 8 их наяд воныг, өрхийн амьжиргааг дэмжихэд 14.3 их наяд воныг төсөвлөсөн
- 7 дугаар сард гурав дахь тодотголоор ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн аюулгүй байдлыг хангах, халдварын тархцыг хянахад 35.1 их наяд воныг төсөвлөсөн
- Ажлын байрыг урт хугацаандаа нэмэгдүүлэх арга хэмжээг эхлүүлж, улсын эдийн засгийн бүтцийг өөрчилж, ногоон эдийн засаг бүхий орон болох хөтөлбөрийг эхлүүлсэн. Энэ хүрээнд 1.9 сая ажлын байр шинээр бий болсноор цар тахлын дараах урт, дунд хугацааны эдийн засгийн хүндрэлээс сэргийлэхэд эерэг нөлөөтэй
- 9 дүгээр сард парламентаас дахин нэг төсвийн тодотгол хийж, жижиг, дунд аж ахуй нэгжүүд, ажил эрхлэлтийг дэмжих, орлого багатай өрхийн амьжиргааг сайжруулахад 7.8 их наяд вон төсөвлөсөн.
- Ерөнхийлөгч Мүн Жэ Ин санхүүгийн тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг зарлаж, төрийн өмчит болон арилжааны банкнуудаас жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгох зээлийг дэмжих хөтөлбөр эхлүүлсэн

Дэлгэрэнгүй мэдээлэл:

БНСУ анх голомтот халдвар дэгдэх үеэс дэвшилтэт технологи ашиглаж халдварын тархцыг хязгаарлах аргыг голлон ашиглаж байв.

Тухайлбал коронавирусын батлагдсан тохиолдолд илрэх бүрт тухайн хүний төлбөрийн картын мэдээлэл болон хяналтын камерын бичлэг дээр тулгуурлан байршил, хөдөлгөөнийг нь тогтоож, халдварын тархцыг хянах арга үндсэндээ бүтэн сарын турш амжилттай хэрэгжсэн. Харин хоёрдугаар сарын 18-нд халдвар авсан иргэн Шинчеонжи урсгалын сүмийн нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцсон нь халдварын эхний томоохон дэгдэлт гаргахад хүргэсэн. Тухайн үед Өмнөд Солонгосын хэвлэлээр Шинчеонжи урсгалд өвчинг нүглийн илрэл гэж үздэг тул тус урсгалыг шүтэгчид мэргэжлийн байгууллагад мэдээлэл өгөх, хамтран ажиллахаас зайлсхийж байсан гэх мэдээлэл гарсан ч тус урсгалынхан энэ мэдээллийг үгүйсгэж байв. Анх БНХАУ-д халдвар дэгдсэн цагаас хойш Солонгосын Анагаах Ухааны нийгэмлэгээс хэд хэдэн Засгийн газартаа хандан БНХАУ-аас ирэх бүх зорчигч тээврийн хөдөлгөөнийг хаах, голомтот халдвараас сэргийлэх чиглэлд илүү идэвхтэй ажиллахыг уриалж байсан бөгөөд тухайн үедээ Засгийн газрыг хойрго ажиллаж байна гэх шүүмжлэл гарч байв.

Харин сүмийн цуглаанаас үүдэн Тэгү хотод халдвар голомтлон тархаж, бусад хотуудад ч халдвар тархаж эхэлсэн цагаас Өмнөд Солонгосын Засгийн газар шуурхай ажиллаж эхэлсэн бөгөөд тэгэхдээ нэн түрүүнд иргэдийг нийтээр нь шинжилгээнд хамруулах зарчмыг мөрдлөг болгожээ.

Энэ хүрээнд авч хэрэгжүүлсэн хамгийн оновчтой арга хэмжээ нь иргэдэд автомашинаасаа шинжилгээнд хамрагдах боломжийг олгох шийдэл байсан бөгөөд 2 сарын 23-наас эхлэн үүнд зориулсан төвүүд нээгдэж, иргэд олон хүнтэй хавьталд оролгүйгээр машинаасаа бүртгүүлэх, асуулга бөглөх, төлбөрөө төлөх, шинжилгээгээ өгөх боломжоор хангасан. Энэхүү шийдэл нь нэг хүний шинжилгээ өгөхдөө зарцуулах дундаж хугацааг эрс бууруулж, ердөө 10 минутын хугацааг зарцуулах боломжтой байхаар зохицуулсанд гол давуу тал нь оршиж байв.

Энэ болон оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлэх бусад арга хэмжээний үр дүнд халдварыг эрт, эрсдэл багатайгаар илрүүлсэн нь халдварыг хумихад ч халдвар авсан иргэдийг шуурхай эмчлэхэд ч шууд нөлөө үзүүлжээ.

Мөн гуравдугаар сарын дунд үеэс эхлэн явган хүнд зориулсан шинжилгээний бүхээгийг нэвтрүүлснээр энэ чиглэлд бүр ч томоохон дэвшил гарсан.

Өмнөд Солонгост халдварын эхний томоохон давлагааг үндсэндээ 20 орчим хоногийн дотор хумьж чадсан бөгөөд түүнээс хойш Бучеон хот, Сөүл Итаевон дүүрэг зэрэг тодорхой бүсүүдэд хэд хэдэн удаагийн халдвар гарахад мөн богино хугацаанд халдварыг хумьж чадсан.

Өмнөд Солонгосын Засгийн энэ хугацаанд хатуу хөл хорио тогтоохгүй байх чиглэлийг баримталж байсан бөгөөд сургууль, цэцэрлэг, кино театр зэрэг тодорхой үйлчилгээний газруудыг харьцангуй богино хугацаагаар бүсчилсэн байдлаар хаасныг эс тооцвол байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээнээс зайлсхийж байлаа.

Харин халдварын эхний дэгдэлтийн үед сурагчдын амралт тохиож байсан бөгөөд хичээлийн шинэ улирал 3 сарын 2-нд эхлэх товтой байсан. Харин голомтот халдвар дэгдсэнтэй холбоотойгоор нийтээрээ хичээлийн шинэ улирал эхлэх хугацааг 7 хоногоор хойшлуулж, зарим нь үргэлжлүүлэн сургалтаа цахим хэлбэрээр явуулах шийдвэр гаргасан.

Тус улс цар тахлын үед үр дүнтэй ажиллаж чадсаныг нэн түрүүнд өмнө нь Засгийн газрын холбогдох байгууллагуудын боловсруулсан төлөвлөгөөтэй холбон үзэх үндэстэй.

Тухайлбал 2015 онд МЭРС халдварт өвчин дэгдсэний дараагаар Өмнөд Солонгосын Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яам цар тахал, голомтот халдварын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан төлөвлөгөөг баталж, тухайн төлөвлөгөөгөө 5 жил тутамд шинэчлэхээр тусгасан байдаг. Тус улсад авч хэрэгжүүлсэн шинжилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, тодорхой технологийг ашиглаж иргэдийн хөдөлгөөний хянах шийдлүүд нь энэ төлөвлөгөөнд туссан байдаг.

Энэ хүрээнд 2018 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу халдварт өвчний үед авч хэрэгжүүлэх 48 багц арга хэмжээг тусгасан бөгөөд энэ чиглэлийн ажилд зориулж 32.5 сая америк долларыг төсөвлөсөн байжээ. Мөн 165 ерөнхий эмнэлгийг халдварт өвчний үед тусгай зориулалтаар ашиглахаар тусгасан байдаг.

Мөн Өмнөд Солонгост халдварын тархцыг хянах, хязгаарлах арга хэмжээ амжилттай хэрэгжихэд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлж зарим томоохон аж ахуй нэгжүүд хамгаалалтын хувцас, хэрэглэл үйлдвэрлэж Засгийн газарт нийлүүлж эхэлжээ.

Дээр дурдсан төлбөрийн картын мэдээлэл, хяналтын камерын бичлэг, ухаалаг утасны мэдээлэл зэргийг үндэслэн иргэдэд халдвар авсан хүнтэй хавьталд орсон эсэхийг нь мэдээлж байсан нь иргэдэд шинжилгээнд хамрагдах шаардлагатай эсэхээ мэдэх боломж олгосон.

Нөгөө талаасаа БНСУ-ын иргэдийн амьдралын хэвшил цар тахлын үед эерэг нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Тухайлбал Солонгосчууд агаарын бохирдол, бичил тоос шорооноос сэргийлэхийн тулд өдөр тутамдаа амны хаалт зүүж хэвшсэн байдал, хувийн ариун цэврээ өндөр төвшинд сахдаг зэрэг нь халдвар дэгдэхээс сэргийлсэн гэж үзэх үндэстэй.

Мөн Тэгү хотод анх халдвар дэгдсэний дараа албан ёсоор хөл хорио тогтоогоогүй байхад иргэдийн хөл хөдөлгөөн эрс багассан, олон иргэд сайн дураар цар тахлаас сэргийлэх ажилд оролцсон зэргийг ч судлаачид онцолжээ.

Товчхондоо Өмнөд Солонгосын цар тахлын үеийн үр дүнтэй бодлого, арга хэмжээг төлөвлөлт, бэлэн байдал, төсөв болон удирдлагын тогтолцоотой нь холбон тайлбарлаж байна.

Харин эдийн засгийн болон санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэхийн тулд БНСУ-ын авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ нь парламентаас нийт 4 удаа төсвийн тодотгол хийж, цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлийг давахад их хэмжээний мөнгө төсөвлөх шийдвэрүүд нь байлаа.

Тухайлбал анх халдварын эхний томоохон дэгдэлтийн үед буюу 3 дугаар сард цар тахалтай тэмцэхэд болон эдийн засгийн хүндрэлийг давахын тулд аж ахуй нэгжүүдэд зээл, батлан даалт олгоход зориулж 10.9 их наяд төсөвлөснөөс хойш өрхийн амьжиргааг дэмжих, гамшгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, зэрэг чиглэлд нийтдээ 60 орчим их наяд воныг төсөвлөөд байна Энэ бол мэдээж БНСУ санхүүгийн нөөц, бололцоо ихтэй улсынхаа хувьд авч хэрэгжүүлсэн, тус улсын онцлогт нийцсэн алхам гэж үзэж болно.

Үүнээс гадна эдгээр батлагдсан төсвийн хүрээнд БНСУ-ын Засгийн газар жижиг, дунд аж ахуй нэгжүүдэд зээл авахад нь батлан даалт олгох эхэлсэн нь тухайн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд томоохон түлхэц болсон. Мөн төрийн өмчит болон арилжааны банкнуудтай хамтарч жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зээл олгох нөхцөлийг шуурхайлах шийдвэрийг гаргасан. Үндсэндээ БНСУ-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс хамгийн онцлууштай нь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, шийдвэрүүд байсан. Тухайлбал тодорхой байршлуудад түрээсийн үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд аж ахуй нэгжүүдийн түрээсийн төлбөрийн 25 хувиар бууруулах, улсын хэмжээнд тухайн аж ахуй нэгжүүдийн даатгалын төлбөрийг 50 хувь хөнгөлөх зэрэг шийдвэрийг гаргажээ.

Мөн НӨАТ тэргүүтэй тодорхой нэр төрлийн татварыг 9 сарын хугацаагаар хойшлуулсан зэрэг нь жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг дэмжихэд түлхэц үзүүлжээ.

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй тул Засгийн газраас ногоон эдийн засагт шилжих хөтөлбөрийг эхлүүлэх замаар урт хугацаанд ажлын байрыг нэмэгдүүлэх, банк, эрчим хүчний салбарт тодорхой шинэчлэл хийх шийдвэрийг гаргасан.

1.3. Вьетнам

Вьетнам улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хангах чиглэлээр:

- Улсын хэмжээнд хатуу хөл хорио тогтоохоос зайлсхийсэн ч анх халдвар тархах үеэс эхлэн Ковид-19 өвчний талаар дуудлага хүлээн авах болон зөвлөгөө өгөх утасны шугамыг нээсэн
- Бусад улс орнуудтай харьцуулахад маш эрт эрсдэлийн үнэлгээ хийж, хилээр нэвтрэх хүмүүсийн халууныг шалгах журмыг нэвтрүүлсэн
- Үндэсний хэмжээнд халдварт өвчинтэй тэмцэх хороог тусгайлан байгуулсан
- Халдвар дэгдсэн бүсүүдэд тосгоноор нь хөдөлгөөн хязгаарлах, халдвар авсан хүмүүсийг тусгаарлах арга хэмжээг авсан
- Хөл хорионы үед тухайн тосгонуудыг бүхэлд нь шинжилгээнд хамруулсан
- Энэ төрлийн буюу харьцангуй хязгаарлагдмал хүрээг хамрах хөл хориог нийт 7 удаа тогтоосон бөгөөд цаг хугацааны хувьд 1 хоногоос 1 сар хүртэл харилцан адилгүй хугацаанд үргэлжилсэн
- Эрсдэл өндөртөйд тооцогдох улсуудаас ирэх иргэний тээврийн хөдөлгөөнийг маш шуурхай шийдвэр гаргаж хязгаарлаж байгаад дэлхий даяар халдвар тархах үед хилээ бүрэн хаасан
- Хилийн чанадаас ирсэн хүмүүсийг 14 хоног заавал тусгаарлах, гэхдээ тусгаарлалтыг үнэ төлбөргүй байхаар шийдвэрлэсэн

- Улсын хэмжээнд хатуу хөл хориог журамлан тогтоогоогүй ч зай барих, хөдөлгөөнийг тодорхой хэмжээнд хязгаарлах удирдамж гаргасан
- Зарим аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг богино хугацаагаар буюу 2 долоо хоног хязгаарласан
- Ковид-19 өвчний оношлуурыг дотооддоо бүтээхийг дэмжиж, тэр нь үр дүнд хүрч чадсан

Эдийн засгийн чиглэлээр:

- Цар тахлаас үүдэн үйл ажиллагаа нь доголдсон аж ахуй нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлж, зарим татварыг чөлөөлж, заримыг хойшлуулахад нийтдээ 1.16 тэрбум доллартой тэнцэх хэмжээний төсөв зарцуулсан
- Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийг харилцан адилгүй хугацаагаар хойшлуулсан
- Төрийн зарим үйлчилгээний хураамжийг 25-50 хувиар бууруулсан
- Төв банк бодлогын хүүг 0.25-1 хувиар бууруулсан
- Зарим арилжааны банк зээлийн хүүгээ буулгасан бөгөөд эдгээр банканд төрөөс тодорхой дэмжлэг үзүүлсэн
- Үндэсний хэмжээнд үйлчилж байсан хөл хөдөлгөөнийг хязгаарлах удирдамжийн хугацаа дуусахаас өмнө эдийн засгийн үйл ажиллагааг сэргээх тодорхой дарааллыг гаргасан
- Эмзэг давхаргын иргэдэд 3 сар хүртэлх хугацаагаар мөнгөн тэтгэмж олгосон

Дэлгэрэнгүй мэдээлэл:

Судалгааны өмнөх хэсэгт дурдсанчлан цар тахлын үед Ковид-19 өвчний улмаас нас барсан хүний тоог нийт хүн амын тоотой харьцуулж үзэхэд цар тахалтай хамгийн амжилттай тэмцсэн улсуудын нэг нь Вьетнам юм.

Тус улс Өмнөд Солонгосын нэгэн адилаар хатуу хөл хорио тогтоолгүйгээр халдварыг амжилттай хянаж чадсан бөгөөд цар тахлын үед шуурхай, оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд цар тахлыг хамгийн амжилттай хянаж байгаа улсуудын тоонд багтаж байна.

Вьетнамд 1 сарын 23-нд Ковид-19 өвчний эхний халдвар бүртгэгдсэн даруйд тус улсын мэргэжлийн байгууллагууд энэ өвчний талаар дуудлага хүлээн авах, зөвлөгөө өгөх хоёр шуурхай утасны дугаарыг ажиллуулж эхэлжээ.

Зарим улс орноос ялгаатай нь Вьетнамд голомтот халдвар дэгдсэн даруйд Төв Засгийн газар халдварыг хянах, хязгаарлах асуудлыг гардан хариуцаж, голлох шийдвэрүүдийг гаргах чиглэл баримталсан. Үүнийг Вьетнамын төрийн удирдлагын болон гамшигийн удирдлагын тогтолцоотой шууд холбоотой гэж үзэх үндэстэй.

Тиймээс анхны халдвар бүртгэгдсэнээс 7 хоногийн дараа Үндэсний хэмжээнд халдварт өвчинтэй тэмцэх хороог тусгайлан байгуулж, тус хороо хоёр хоног тутам хуралдахаар зохицуулсан. Энэ хороо халдварыг хянах, хязгаарлах асуудлаар голлох шийдвэрийг гаргаж байсан бөгөөд халдварын эхний үед хэд хэдэн тосгон, суурин газарт халдвар голомтлон дэгдэх эрсдэл үүссэнийг хязгаарлаж чадсан.

Эхлээд нийслэл Ханой хотоос холгүй байрлах Сон Лой гэх тосгонд халдвар дэгдэх эрсдэл үүссэн тул тус тосгон дахь халдвар авсан хүмүүсийг тусгаарлаж, тосгонд бүхэлд нь 21 хоногийн турш хөдөлгөөн хязгаарлажээ. Энэ хугацаанд тухайн тосгоны бүхэлд нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан бөгөөд тэр цагаас хойш 2 сар орчмын дотор 7 удаа бүсчилсэн байдлаар хөл хорио тогтоосон бөгөөд үүнээс хамгийн олон хүнийг хамарсан нь 10,000 хүнийг хамарч байсан бол хамгийн цөөн хүнийг хамарсан нь 150 хүнийг хамарсан хөл хорио байв. Цаг хугацааны хувьд эдгээрээс хамгийн богино нь 1 хоног, хамгийн удаан нь 1 сар орчим үргэлжилжээ. Үүний үр дүнд Вьетнамын Засгийн газар халдварын давлагаа дэгдэх хэд хэдэн удаагийн эрсдэлээс хамгаалж чадсан.

Мөн Вьетнамын Засгийн газар анх цар тахлын тухай мэдээлэл гарч эхэлсэн даруйд мэргэжлийн байгууллагууд эрсдэлийн үнэлгээ хийсний үндсэн дээр нэн түрүүнд хилээр нэвтрэх хүмүүсийн халууныг шалгах, Цагаан сарын амралтыг сунгах шийдвэрүүд гаргасан.

Вьетнамын Засгийн газар олон улсын иргэний агаарын тээврийн хөдөлгөөний хязгаарлахдаа хилээ бүрэн хаах бус эрсдэл өндөртэй улс орнуудтай нэн даруй хилээ хаах чиглэлийг баримталсан нь мөн оновчтой гэж үзэх үндэстэй.

Тухайлбал 1 сарын 30-наас Хятадын иргэдэд виз олгохоо зогсоож, Ухань хот дахь дэгдэлтийн үед буюу 2 сарын 1-нд агаарын хилээ хааж, 2 сарын 5-нд хуурай газрын хилээ хаажээ.

Харин Европоос ирсэн хүнээс халдвар илэрч, халдварын давлагаа үүсэх эрсдэл үүссэн даруйд буюу гуравдугаар сарын 15-нд Их Британи, Европын холбооны орнууд болон АНУ-тай мөн хилээ хаасан.

Улмаар дэлхий даяар нөхцөл байдал хүндэрч эхэлсэн тул 3 сарын 22-нд хилээ бүрэн хаах шийдвэр гаргаж байв.

Түүнчлэн хоёрдугаар сараас эхлэн хилийн чанадаас ирсэн хүмүүсийг 14 хоногийн хугацаанд заавал тусгаарлах журмыг мөрдүүлж эхэлсэн. Вьетнамд мөрдүүлсэн тусгаарлалт нь үнэ төлбөргүй байсан бөгөөд энэ хугацааны шинжилгээ, хоолыг Вьетнамын Зэвсэгт хүчин болон орон нутгийн удирдлага хариуцаж байжээ.

Ингэснээр Вьетнамын Засгийн газар Ковид-19 өвчний зөвөөрлөгдөн ирсэн тохиолдлуудыг бүрэн хянах боломж бүрдсэн бөгөөд дотооддоо халдвар алдах эрсдэлээс сэргийлсэн.

Вьетнам улсад одоог хүртэл үндэсний хэмжээнд хатуу хөл хорио тогтоогоогүй байна. Харин тус улсын Ерөнхий сайд 4 дүгээр сарын 1-нд улсын хэмжээнд 2 долоо хоногийн туршид зай барих удирдамжийг гаргасан бөгөөд энэхүү удирдамжийн дагуу иргэдэд гэрээс гарахгүй байх, бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа түр зогсоох чиглэл өгч, нийтийн тээврийн хөдөлгөөнийг хязгаарлажээ. Энэ удирдамжийг зарим том хотод хэрэгжих нөхцөлтэйгөөр дахин 7 хоног сунгасан.

Энэхүү шийдвэрийн дараагаар дотоодод дамжсан халдвар бүртгэгдэлгүй 2 долоо хоног болсон тул сургууль болон бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг эргэн сэргээсэн.

Мөн цар тахлын явцад иргэдийг мэдээллээр хангахад онцгой анхаарал хандуулж байсан бөгөөд Эрүүл мэндийн яамнаас Ковид-19 өвчний шинж тэмдэг болон сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээллийг тогтмол мессеж -ээр илгээж байна.

Түүнчлэн цар тахалтай амжилттай тэмцэх байгаа бусад улс орнуудын нэгэн адилаар шинжилгээний хүчин нэмэгдүүлэхэд онцгой анхаарч буй бөгөөд төрийн мэдлийн 4 судалгааны байгууллагын бүтээсэн оношлуур холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авч хэрэглээнд нэвтрээд байна.

Шинжилгээний хүчин чадлыг авч үзэхэд Вьетнам 1 дүгээр сард ердөө хоёр цэгт шинжилгээ авч байсан бол тавдугаар сар гэхэд 120 цэгт байршил авч эхэлжээ.

Эдийн засгийн хувьд Вьетнамын Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс хоёр арга хэмжээг голлон онцолж болох юм.

Тухайлбал нэн түрүүнд Вьетнам улс эдийн засгийн үйл ажиллагааг дэмжихийн тулд нийтдээ ДНБ-ны 3.6 хувьтай тэнцэх хэмжээний төсвийг зарцуулаад байна. Энэ арга хэмжээний хүрээнд зарим аж ахуй нэгжийн НӨАТ, нийгмийн даатгал болон бусад татвар, түүнчлэн түрээсийн төлөлтийг хөнгөлж, хойшлуулж, төрийн зарим үйлчилгээний хураамжийг 25-50 хүртэлх хувиар бууруулжээ.

Хоёрдугаар Вьетнамын Засгийн газар иргэд болон зарим аж ахуй нэгжүүдэд шууд бэлэн мөнгө олгох шийдвэрийг гаргасан.

Энэ хүрээндээ нийтэд 36 их наяд Вьетнам донг буюу 1.5 тэрбум орчим долларыг эмзэг давхаргыг өрхүүдэд нэг өрхөд 3 хүртэлх сарын хугацаагаар олгох зарчмаар халамж хэлбэрээр тараасан. Энэ хөтөлбөрийн хүрээнд нийт хүн амын 10 гаруй хувь нь ямар нэг байдлаар ашиг шим хүртсэн гэж албаны их сурвалжууд тайлбарлаж байгаа бөгөөд 10 дугаар сарын байдлаар төсөвлөсөн нийт мөнгөний 1/3 орчмыг тараагаад байна.

Мөн Вьетнамын эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа тогтмол, хурдацтай сэргэхэд халдварыг амжилттай хязгаарлаж буй тул дахин дахин хөл хорио тогтоох шаардлагагүй байгаа нь чухал нөлөө үзүүлж байна

Түүнээс гадна Засгийн газар үндэсний хэмжээнд үйлчилж байсан бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлах зөвлөмж, уриалгын дараагаар бизнесийн үйл ажиллагааг сэргээхдээ нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ нийтэд танилцуулснаар бизнес эрхлэгчид үйл ажиллагаа нь эргэн сэргэх хугацааг эртнээс тооцоолох боломж бүрдсэн.

1.4. Япон

Япон Улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- Цар тахлын голомтоос иргэдээ татан авахад маш их ач холбогдол өгсөн
- Халдвар хүнээс хүнд дамждаг нь тогтоогдсон даруйд Ерөнхий сайд Абэ Шинзо цаашид энэ чиглэлээр шийдвэр гаргахдаа мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг удиртгал болгохоо зарласан
- Цар тахлын үеийн бүх арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэхэд голлон анхаарсан
- Хуулийн дагуу шинэ төрлийн коронавирусийг “халдварт өвчин” гэж албан ёсоор тодорхойлсноор Засгийн газар тус өвчний халдвар авсан иргэдийг хүчээр эмчилгээнд хамруулах эрх зүйн үндэс бүрдсэн
- Мөн Тусгаарлалтын тухай хуулийг үндэслэн тус өвчнийг “тусгаарлах шаардлагатай халдварт өвчин” гэж тодорхойлсноор халдвар авсан байж болзошгүй иргэдийг тусгаарлах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.
- Иргэддээ хандан нэр заасан улс орнууд руу аялахгүй байх уриалгыг гаргаж байсан. Анх БНХАУ руу аялахгүй байхыг уриалсан бол 3 дугаар сарын сүүл үе гэхэд дэлхийн улс орнуудын 30 гаруй хувь руу нь аялахгүй байхыг уриалаад байв

- *Хувийн хэвшилтэй хамтран ажиллаж шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх чиглэл барьсан*
- *Шинжилгээнд хамрагдах цагийг утсаар авахаар зохицуулсан*
- *Эмчилгээнд ямар эм ашиглахаар төлөвлөж буйгаа нийтэд зарлах чиглэл барьж байгаа*
- *Ерөнхий сайдын дэргэд хоёр ажлын хэсэг ажилласны нэг нь эрдэмтдийн нөгөө нь Засгийн газар, орон нутгийн удирдлагуудын зөвлөл байна*
- *Цар тахал хамгийн дээд цэгтээ хүртэл тархах үед муж, хот тус бүрт халдвар авах, хүнд өвчлөх боломжит хүний тоог урьдчилан тооцоолж, тухайн тоогоор эмнэлгийн ор бэлтгэсэн*
- *Эхлээд улсын зарим хэсэгт, дараа нь улс даяар онц байдал зарласан*
- *Онц байдал зарлахдаа иргэдэд хандан уриалга гаргасан ч хатуу хөл хорио тогтоогоогүй. Онц байдал 1 сар хагасын хугацаанд үргэлжилсэн*
- *Олимп -ийн наадмыг болон бусад олон нийтийн арга хэмжээг хойшлуулсан*
- *Иргэдийн хөл хөдөлгөөнийг хянах аппликейшн бүтээж, иргэдийг сайн дурын үндсэн дээр ашиглахыг уриалсан*
- *9 дүгээр сард орон даяар бэлэн байдлын зэргийг буулгасан ч 11 сард дахин дэгдэлт гарахад зарим хэсэгт эргэн нэмэгдүүлсэн*

Эдийн засгийн чиглэлээр:

- *6 дугаар сараас муж хоорондын хөдөлгөөнийг сэргээсэн*
- *Караоке, хоолны газар зэрэг үйлчилгээний газруудыг цагийн хязгаартай ч ажиллуулах чиглэл барьсан*
- *4 дүгээр сард ДНБ-ыхээ 20,9 хувьтай тэнцэх хэмжээний гамшгийн үеийн эдийн засгийн багц хөтөлбөрийг баталсан нь дэлхийн дунджаас онцгой өндөр үзүүлэлт*
- *Энэ хүрээнд ажлын байр, аж ахуй нэгжүүдийг хамгаалахад ихэнх төсвийг зарцуулсан*
- *5 дугаар сард мөн ижил дүнтэй төсвийг баталсан*
- *Тус хөтөлбөрийн хүрээнд иргэдэд болон зарим аж ахуй нэгжид тэтгэмж хэлбэрээр олгож, заримыг нь орон нутгийн удирдлагуудын мэдэлд шууд шилжүүлсэн*
- *Зарим төрлийн татвар болон нийгмийн даатгалын төлбөрийг хойшлуулсан*
- *12 дугаар сард ДНБ-ийхээ 13.1 хувьтай тэнцэх мөнгөн дүн бүхий хөтөлбөрийг баталж аж ахуй нэгжүүдийг технологийн дэвшил ашиглахыг дэмжих, зарим аж ахуй нэгжид хөнгөлөлттэй зээл олгох болон урт хугацааны эдийн засгийн эрсдэлээс сэргийлэхэд ашиглахаар төлөвлөж байна*
- *Цар тахлын нөхцөл байдал харьцангуй тогтворжих үед аялал, жуулчлалын салбараа дэмжихийн тулд Засгийн газраас иргэдээ аяллаар явахыг уриалсан хөтөлбөр зарласан. Энэ хүрээндээ аяллаар явсан иргэдийн сууцны зардлын 35 хувийг төрөөс хариуцаж, хоолны болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүний зардлыг нь 15 хувиар хөнгөлсөн /Халдварын 3 дахь давлагаа 11 дүгээр сард дэгдсэний дараа энэ хөтөлбөрийг цуцалсан/*

Япон Улсад Ковид-19 өвчний улмаас амиа алдсан хүний тоог нийт хүн амтай нь харьцуулан авч үзэхэд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын дунд хамгийн бага байна.

Японы хүн амд Ковид-19 өвчний эмзэг бүлэг буюу ахмад настнуудын эзлэх хувь өндөр атал энэ тоо бага байгаа нь Япон Улсад цар тахалтай амжилттай тэмцэж чадсаныг илтгэж байна. Үүнийг Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс гадна Япончуудын амьдралын хэв маяг, эрүүл мэндийн тогтолцоо сайн тул иргэдийн дархлаа өндөр байдагтай нь холбон авч үзэж байна.

Японы Засгийн газрын зүгээс халдварын эхний үед нэн түрүүнд цар тахлын эхний томоохон голомт болох БНХАУ-ын Хубэй мужаас иргэдээ татан авахыг чухалчилсан.

Нөгөө талаас Японы Засгийн газар хилээр нэвтрэх иргэдийн биеийн дулааныг хэмжих зэрэг тодорхой журмыг нэн түрүүнд мөрдүүлсэн билээ.

Харин шинэ төрлийн коронавирус хүнээс хүнд халддаг нь тогтоогдсоны дараагаар Японы Ерөнхий сайд Абэ Шинзо Засгийн газрын шуурхай хуралдаан зарлаж Үндэсний Халдварт өвчин судлалын хүрээлэнгийн санал, зөвлөмж дээр үндэслэн холбогдох шийдвэр гаргахаа зарласан. Улмаар 1 сарын 27-нд Японы Халдвар өвчний хяналтын тухай хуульд заасны дагуу шинэ төрлийн коронавирусийг “халдварт өвчин” гэж албан ёсоор тодорхойлсноор Засгийн газар тус өвчний халдвар авсан иргэдийг хүчээр эмчилгээнд хамруулах эрх зүйн үндэс бүрдсэн. Мөн Тусгаарлалтын тухай хуулийг үндэслэн тус өвчнийг “тусгаарлах шаардлагатай халдварт өвчин” гэж тодорхойлсноор халдвар авсан байж болзошгүй иргэдийг тусгаарлах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Товчхондоо Японы Засгийн газар цар тахалтай тэмцэх үйл явц нь ямар нэг байдлаар хүний эрх, эрх зүйн зөрчил дагуулахаас сэргийлж, нэн түрүүнд эрх зүйн хүрээнд халдварт өвчинтэй тэмцэх боломжийг бүрдүүлсэн нь жишиг арга хэмжээ мөн.

Улмаар Засгийн газрын яамдын өндөр албан тушаалтнуудаас бүрдэж, Ерөнхий сайдын шийдвэрт шууд нөлөөлөх эрх бүхий ажлын хэсгийг байгуулж, Хубэй мужаас ирсэн гаднын иргэдийг нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргасан.

Цар тахлын эхэн үед Японы Засгийн өмнө учирсан эхний томоохон сорилт нь тус улсын эрэг дээр байсан “Diamond Princess” хөлөг дээр дэгдэлт гарсан явдал байсан бөгөөд Японы Засгийн газар хөлгийг тусгаарлаж, хөлөг дээрх хүмүүсийг шинжилгээнд хамруулж, халдвар авсан иргэдийг Япон улс руу нэвтрүүлж эмчлэх бодлого баримталсан.

Японы Засгийн газрын авч хэрэгжүүлсэн энэ алхам нь хөлөг дээр дэгдсэн халдвар тус улсад дэгдэхээс сэргийлсэн, оновчтой алхам байсан гэж мэргэжилтнүүд дүгнэж байна.

Хөлөг онгоц дээр дэгдэлт гарсны зэрэгцээ Япон Улсад ч халдвар дэгдэж эхэлсэн тул тус улсын Засгийн газар тогтоон барих бодлогоо өөрчилж, урьдчилан сэргийлэх, эмчлэх бодлого хэрэгжүүлж эхэлжээ.

Энэ хүрээнд Үндэсний Халдварт өвчин судлалын хүрээлэн болон засаг захиргааны нэгжүүдийн нийтийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах тогтолцоог бий болгож, үндэсний хэмжээнд иргэдийг шинжилгээнд хамруулах ажлыг эхлүүлж, шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх алхам авч хэрэгжүүлжээ.

Цаашлаад Японы Засгийн газар хувийн компаниудтай цар тахлыг оношлох чиглэлд хамтран ажиллаж, шинжилгээнд хамрагдах боломжтой хүмүүсийн жагсаалтыг шат дараатайгаар өргөтгөсөн.

Улмаар улсын хэмжээнд Ковид-19 өвчний талаар зөвлөгөө өгөхийн зэрэгцээ иргэдэд утсаар шинжилгээнд хамрагдах цаг олгох 536 төвийг нээж ажиллуулжээ.

Халдварын эхэн үед иргэдийн дунд ханиадны шинж тэмдэг илэрсэн иргэд өөрийгөө Ковид-19 өвчний халдвар авсан гэж итгэж, шинжилгээнд хамрагдах хүсэлт гаргаснаар эмнэлгүүдийн ачаалал нэмэгдэх эрсдэл үүссэн учраас ямар шинж тэмдэг илэрсэн нөхцөлд шинжилгээнд хамруулах талаар нарийвчлан тусгасан зөвлөмжийг тус улсын Эрүүл мэндийн яамнаас гаргажээ.

Япон Улс мөн бусад улс орнуудаас өмнө буюу 2 сарын 22-нд Ковид-19 өвчний эмчилгээнд ашиглах эмийн талаарх мэдээллээ нийтэд ил болгож, Эрүүл мэндийн сайд Кацунобу Като Фүжифилм компанийн боловсруулсан фавипиравар гэх эмийг эмчилгээнд ашиглах төлөвлөгөөтэй байгаагаа зарлажээ.

Японы Ерөнхий сайд, Засгийн газрын дэргэд хоёрдугаар сараас төрийн өндөр албан тушаалтнуудаас бүрдэх ажлын хэсэг болон вирус судлалын эрдэмтдээс бүрдэх шинжээчдийн зөвлөл ажиллаж байсан нь цар тахлын хянах, хязгаарлах асуудлаар шийдвэр гаргахад онцгой нөлөө үзүүлсэн гэж үзэхэд хүргэж байна.

Хоёрдугаар сарын сүүл үеэс Японы Засгийн газар цар тахлаас сэргийлэхийн тулд ханиадны хөнгөн шинж тэмдэг илэрч буй иргэдэд эмнэлэгт ирэлгүйгээр, гэртээ амарч, өөрийгөө эмчлэхийг оролдох, ужиг өвчтэй болон ахмад настай иргэдэд онц шаардлагагүй бол эмнэлэгт ирэхгүй байж, утсаар эмчилгээ бичүүлэг зөвлөмж өгч эхэлсэн.

Мөн Японы томоохон хотуудад иргэдийн бөөгнөрөл үүсэх магадлал өндөр байдаг тул аж ахуй нэгжүүдэд ажилчдаа гэрээс ажиллах нөхцөл бүрдүүлэх, орон нутгийн засаг захиргаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх чиглэлд өгсөн.

Түүнчлэн сургуулиудын амралтын хугацааг татаж, 3 сарын 2-ноос эхлүүлэхээр шийдвэрлэсний зэрэгцээ ажилчид нь хүүхдээ харахын тулд чөлөө авснаас үүдэн үйл ажиллагаа нь доголдсон аж ахуй нэгжүүдэд өгөх мөнгөн тусламжийн санг байгуулжээ.

Харин гуравдугаар сард Японы Эрүүл мэндийн яам муж тус бүрт халдвар авах магадлалтай хүний тоог тооцоолон гаргаж, муж, засаг захиргааны нэгжийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагуудад тухайн тоонд нийцүүлэн эмнэлгийн ор бэлтгэх үүргийг өгсөн.

Жишээлбэл энэхүү тооцооллоор Токио хотод халдвар оргилдоо хүрвэл өдөр тутамд гэрээр эмчлүүлэх боломжтой 45,400 хүн байх бол хэвтэж эмчлүүлэх шаардлагатай 20,500 өвчтөнг эмнэлэгт хүлээн авна, түүний 700 орчим нь хүнд өвчтөн байна гэж тооцжээ. Харин Хоккайдод өдөрт эмнэлэгт ирэх ч гэрээр эмчлүүлэх боломжтой өвчтөний тоо 18,300, хэвтэж эмчлүүлэх өвчтөний тоо 10,200 хүрч, түүнээс 340 нь хүнд өвчтөн байна гэж тооцож байв.

Японы хууль тогтоомжийн дагуу Төв Засгийн газар аль нэг хотод хөл хорио тогтоох эрхгүй, нөгөө талаасаа төр иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах эрхгүй учраас бусад орнуудад тогтоосон шиг хатуу хөл хорио тогтоох боломж байгаагүй. Харин Засгийн газар иргэдээсээ хамтран ажиллахыг “хүсэх” эрх бий.

Энэ зохицуулалт Япон улсыг халдварыг хяналтаас алдахад хүргэнэ гэх таамаг зонхилж байсан. Гэвч Япон Улсын Засгийн газар эрх зүйн хүрээнд оновчтой ажиллаж чадсаны үр дүнд хөл хорио тогтоогоогүй ч халдварын давлагааг амжилттай хязгаарласаар байна.

3 дугаар сарын сүүл үе болон 4 дүгээр сард нийслэл Токио хот болон улсын бусад хэсгүүдэд халдвар тархах эрсдэлт нөхцөл үүсэх бүрт орон нутгийн удирдлагууд иргэддээ хандан шаардлагагүй нөхцөлд олон нийтийн газраар явахгүй байх, өөрийгөө хамгаалахыг уриалж байлаа.

Мөн тухайн үед эмнэлгүүдийн ачаалал нэмэгдэхээс сэргийлж Засгийн газар халдвар авсан ч ноцтой шинж тэмдэг илрэхгүй байгаа өвчтөнүүдийг гэртээ байх эсвэл Японы Өөрийгөө хамгаалах хүчин болон орон нутгийн удирдлагуудын бэлтгэсэн байранд байхыг уриалсан.

Харин 4 сарын 7-нд Ерөнхий сайд Абэ бүрэн эрхийнхээ хүрээнд Токио хот болон 6 мужид сарын хугацаатай онц байдал зарлаад, 4 сарын 16-нд энэ шийдвэрээ өргөжүүлж, үндэсний хэмжээнд онц байдал зарласан. Японы Засгийн газар 5 сарын эхээр онц байдлыг 1 сараар сунгасан ч сарын дунд үеэс эхлэн зарим мужид онц байдлыг цуцалж эхэлсэн билээ.

Үндсэндээ Японы Засгийн газрын цар тахлын үед иргэдийг хөл хөдөлгөөн, эрхийг хязгаарлах арга хэмжээ нь “уриалга”-ын зарчмаар явагдсан бөгөөд, тухайлбал онц байдлын иргэдийг гэрээс гарахгүй байхыг уриалсан, дэлхийн бусад улсад халдвар дэгдэх үед нэр заасан улс орнууд руу зорчихгүй байхыг уриалсныг дурдаж болно.

Мөн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих, ажилгүйдэл газар авах, өрхийн амьжиргаа буурахаас сэргийлж зарим өрхөд тэтгэмж олгох шийдвэрийг 5 дугаар батлагдсан багц хөтөлбөрт тусгасан.

Харин 4 дүгээр сард батлагдсан эхний хөтөлбөрөөр ДНБ-ийхээ 20.9 хувьтай тэнцэх хэмжээний хөтөлбөрөөр ажлын байр, аж ахуй нэгжүүдийг хамгаалахад зориулагдсан.

Одоог хүртэл Японы эрх баригчдын баталсан цар тахлын үед улсын эдийн засгийг дэмжих зорилготой 3 удаагийн хөтөлбөр нь нийтдээ тус улсын өнгөрсөн оны ДНБ-ий 50 гаруй хувьтай тэнцэж байна.

Дээр дурдсан хоёр хөтөлбөр тус бүр нь өнгөрсөн оны ДНБ-ийнх нь 20.9 хувьтай дүйх бол сүүлд 12 дугаар сард 76.3 их наяд иен буюу 708 тэрбум долларын багц хөтөлбөрийг баталсан нь ДНБ-ийнх нь 13 орчим хувьтай дүйнэ.

Эхний хоёр хөтөлбөрөөр Японы Засгийн газар иргэд болон цар тахлаас үүдэн хохирол амссан зарим аж ахуй нэгжид мөнгөн тэтгэмж олгож, зарим төрлийн татвар болон нийгмийн даатгалын төлбөрийг хойшлуулж, нийтийн өмчийн болон хувийн байгууллагуудаас аж ахуй нэгжүүдэд зээл олгоход түлхэц үзүүлэх алхмуудыг авч хэрэгжүүлсэн.

Харин 12 дугаар сард батлагдсан сүүлийн багц хөтөлбөр нь ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих, дижитал шилжилтийг санхүүжүүлэх зэрэг шинэ Ерөнхий сайд Суга Ёшихидэгийн эдийн засгийн бодлогыг түргэсгэх замаар урт хугацааны эдийн засгийн хүндрэлээс сэргийлэхэд чиглэж байна. Түүнчлэн Японы ихэнх орон нутгийн удирдлагууд бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг аль болох зохих түвшинд үргэлжлүүлэхийг эрмэлзэж байсан бөгөөд караоке, хоолны газар зэрэг Японд түгээмэл байдаг үйлчилгээний газруудыг цагийн хязгаартай ч ажиллуулах чиглэл баримталж байлаа.

Япон Улсад 6 дугаар сараас нөхцөл байдал тогтворжиж эхлэх үеэс Засгийн газар эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих бодлого баримталж, нөхцөл байдал тогтвортой хэвээр 3 сар орчмын хугацаа өнгөрөхөд буюу 9 дүгээр сард бэлэн байдлын зэргийг буулгасан.

Тэр дундаа цар тахлын үед хамгийн хүнд цохилт амссан аялал жуулчлалын салбарыг дэмжих бодлого баримталж эхэлсэн. Энэ хүрээнд “Аяллаар яв” хэмээх кампанит хөтөлбөрийг эхлүүлж, дотоодын жуулчлалыг дэмжих уриалга гаргасан билээ.

Энэхүү хөтөлбөрийг долоо дугаар сараас эхлэн зарлаж, аялж буй иргэдийн сууцны зардлын 35 хувийг төрөөс хариуцаж, хоолны болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүний зардлыг 15 хувиар хөнгөлөх арга хэмжээг улсын хэмжээнд авч хэрэгжүүлсэн. Ингэснээр аялах үед гардаг нийт зардал 50 орчим хувиар буурах боломж бүрдсэн.

Японы Засгийн газрын аялал, жуулчлалын салбарыг тусгайлан дэмжих энэхүү бодлого нь богино хугацаанд үр дүнд хүрч, улмаар Засгийн газраас сунгасан боловч 11 дүгээр сард улсын хэмжээнд халдварын давллагаа дахин дэгдэхэд нийгэмд энэ хөтөлбөрөөс үүдэн халдвар дэгдсэн гэх сэжиг таамаг гарч эхэлсэн.

Улмаар 12 дугаар сард Японы Засгийн газар энэ хөтөлбөрийг цуцалсан боловч аялал, жуулчлалын салбарыг дэмжих оновчтой шийдэл байсныг нь үгүйсгэх аргагүй.

1.5. Шинэ Зеланд

Шинэ Зеланд улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- ДЭМБ-ын холбогдох заавар, зөвлөмжийг маш сайн дагаж биелүүлсэн.
- Үүнд өмнө нь батлагдсан байсан цар тахалтай тэмцэх төлөвлөгөө чухал нөлөө үзүүлсэн гэж тооцож байна
- Ковид-19 өвчнийг “Халдварт болон мэдэгдвэл зохих” өвчин гэж албан ёсоор зарласнаас хуулийн дагуу бүх шатны эмнэлгийн байгууллагууд сэжигтэй тохиолдол гарах бүрт холбогдох байгууллагад мэдэгдэхээр хуульчилсан
- Халдвартай улс орнуудаас нислэг хүлээн авахаа харьцангуй эрт зогсоож байсан.
- Хамгийн эхэнд БНХАУ-аас ирсэн хүмүүсийг хилээр нэвтрүүлэхийг хориглосон. Гэхдээ БНХАУ-аас гарснаасаа хойш гуравдагч улсад 14-өөс дээш хоногийн хугацаанд байсан хүмүүсийг нэвтрүүлэхээр зохицуулсан.
- 3 сарын дунд үед гэхэд улсынхаа иргэн болон байнга оршин суудаг гаднын иргэдээс бусад хүнийг хилээр нэвтрүүлэхийг бүрэн хориглосон
- Гаднаас ирсэн иргэд болон байнга оршин суугчдад өөрийгөө тусгаарлах шаардлага тавьсан
- 3 сарын 25-наас 4 сарын 27 хүртэл улсын хэмжээнд 4 дүгээр төвшний бэлэн байдал зарлаж, хөл хорио тогтоосон
- 4 дүгээр зэргийн бэлэн байдлаас гадна Иргэний хамгааллын сайдын шийдвэр шийдвэрээр улсын хэмжээнд онц байдал зарлаж нийт 3 удаа, тус бүр 7 хоногийн хугацаагаар сунгасан
- Хөл хорионы үед буюу 4 сарын 10-наас 5 хотод үйл ажиллагаа явуулдаг зочид буудлуудтай гэрээлж, тухайн байршлуудад иргэдийг тусгаарлах журмыг мөрдүүлсэн. Тусгаарлалтын хугацаа 14 хоног байсан.
- Хөл хорио үр дүнд хүрч чадсан тул хөл хорио сулласнаас хойш бэлэн байдлын зэргийг ойр, ойрхон хугацаанд буулгаж чадсан
- 6 сарын 8 гэхэд буюу хатуу хөл хорио дууссанаас хойш 1 сар гаруйн дараа бэлэн байдлын зэргийг 1 дүгээр зэрэг хүртэл буулгаж, дотоод дахь бүх хязгаарлалтаа цуцалж, зөвхөн хилээр гаднын иргэдийг нэвтрүүлэхэд тогтоосон хязгаарлалтыг үлдээсэн
- 8 дугаар сард Окланд хотод хаанаас авсан нь тодорхойгүй халдвар бүртгэгдэхэд бэлэн байдлын зэргийг тус хотод болон ойролцоох бүсэд 3 дугаар зэрэг, улсын бусад хэсэгт 2 дугаар зэрэг болгож нэмэгдүүлсэн
- Халдварын тархцыг амжилттай хянаж чадсан тул улсын бусад хэсэгт 9 дүгээр сард, Окланд хотод 10 дугаар сарын эхэн үед бэлэн байдлын зэргийг 1 хүртэл буулгасан
- Шинжилгээг маш идэвхтэй авсан бөгөөд нийт халдварын тооноос 1,052 дахин олон шинжилгээ авсан нь зөвхөн Австралийн дараа орох үзүүлэлт

Эдийн засгийн чиглэлээр:

- Халдварын ид дэгдэлтийн үед Засгийн газар цар тахлаас үүдсэн эдийн засгийн маш ноцтой хүндрэл нүүрлэж болзошгүй тул, халдварыг эрт хязгаарлах шаардлагатай байгааг мэдэгдсэн.
- Ерөнхий сайд болон бусад улс төрийн албан тушаалтнууд цалингаа 20 хүртэлх хувиар танасан
- Эмзэг давхаргын хүмүүсийг хамгаалахын тулд зарим төрлийн нийгмийн халамжийн хэмжээг нэмэгдүүлсэн
- Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаа нь онцгой доголдсон зарим аж ахуй нэгжид цалингийн татаас өгсөн

- Бизнесийн зарим төрлийн татварын хэмжээг багасгасан
- Ажлын байраа алдсан хүмүүст зарим хөнгөлөлт үзүүлсэн
- Дэд бүтцийн салбарт болон зам тээврийн төсөлд хөрөнгө оруулсан
- Иргэний агаарын тээврийн салбарыг дэмжиж, аялал жуулчлалыг сэргээх багц хөтөлбөр баталсан
- Засгийн газраас 50-аас доош ажилтантай жижиг аж ахуй нэгжүүдэд 2023 оныг дуустал 100,000 шинэ Зеланд доллар /71 мянга орчим ам.доллар/ хүртэлх хэмжээний зээл олгож байгаа
- Төв банк бодлогын хүүг 0.25 хүртэл бууруулсан
- Аж ахуй нэгжүүдэд зээлээ 10 сар хүртэл хугацаагаар царцаах боломж олгосон
- Орон сууцны түрээсийн төлбөрийг 6 сарын турш нэмэхийг хориглосон

Дэлгэрэнгүй мэдээлэл:

Шинэ Зеланд улс харьцангуй амжилттай, эндэгдэл багатайгаар цар тахлын нөхцөл байдлыг хяналтад оруулж, тархцыг хязгаарлаж чадсаныг тус улсын Засгийн газар шуурхай ажиллаж чадсантай холбон тайлбарлаж байна.

Тэр дундаа ДЭМБ-ын хувьд цар тахалтай хамгийн амжилттай тэмцэж чадсан улсуудын тоонд Шинэ Зеланд Улсыг зүй ёсоор багтааж байна. Тус улсын хувьд ДЭМБ-ын заавар, зөвлөмжийг маш сайн дагасан болохыг ч мэргэжлийн байгууллагууд онцолж байна.

Тухайлбал 1 дүгээр сарын 30-нд ДЭМБ шинэ төрлийн коронавирусийн гаралтай халдварт өвчнийг нийтийн эрүүл мэндийн онц байдал хэмээн зарласнаас ердөө 3 хоногийн дараа халдвараас сэргийлэх дорвитой алхмыг авч хэрэгжүүлсэн гэж ДЭМБ дүгнэж байна.

Мөн өмнө нь батлагдаад байсан цар тахалтай тэмцэх төлөвлөгөө ч энэ үед онцгой ач холбогдолтой байсан гэж дүгнэж байна.

Энэ хүрээнд Шинэ Зеландын Эрүүл мэндийн яам Үндэсний эрүүл мэндийн зохицуулах төвийг байгуулж, энэхүү өвчнийг албан ёсоор “халдварт болон мэдэгдвэл зохих өвчин” гэх зарласнаас хуулийн дагуу бүх шатны эмнэлгийн байгууллагууд сэжигтэй тохиолдол гарах бүрт холбогдох байгууллагад мэдэгдэх, шаардлагатай нөхцөлд халдвар авсан байж болзошгүй хүмүүсийг тусгаарлахаар хуульчилсан.

Түүнчлэн халдварын голомт болох БНХАУ-аас нислэг хүлээн авахгүй байх, тус улсад байсан хүмүүсийг хилээр нэвтрүүлэхгүй байх журмыг харьцангуй эрт мөрдүүлж чадсан. Хожим бусад улс орнуудад идэвхтэй тархах үед ч үүнтэй ижил шийдвэрүүдийг гаргаж байлаа.

Гэхдээ онц шаардлагатай хүмүүсийг хилээр нэвтрүүлэх боломжтой байхаар зохицуулсан бөгөөд ингэхдээ БНХАУ-аас гарснаасаа хойш гуравдагч улсад 14-өөс дээш хоногийн хугацаанд байсан хүмүүсийг нэвтрүүлэхээр зохицуулсан.

Мөн дэлхийн зарим оронд авч хэрэгжүүлсэн үнэ төлбөргүй, тусгай утсыг Ковид-19 өвчний дуудлага, мэдээлэлд зориулж бий болгох алхмыг авч хэрэгжүүлсэн.

Шинэ Зеландын Засгийн газар нөхцөлд байдалд үнэлгээ хийж, халдвар идэвхтэй тархсан улс орнуудаас ирсэн хүмүүсийг хилээр нэвтрүүлэхийг үе шаттайгаар хориглосоор 3 сарын дунд үед гэхэд улсынхаа иргэн болон тус улсад байнга оршин суудаг гаднын иргэдээс бусад хүнийг хилээр нэвтрүүлэхийг бүрэн хориглосон.

Харин гаднаас ирсэн хүмүүсийг 14 хоногийн хугацаанд өөрийгөө тусгаарлах өгч байсан. Гэхдээ тухайн үедээ Номхон далайн арлын орнуудад халдвар бүртгэгдээгүй байсан тул тухайн орнуудаас ирсэн хүмүүсийг тусгаарлах шаардлагагүй гэж үзэж байв.

Түүнчлэн нэг талаасаа хилийн чанадад аялж яваа иргэдээ эргэн уриалснаас гадна хөл хорио, тусгаарлалтын дэглэмийг зөрчсөн гаднын иргэдийг албадан гаргахаа мэдэгдэж байлаа. Энэ мэдэгдлийн дараахан тусгаарлалтын дэглэмийг зөрчсөн хоёр хүнийг тусгаарлалтын хугацааг нь дуусгаад албадан гаргахаа зарласан. Энэ нь иргэд тусгаарлалтын горимыг зөрчих эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулсан байх магадлалтай.

Түүнчлэн Ерөнхий сайд Ардерн 3 сарын 16-нд 500-аас дээш хүн цугласан арга хэмжээг хориглож байгаагаа зарлахдаа цар тахлын эдийн засагт нөлөөллийн асуудлыг голлон хөндөж, 2008 оны Дэлхийн эдийн засгийн хямралаас ч ноцтой эдийн засгийн хямралыг дагуулах эрсдэлтэй талаар ярьсан нь иргэд дэглэм сахихад нөлөөлсөн гэж үзэх үндэстэй.

Шинэ Зеландын Засгийн газар харьцангуй амжилттай ажиллаж байсан боловч 3 дугаар сарын сүүл үе гэхэд нөхцөл байдал илт хурцадсан учир 3 сарын 25-нд улсын хэмжээнд 4 дүгээр бэлэн байдлыг зарлаж хөл хориог тогтоосон. Энэхүү хөл хорио 1 сар гаруйн хугацаанд үргэлжлээд 4 сарын 27-нд дуусгавар болсон билээ.

Үүний зэрэгцээ энэ хугацаанд Иргэний хамгааллын сайдын шийдвэрээр нийтдээ үндэсний хэмжээнд онц байдал зарлаж, 3 удаа, тус бүр долоо хоногээр сунгасан.

Шинэ Зеланд улс цар тахалтай амжилттай тэмцэхэд нөлөөлсөн нэг гол хүчин зүйл нь хөл хорио тогтоосон болон сулласан хугацаа нь цагаа олсон, хөл хорионы үед бүх холбогдох байгууллагууд чиг үүргээ уялдуулж ажилласантай нь холбон үзэж болно.

Тухайлбал энэ нэг сарын хугацаанд Цагдаагийн байгууллага хөл хориог зөрчиж буй үйлдлийн талаар цахимаар мэдээлэл авч эхэлсэн, цар тахлын үед харьцангуй ачаалал багатай байсан төрийн байгууллагууд төсвөө сайн дураар ачаалал ихтэй ажиллаж буй байгууллагуудад шилжүүлсэн зэргийг дурдаж болох юм.

Мөн хөл хорио үргэлжилж байх хугацаанд буюу 4 сарын 10-нд холбогдох байгууллагууд өмнө нь гаднаас ирсэн иргэдэд өөрийгөө тусгаарлах чиглэлд өгч байснаа өөрчилж, 5 томоохон хотод үйл ажиллагаа явуулдаг зочид буудлуудтай гэрээлж, гаднаас ирсэн хүмүүсийг 14 хоног тусгаарлах журмыг мөрдүүлсэн.

Улмаар хөл хорионы нэг сарын хугацаанд Шинэ Зеландын Засгийн газар амжилттай ажиллаж, халдварыг тархцыг хязгаарлаж чадсан тул хөл хорио дуусах үеэс нөхцөл байдал үндсэндээ бүрэн тогтворжиж, Засгийн газар бэлэн байдлын зэргээ богино хугацаанд буулгаж, 6 сарын 8 гэхэд 1 дүгээр зэрэг хүртэл буулгаж, дотоод дахь бүх хязгаарлалтаа цуцалсан.

Зарим мэргэжилтнүүдийн хувьд Шинэ Зеландын Засгийн газар халдварын тархац хязгаарлаад зогсохгүй, хатуу хөл хорио тогтоогоод бүр мөсөн халдваргүй болох, харьцангуй зоримог стратеги барьсан гэж үзэж байна.

Хожим 8 дугаар сард Окланд хотод хаанаас авсан нь тодорхойгүй халдвар бүртгэгдэхэд бэлэн байдлын зэргийг тус хотод болон ойролцоох бүсэд 3 дугаар зэрэг, улсын бусад хэсэгт 2 дугаар зэрэг болгож нэмэгдүүлсэн ч халдварын тархцыг амжилттай хянаж чадсан тул улсын бусад хэсэгт 9 дүгээр сард, Окланд хотод 10 дугаар сарын эхэн үед бэлэн байдлын зэргийг 1 хүртэл буулгасан.

Ингэснээр эдийн засгийн хүндрэлийг даван туулах голлон анхаарах боломж бүрдсэн Эдийн засгийн чиглэлээр Шинэ Зеландын Засгийн газар дэлхийн бусад улс орнуудын нэгэн адилаар жижиг дунд аж ахуй нэгжүүдийг дампуурлаас сэргийлэх чиглэлд голлон анхаарсан бөгөөд энэ хүрээнд макро-эдийн засгийн болон валют, санхүүгийн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлснийг дээр дурдсан.

Түүнээс гадна тус улсын Засгийн газар дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулснаараа ажлын байрыг нэмэгдүүлэх, ажил олгогчдод татаас олгосноороо ажлын байрыг хадгалах, зам тээвэр, иргэний агаарын тээврийн салбар туйлдахаас сэргийлэх, жижиг, дунд аж ахуй нэгжүүдэд урт хугацааны зээл олгосноороо тэдгээрийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлжээ.

Түүнчлэн 4 дүгээр 15-нд Ерөнхий сайд Ардерн болон Засгийн газрын бусад гишүүд цалингаа 20 хувиар танах шийдвэр гаргасан нь нэг талаасаа улс төрийн өнгө аястай шийдэл байсан байж болох ч эдийн засагт бага ч гэсэн дэмж үзүүлсэн.

Олон улсын мэргэжилтнүүд Шинэ Зеланд улсын амжилтыг нэн түрүүнд шуурхай ажиллаж чадсантай, цаашлаад богино хугацаанд хатуу хөл хорио тогтоож, халдварыг бүр мөсөн арилгах стратеги барьсан нь оновчтой байсантай холбон авч үзэж байна.

1.6. Филиппин

Филиппин улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- Халдвар дотоодод дамжсан даруйд Нийтийн эрүүл мэндийн онц байдлыг зарласан
- Нийслэл хот байрладаг Лузон арал болон зарим бүсэд хатуу хөл хориог тогтоосон ч үр дүнд хүрсэн гэж үзэхэд бэрх байна. /Хөл хорионы үеэр гарсан байж болзошгүй алдааны талаар доор дурдсан/
 - Нийтдээ 18 удаа хэсэгчилсэн байдлаар тодорхой бүсүүдэд хөл хорио тогтоосон
 - Шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн
 - Ази, Номхон далайн бусад улс оронтой харьцуулахад маш хатуу хөл хорио тогтоож, хөл хөдөлгөөнийг хянахад цэрэг, цагдаагийн хүч дайчилсан
 - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хатуу хязгаар тогтоосон
 - Цэнгэлдэх хүрээлэн, хурлын цогцолбор гэх мэт өөр зориулалттай байгууламжуудыг Ковид-19 өвчний үед хилийн чанадаас ирсэн иргэдээ тусгаарлах болон бусад зориулалтаар ашиглах төв болгосон

Эдийн засгийн чиглэлээр

- Орон нутгийн удирдлагуудад гамшигийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөө зарцуулах чиглэлийг өгсөн
- Нэг хүнд хоёроос дээш халдваргүйжүүлэгч худалдахыг хориглох чиглэл өгч үнийн хөөрөгдлөөс сэргийлэх алхмыг авч хэрэгжүүлсэн
- 60 хоногийн хугацаанд гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг царцаах шийдвэр гаргасан
- Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих зорилгоор ДНБ-ы 3.1 хувьтай тэнцэх хэмжээний багц төсөв баталсан
- Бага орлоготой 18 сая өрхөд бэлэн мөнгө тараасан
- Жижиг аж ахуй нэгжүүдэд зээлийн батлан даалт олгосон
- Ойрын хугацаанд газар тариалан, зам тээвэр, аялал жуулчлалын салбарт ажилладаг хүмүүст санхүүгийн шууд дэмжлэг үзүүлэх төлөвтэй байна
- Ковид-19 цар тахлын үед баримтлах 4 тулгуурт нийгэм-эдийн засгийн стратегийг боловсруулсан. Үүнд: эмзэг бүлгийг дэмжих, цар тахалтай тэмцэх нөөцийг нэмэгдүүлэх, санхүүгийн болон валютын зохих арга хэмжээг авах гэсэн 4 арга хэмжээ багтаж байна

Дэлгэрэнгүй мэдээлэл:

Ази, Номхон далай, Зүүн Азийн дийлэнх улс орнуудтай харьцуулахад Филиппин улсад харьцангуй олон халдвар бүртгэгдэж, олон хүн Ковид-19 өвчний улмаас амиа алдаад байна.

Филлипин улсад Ковид-19 өвчний улмаас амиа алдсан хүний тоог нийт хүн амтай нь харьцуулахад нь 100,000 хүн тутам 7.99 хүн Ковид-19 өвчний улмаас амиа алдсан байгаа нь өмнө нь жишээлэн авч үзсэн Азийн орнуудаас хэд дахин өндөр үзүүлэлт юм.

Филиппин улсыг мөн өмнө дурдагдсан улс орнуудтай харьцуулахад Ковид-19 өвчний халдвар дотооддоо дамжсан тохиолдол харьцангуй сүүлд буюу 3 дугаар сард бүртгэгдсэн.

Үүнтэй холбоотойгоор цар тахлын эхэн үеэс буюу 1 дүгээр сарын сүүл болон 2 дугаар сарын эхэн үед анх халдвар бүртгэгдсэн орнууд цар тахалтай тэмцэхдээ илүү шуурхай ажиллаж, бэлэн байдлаа хангаж, урт хугацаандаа халдварыг амжилттай хянаж чадсан нь дээр дурдсан улс орнуудын жишээнээс харагдаж байгаа бол нөгөө талаас 3,4 дүгээр сард хүртэл нөхцөл байдал тогтвортой байсан улс орнуудын зарим нь тэр хугацаандаа бэлэн байдлаа хангаж чадалгүй хэт алгуурлаж, алдаа гаргасан нь Филиппин болон Европ, Америкийн зарим орнуудаас харагдаж байна.

Филиппинд анх халдвар дотооддоо дамжсан даруйд Ерөнхийлөгч Дутерте Нийтийн эрүүл мэндийн онц байдал зарлаж, орон нутгийн удирдлагуудад гамшигийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөө зарцуулах чиглэлийг өгсөн билээ.

Үүний дараагаар Филиппиний Худалдаа, Аж үйлдвэрийн яам нэг хүнд хоёроос дээш халдваргүйжүүлэгч худалдахыг хориглох чиглэл өгч үнийн хөөрөгдлөөс сэргийлэх алхмыг авч хэрэгжүүлсэн. Мөн 60 хоногийн хугацаанд гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг царцаах шийдвэр гаргасан нь бусад орнуудад төдий л авч хэрэгжүүлээгүй алхам юм.

Харин дотоодод халдвар дэгдсэнээс 10 орчим хоногийн дараа буюу 3 сарын 13-нд Ерөнхийлөгч Дутерте нийслэл Манила хот болон Лузон арлын бусад хотуудад хатуу хөл хорио тогтоох шийдвэр гаргасан.

Гэтэл Филиппинд гарсан шийдвэр олон талаараа алдаатай байсан гэж үзэх өнцөг шинжээчдийн дунд зонхилж байна. Үүнд:

- Нэн түрүүнд халдвар анх удаа дотоодод дамжсанаас хойш 10 гаруй хоногийн дараа хөл хорио тогтоосон нь цаг хугацааны хувьд хөл хорио цагаа олоогүй байх магадлалтай гэж үзэхэд хүргэж байна
- Хөл хориог шууд эсвэл ойрын хугацаанд хэрэгжих нөхцөлтэйгөөр биш шийдвэр гарснаас 3 хоногийн дараа хэрэгжих нөхцөлтэйгөөр гаргасан нь зарим талаар сөрөг нөлөө дагуулсан байх магадлалтай
- Эрх зүйн талаасаа хуульд заасан “Олон нийтийн эрчимжүүлсэн тусгаарлалт” гэх нэр томъёог ашиглан шийдвэр гаргасан ч түүнийг “хатуу хөл хорио”-той дүйнэ гэж аман байдлаар тайлбарлаж байсан нь эргэлзээ, үл ойлголцол үүсэхэд хүргэсэн

Тухайн шийдвэрээс хойш Филиппин улсад нийтдээ 18 удаа хэсэгчилсэн байдлаар тодорхой бүсүүдэд хөл хорио тогтоосон ч тус улс дахь халдварын тархац болон Ковид-19 өвчнөөс үүдэн нас барсан хүний тоог харахад Филиппин улсын Засгийн газар цар тахлыг хязгаарлаж чадсан гэхэд хүнд юм.

Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын тогтоосон хөл хорио, хязгаарлалттай харьцуулахад Филиппин улсынх маш хатуу хэв шинжтэй байсан бөгөөд хэв журмыг сахиулах цэрэг, цагдаагийн алба хаагчдыг идэвхтэй ашигласан.

Гэвч Филиппинд халдварыг тархцыг хязгаарлах ажил үр дүнд хүрэхгүй байснаас үүдэлтэйгээр Манила хот болон эргэн тойронд нь тогтоосон бэлэн байдлын зэргийг буулгах хүртэл 5 сарын хугацаа зарцуулагдсан.

Мөн шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх, тодорхой нөхцөлтэйгөөр тээврийн хязгаар тогтоох зэрэг алхмыг авч хэрэгжүүлсэн.

Түүнчлэн цэнгэлдэх хүрээлэн, хурлын цогцолбор гэх мэт өөр зориулалттай байгууламжуудыг Ковид-19 өвчний үед хилийн чанадаас ирсэн иргэдээ тусгаарлах болон бусад зориулалтаар ашиглах төв болгож байна.

Филиппинд халдварын тархцыг богино хугацаанд хянаж чадаагүй, хөл хорио хэт удаан үргэлжилснээс шалтгаалан бизнесийн байгууллагууд нийтээрээ онцгой хүндрэлд орсон. Тус улсын ДНБ-ын хэмжээ оны эхний улиралд өмнөх оны мөн үеийнхээс 0.7 хувиар буурснаа 2,3 дугаар улирлуудад 16.5, 11.5 хувиар буурсан нь хатуу хөл хорио эдийн засагт ноцтой хүндрэл учруулсныг илтгэнэ.

Манила хотын ойр орчимд 8 дугаар сард бэлэн байдлын зэргийг буулгаснаас хойш үе шаттайгаар хөл хорио, хязгаарлалтыг суллаж байгаа ч аж ахуй нэгжүүд эдийн засгийн сэргэлт авахад удаан хугацаа шаардагдах төлөвтэй байна.

Гэхдээ тэр цагаас хойш улсын ихэнх хэсэгт зочид буудлууд хэвийн ажиллах боломжтой болж, нийтийн тээврийн хөдөлгөөн сэргээж байна.

Филиппиний Засгийн газар цар тахлын үед хэрэгжүүлж буй нийгэм-эдийн засгийн бодлого, стратегиа үндсэн 4 арга хэмжээгээр тайлбарлаж, 4 тулгуурт стратеги гэж нэрлэж байна.

Эдгээр нь:

- Тулгуур 1: Ядуу болон бага орлоготой өрх, жижиг бизнес байгууллагын ажилчид болон бусад эмзэг бүлгүүдэд чиглэсэн олон төрлийн тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлэх, мөнгөн тусламж олгох замаар дэмжих
- Тулгуур 2: Ковид-19 цар тахалтай тэмцэх эрүүл мэндийн нөөцийг нэмэгдүүлж, цар тахалтай нүүр тулж ажиллаж буй ажилчдын аюулгүй байдлыг хангах.
- Тулгуур 3. Эдийн засгийн эргэлтийг хэвээр хадгалах, цар тахалтай тэмцэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн валютын арга хэмжээ
- Тулгуур 4: Ажлын байрыг бий болгож, өсөлтийг хангах эдийн засгийн сэргэлтийн хөтөлбөр

Энэхүү 4 тулгуурт стратегийн хүрээнд Филиппиний Засгийн газар 595.5 тэрбум песо буюу 120 тэрбум орчим ам.доллартой тэнцэх хэмжээний багц хөтөлбөрийг зарласан бөгөөд энэ хүрээндээ 205 тэрбум песог эмзэг давхаргад буюу буурай орлоготой 18 сая өрхөд бэлэн мөнгө хэлбэрээр тараажээ. Харин үлдсэн хэсгийг эмзэг бүлгийн ажилчдыг хамгаалах, цар тахалтай тэмцэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, жижиг бизнесүүдэд батлан даалт олгох, зэрэг арга хэмжээнд зарцуулсан.

Түүний есдүгээр сард хууль тогтоох байгууллагаас батлагдсан “Баянихан 2” хөтөлбөрийн хүрээнд эмзэг давхаргын айл өрхүүдэд халамж тараах чиглэл баримталж байна. Мөн тодорхой салбарууд буюу хөдөө аж ахуй, зам тээвэр, аялал жуулчлалын салбарыг мөн халамж тараах хэлбэрээр дэмжих төлөвтэй байна.

Филиппиний Засгийн газрын авч хэрэгжүүлж буй харьцангуй зүүний чиг баримжаатай буюу халамжийн бодлогыг зарим шинжээчид шүүмжилж байгаа нэг хэсэг нь цар тахлын үед эмзэг давхаргыг хамгаалах цор ганц бодит арга гэж харж байна.

1.7. Энэтхэг

Энэтхэг улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

- БНХАУ-д халдвар дэгдэх үеэс эхлэн тус улсаас ирсэн иргэдийн халууныг шалгаж эхэлсэн
- Хоёрдугаар сард Азийн бусад орнуудаас ирэх иргэдийн халууныг шалгах журам мөрдүүлсэн
- Тэр үед мэргэжлийн байгууллагууд зөвхөн халуун шалгах нь үр дүнд хүрэхгүйг анхааруулж байв

- Үндсэндээ Энэтхэгийн Засгийн газрын авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг цаг хугацааны хувьд хожимдсон гэж үзэж байгаа
- Гуравдугаар сарын эхэн үеэс нөхцөл байдал хяналтаас гарсан нөхцөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, Засгийн газрын 7 яамны хамтарсан баг байгуулагдаж тусгаарлах болон эмчилгээний байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан
- Үүний зэрэгцээ нийгэмд цочрол үүсэхээс сэргийлэх алхмыг авч хэрэгжүүлсэн
- 3 сарын 3-наас гаднын иргэдэд виз олгохыг зогсоож, халдвар тархаж байсан зарим улсын иргэдэд олгосон визээ цуцлаад, 10 хоногийн дараа бүх улсын иргэдэд олгосон дипломат, албан визээс бусад визийг цуцалсан
- Цар тахал бүртгэгдсэн орнуудаас ирсэн иргэдээ 14 хоног тусгаарлах журам мөрдүүлсэн
- Мужийн удирдлагуудын шийдвэрээр ихэнх мужид амны хаалт зүүхийг журамласан
- 3 дугаар сарын дунд үед хуурай газраар хиллэдэг бүх орнуудтайгаа зорчигч тээврийн хөдөлгөөнийг бүрэн хаасан
- 3 дугаар сарын сүүлээр муж хоорондын хилийг хаасан
- 3 сарын 24-нд хатуу хөл хорио тогтоосон нь 5 сарын 31 хүртэл буюу 2 сар гаруй үргэлжилсэн
- Хөл хориог тогтоох шийдвэр ч, суллах шийдвэр цаг үеийн нөхцөл байдал, бодит байдалтай нийцээгүй гэж үзэж байна
- Улсыг бүхэлд нь 3 үндсэн хэсэгт хувааж байгаа нь 1) Улаан бүс буюу халдвар өндөр тархсан бүс, 2) Шар бүс буюу харьцангуй удаан тархаж буй бүс, 3) Ногоон буюу Сүүлийн 21 хоногт халдвар бүртгэгдээгүй бүс
- Энэхүү бүсийн ангилал дээр тулгуурлан шаардлагатай бүсүүдэд хөл, хөдөлгөөний хязгаарлах үйл ажиллагаа одоог хүртэл үргэлжилж байгаа
- Шинжилгээний хүчин чадлаа тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэл барьсан ч хангалттай төвшинд нэмж чадаагүй гэж үзэж байна
- Үүнээс үүдэн халдварыг эрт оношлоход хүндрэл үүссэн
- Гэхдээ шинжилгээний чадлыг нэмэгдүүлэх зарим алхам нь үр дүнтэй байсан. Тухайлбал 3 дугаар сараас эхлэн хувийн лабораториудад шинжилгээ Ковид-19 өвчний шинжилгээ авахыг зөвшөөрсөн
- Улсын алс бөглүү хэсэгт эмнэлгийн хүчин чадал сул байсан нь нөхцөл байдал хяналтаас гарахад улам бүр нөлөөлсөн

Эдийн засгийн чиглэлээр:

- Ковид-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийг даван туулах ажлын хэсгийг байгуулсан
- Үндсэн хоёр төрлийн аж ахуй нэгжийг дэмжих бодлого барьж байгаа. 1) Жижиг, дунд бизнес, 2) Цар тахлаас үүдэн онцгой хохирол амссан иргэний агаарын тээвэр болон бусад салбар
- Улсын хэмжээнд хөл хорио үргэлжилж байхад буюу 4 сарын 20-ноос эхлэн цар тахлын тархац харьцангуй бага байгаа бүсүүдэд эдийн засгийн үйл ажиллагааг сэргээж эхэлсэн
- Мөн үед цагаач ажилчид болон бусад хүндэтгэх шалтгаантай хүмүүсийг муж дамжин аялахыг зөвшөөрсөн
- ДНБ-ны 10 хувь орчимтой тэмцэх мөнгөн дүн бүхий багц хөтөлбөрийг зарлаж, валют, санхүүгийн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн
- Хөл хорионы үе дууссан даруйд буюу 6 сарын 1-нээс эхлэн эдийн засгийн үйл ажиллагааг 5 үе шаттайгаар сэргээгээд байна
- Одоогоор гарсан сүүлийн буюу 5 дахь үе шатаар кино театр, үзвэр үйлчилгээний газруудыг 50 хувийн ачаалалтайгаар нээх, сургууль болон зарим байгууллагыг нээх эсэх асуудлыг шийдэх эрх мэдлийг орон нутгийн удирдлагад өгөх зэрэг алхам авч хэрэгжүүлээд байна.

- Цар тахлыг нэгэнт хумих, хязгаарлах боломж хомс тул эдийн засгийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх ёстой гэсэн байр суурь шийдвэр гаргах төвшинд гарч байв.
- Нэн ядуу өрхүүдэд бэлэн мөнгө тараасан. Үүний нийт мөнгөн дүн нь ДНБ-ийнх нь 1 хувьтай тэнцэж байна.
- Төв Засгийн газраас мужуудад хүүгүй зээл олгосон
- Бизнесийг дэмжих багц баталсан бөгөөд энэ хүрээнд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид, Банк бус санхүүгийн байгууллагууд, тариалан эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг багтаж байна
- Дийлэнх орны жишгээр бодлогын хүүгээ бууруулсан
- Хил залгаа улсын аж ахуй нэгж тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх боломжтой байхаар тусгаж, Гадаадын хөрөнгө оруулалтын бодлогоо сулласан

2. Умард болон Өмнөд Америкийн зарим орны цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Ковид-19 цар тахлаас үүдэн нас барсан хүний тоог тухайн бүсийн хүн амын тоотой харьцуулж үзэхэд Умард, Өмнөд болон Латин Америкийн бүсэд нийтийн эрүүл мэнд талаасаа хамгийн их хохирол учирсан болохыг өмнөх хэсэгт дурдсан.

Үүнээс үүдэн энэ бүс нутгийн орнуудын авч хэрэгжүүлсэн бодлого нийтийн эрүүл мэндийг хангах талаасаа зарим талаар алдаа, дутагдалтай байсан гэж үзэх үндэстэй. Тэр утгаараа өнгөрсөн хугацаанд энэ бүс нутгийн халдвар хурдацтай тархсан АНУ, Мексик, Бразил болон бүс нутгийн бусад оронтой харьцуулахад халдварыг амжилттай хянаж байгаа Уругвай улсын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг энэ хэсэгт авч үзлээ.

2.1. АНУ

АНУ-д Муж бүхэн өөр өөрийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд арга хэмжээг авч хэрэгжүүлсэн учраас бусад улс орнуудтай харьцуулахад хүндрэлтэй

Гэхдээ АНУ-ын хэмжээн дэх цар тахалтай холбоотой тоон мэдээллийг нэгтгэн үзвэл тун ноцтой тоо баримтууд харагдана. Тухайлбал тус улсад бүртгэгдсэн нийт халдварын тоо 18 сая 600 мянга байгаа бол нас баралтын тоо 328,000 байна. Эндээс үзвэл дэлхий даяар бүртгэгдсэн нийт халдварын 22.6 хувь орчим, нийт нас баралтын 18.8 хувь орчим нь АНУ-д бүртгэгджээ АНУ-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр

- Иргэний агаарын тээврийн 3 том компани нэн түрүүнд 1 сарын 31-нд БНХАУ-тай хийх нислэгээ цуцалсан
- Гэвч Европт дэгдэлт үүсэх үед үүнтэй ижил арга хэмжээг авч хэрэгжүүлж амжаагүй нь халдвар тархахад нөлөөлсөн гэж үзэж байгаа
- Халдварын эхэн үед сэжигтэй тохиолдлыг шинжилгээнд хамруулах үйл явц удаан байсан
- Эрүүл мэндийн тогтолцоо нь бэлтгэгдээгүй байсан
- Мөн зарим шийдвэр, тэр дундаа зай барих удирдамж хугацаанаас хагас сарын өмнө гарсан бол Ковид-19 өвчний улмаас нас барсан хүмүүсийн 90 хувь нь аврагдах боломжтой байсан гэсэн судалгаа гарсан.
- Сонгуулийн жил тул улс төрийн хүчин зүйл нөлөөлснийг үгүйсгэх аргагүй.

- Холбооны Засгийн газар буюу Трампын Засаг захиргаа цар тахалтай тэмцэх багийг байгуулж, 3 дугаар сард “Халдварын тархцыг хязгаарлах 15 хоног” хөтөлбөрийг зарлаж, тодорхой зөвлөмж гаргасан.
- Энэ зөвлөмжид зай барих дүрэм багтаж байсан ч амны хаалтны тухай туссаагүй
- Нью-Йорк, Калифорни зэрэг томоохон мужууд 3 дугаар сараас бизнесийн байгууллагуудаа хааж эхлэх үед зарим муж ийм арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй
- 3 дугаар сарын 6-нд Коронавирусийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тухай хууль батлагдаж, цар тахалтай тэмцэх ажилд 8.3 тэрбум долларыг төсөвлөсөн
- 3 сарын 13-нд Ерөнхийлөгч Трамп онц байдал зарласан
- Зарим мужид Үндэсний гвардыг дайчилсан
- Зарим мужид спорт, соёлын болон бусад зориулалттай барилгыг эмнэлэгт болгож ашигласан
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхийн тулд хилийн чанадаас энэ төрлийн бараа, бүтээгдэхүүнийг импортолж, дотооддоо зарим аж үйлдвэрийг энэ чиглэлд ашиглаж эхэлсэн.
- 4 сарын 17 гэхэд бүх мужид гамшгийн бэлэн байдал зарлаж, түүнийг нь Холбооны Засгийн газар хүлээн зөвшөөрөөд байсан
- 5 дугаар сард “Warp Speed” хөтөлбөрийг зарлаж, вакцин бүтээхэд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ашиглах санаачлаг гарсан.
- Дэгдэлтийн оргил үеэс шинжилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарсан бөгөөд тус улсад нас барсан хүний тоог нийт халдварын тоотой харьцуулахад дэлхийн дундажаас бага байгаа нь үүнтэй холбоотой
- Зарим мужид хөл хорио сулраад байх үед буюу 6 дугаар сард олон мужид хоёр дахь давлагаа дэгдсэн.
- Ерөнхийлөгч Трамп зарим мужийн хатуу хөл хориог шүүмжилж байсан нь улс төрийн маргаанд хөтөлсөн

Эдийн засгийн чиглэлээр:

- 3 дугаар сард Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулсан
- Ерөнхийлөгч Трамп жижиг бизнес эрхлэгчдийг дэмжсэн зээл олгохыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон
- Зарим аж ахуй нэгжийн татварыг алданги тооцолгүйгээр 1 сараар хойшлуулсан
- Конгресс 3 дугаар сард нийтдээ 2.3 их наяд доллар буюу АНУ-ын ДНБ-ий 11 хувьтай тэнцэх дүн бүхий багц хөтөлбөрийг тусгасан хууль баталсан
- Конгресс 4 дүгээр сард эдийн засгийн хүндрэлийг давах багц хөтөлбөр баталсны эхнийх нь 483 тэрбум долларын дүн бүхий байсан
- Энэ хоёр хөтөлбөрийн хүрээнд ажилгүйдлийн тэтгэмжийг нэмсэн
- Эмзэг бүлэгт хүнс түгээсэн
- Зарим аж ахуй нэгжид зээл, батлан даалт олгож дампуурлаас хамгаалах, жижиг аж ахуй нэгжийн зарим зээлийг чөлөөлсөн
- Мужуудад төсөв хуваарилсан
- Мөн дэлхийн бусад орнуудад тодорхой тусламж үзүүлсэн
- Хувь хүмүүсийг 1 удаагийн татварын хөнгөлөлтөд хамруулсан
- 4 дүгээр сард Холбооны Гамшгийн эрсдэлийн сангаас 44 тэрбум долларыг оюутны зээл, нийгмийн даатгалын хураамжийг хойшлуулж, ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлэхэд зарцуулах шийдвэр гаргасан
- Ойрын хугацаанд 900 тэрбум долларын хөтөлбөр баталж, 600 тэрбум орчим долларыг хувь хүмүүст шууд олгохоор төлөвлөж байна

2.2. Мексик

Цар тахлын улмаас хамгийн ноцтой хохирол амссан улсуудын нэг нь Мексик улс билээ. Судалгааны өмнө хэсэгт дурдсанчлан тус улсад бүртгэгдсэн нийт халдварын тоог Ковид-19 өвчний улмаас нас барсан нийт тохиолдолтой харьцуулж үзэхэд нас баралтын хувь дэлхийн дунджаас 4-5 дахин өндөр буюу 9.4 орчим хувь байна. Үүнийг нэн түрүүнд Мексик Улс иргэдээ шинжилгээнд хамруулах чиглэлд тааруу ажилласантай нь холбоотой гэж үзэж болох юм. Түүнээс гадна Европт Ковид-19 өвчний улмаас нас барах хүний дундаж нас 75 байхад Мексикт энэ тоо 55 байна. Тиймээс Мексик улсын иргэдийн дунд чихрийн шижин зэрэг хууч өвчтэй хүн олон байдагтай мөн холбоотой гэж үзэж байна.

Мексик улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- Анх халдвар хүнээс хүнд халддаг нь тогтоогдсоноос 2 хоногийн дараа шинэ төрлийн коронавирусийн халдвар Мексик улсад аюулгүй тариагүй гэсэн мэдэгдлийг тус улсын Эрүүл мэндийн яам гаргасан.
- Цар тахлын эхэн үед буюу 1 дүгээр сарыг дуустал Бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах зэрэг тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн
- Гэвч том дүр зургаараа шийдвэр гаргах, бэлэн байдал хангах, болзошгүй эрсдэлийг тооцох хурд нь харьцангуй удаан байлаа.
- 3 дугаар сард дотоодод халдвар дамжсаны дараа зарим нийтийг хамарсан арга хэмжээг хориглосон
- Энэ үеэс мэргэжилтнүүд Мексик улс цар тахалтай тэмцэх нөөц, боломж хомс, тэр дундаа эрчимт эмчилгээний ор, амьсгалын төхөөрөмж цөөтэй, эрүүл мэндийн салбарын хүний нөөц тааруу гэх асуудлыг хөндөж эхэлсэн.
- Мөн гол алдаа нь Засгийн газар хилээ хаахгүй байсанд оршиж байв
- Түүнээс гадна халдвар оргилдоо хүрч тархах хүртэл зарим олон нийтийн арга хэмжээг цуцлаагүй, шинжилгээний хүчин чадал нь тааруу байсан зэрэг нь шүүмжлэлд өртөж байв
- Эрх баригчид, тэр дундаа Ерөнхийлөгч Лопез Обрадор асуудалд шинжлэх ухаанч бус өнцгөөс хандаж, өөрөө зай барихгүй олон хүн цуглуулж, гар барьж байсан нь тогтмол шүүмжлэлд өртөж байсан
- Нөхцөл байдал хэдийн онцгой хүндэрсэн хойно буюу 3 сарын 30-нд Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн онц байдал зарласан
- Тэр цагаас хойш зарим муж, хотод хэсэг хугацааны хөл хорио тогтоосон
- Вакцин худалдан авах ажлыг мужууд өөрсдөө зохион байгуулах санал гарч байсан
- Холбооны Засгийн газар нийтэд нь худалдан авах шийдвэр гаргаж, зарим компанитай гэрээ байгуулж, эхний тунгуудыг хүлээн авах нь ойртоод байна
- 12 дугаар сараас метроны шугамд QR кодыг нэвтрүүлж байна. Энэ мөн л шийдэл нь оновчтой боловч хэт хожимдсон шийдвэр юм
- Одоо хүртэл нөхцөл байдал тогтворжихгүй байгаа ч Засгийн газар үндэсний хэмжээнд хөл хорио тогтоохгүй байх чиглэл барьсаар байна

Эдийн засгийн чиглэлээр:

- *Халдварын тархцыг хязгаарлахын тулд хөл хорио тогтоохгүй байгаагаа бүхэлд нь эдийн засгийн хүчин зүйлтэй холбон тайлбарлаж байгаа*
- *Тухайлбал үндэсний хэмжээнд хөл хорио тогтоовол нэн ядуу 60 сая хүн эрсдэлд орно гэж эрх баригчид үзэж байна.*
- *4 сарын 5-нд Ерөнхийлөгч Лопез Обрадор өөрийнх нь Засгийн цар тахлаас үүдсэн эдийн засагтай асуудалтай тэмцэхэд гол анхаарлаа хандуулна гэж зарласан*
- *Газрын тосны үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн*
- *5 дугаар сард эдийн засгийн үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөөг танилцуулсан*
- *Энэ хүрээнд муж, орон нутгийг эрсдэлийн төвшингээр ногоон, шар, улбар, шар гэсэн 4 ангилалд хувааж, тухайн эрсдэлийн төвшинд үйл ажиллагаа явуулж болох аж ахуй нэгжүүдийн жагсаалтыг гаргасан.*
- *Барилга, уул уурхай зэрэг хүнд үйлдвэрлэлийн салбарыг ажиллах онц шаардлагатай гэсэн ангилалд оруулсан*
- *Өрхийн амьжиргааг дэмжиж байгаа*
- *НӨАТ-ыг буцаан олгох шийдвэр гарсан*
- *Аж ахуй нэгжүүдэд болон хувь хүмүүст зээл олгож байна*
- *Ажлын байраа хадгалж буй байгаа жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг тусгайлан дэмжих бодлого баримталж байна*

2.3. Бразил

Бразил Улс цар тахлын хамгийн олон халдвар бүртгэгдсэн, цар тахлаас үүдэн хамгийн ноцтой хохирол амссан улс орнуудын нэг болоод зогсохгүй Латин Америк, Өмнөд Америкийн улс орнуудад гарсан дэгдэлтийн голомт нь Бразил улс байсан. Тус улсад халдвар хурдацтай тархахад улс төрийн зөрчил, маргаан, тэр дундаа төв Засгийн газар болон мужийн удирдлагуудын үйл ажиллагааны зөрүү голлох нөлөө үзүүлсэн гэж үзэж болно.

Бразил Улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- *Анх халдварын голомтоос иргэдээ татан авахдаа ажиглалт, тусгаарлалтын хугацааг 18 хоног байхаар тогтоосон нь дэлхийн дунджаас өндөр үзүүлэлт.*
- *Гэхдээ 3 сард энэ хугацааг 7 хоног хүртэл буулгасан*
- *Нэн түрүүнд эрсдэлийн үнэлгээ хийж, хамгийн муугаар бодоход улсын хэмжээнд 2 сая хүртэлх хүн цар тахлын улмаас амиа алдах эрсдэлтэй гэсэн дүгнэж гаргасан*
- *Энэхүү үнэлгээн дээр тулгуурлан зай барих дүрэм мөрдүүлэх нь хамгийн үр дүнтэй арга болно гэж үзэж, тус дүрмийг мөрдүүлсэн*
- *Гэвч үнэлгээ хийгдэх үед буюу 3 сарын 19 гэхэд халдвар хэдийн тархсан, 54 цагийн дотор халдварын тоо 2 дахин нэмэгдэж байв.*
- *Шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэхдээ дэлхийн бусад орнууд шиг PCR шинжилгээ биш эсрэг биетийг тогтоох буюу серологийн шинжилгээний оношлуур бүтээх оролдлого хийсэн Энэ оношлуур нь үнийн хувьд хямд, зарим талаар дэвшилтэт байсан*
- *Гэвч ерөнхий арга хэмжээ удаан, улс төрийн сэдэлтэй зөрчил гарч байсан нь цар тахлыг хязгаарлах үйл явцад хүндрэл учруулсан*
- *Зарим муж хөл хорио тогтоосон ч түүнийг Төв Засгийн газар нь буруушааж, эсэргүүцэж, Ерөнхийлөгч Болсонару өөрөө хөл хорио эсэргүүцсэн жагсаалт хүртэл оролцсон*

- Ерөнхийлөгч Болсонаругийн үйлдэл, мэдэгдлүүд, тэр дундаа цар тахлын аюулыг хэт үл ойшоож байсан нь иргэдийн сэтгэл зүйд нөлөөлж, иргэд хөл хорионоос татгалзаж байсан нь халдвар тархахад нөлөөлсөн
- Үндсэндээ цар тахалтай тэмцэхэд Төв Засгийн газрын шийдвэртэй арга хэмжээ илт дутагдаж байгаа.
- Вакцинжуулах ажлыг зарим муж 2021 оны 1 сараас эхлүүлэхээр төлөвлөж байна

Эдийн засгийн чиглэлээр:

- Нийтдээ ДНБ-ий 12 хүртэлх хувьтай тэнцэх төсвийг цар тахалтай тэмцэх, түүнээс үүдсэн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад зарцуулж байна
- Эмзэг өрхүүдэд орлогын дэмжлэг үзүүлсэн
- Орлого багатай болон ажил эрхэлдэггүй өрхүүдэд мөнгө тараасан
- Тэтгэврийн насныхан 13 дахь сарын тэтгэвэр буюу 1 сарын тэтгэвэртэй нь тэнцэх мөнгө өгсөн
- Ажлаасаа чөлөөлөгдөж, эсвэл ажлын цагийн буурснаас орлого нь багассан хувь хүмүүст тэтгэмж олгосон
- Төв банк бодлогын хүүг түүхэн доод төвшин буюу 2 хувьд хүртэл буулгасан
- Мужийн төвшинд мөн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн

2.4. Уругвай

Уругвай улсын байрладаг Өмнөд Америк тивд Ковид-19 цар тахлын улмаас амиа алдсан хүний тоог нийт хүнтэй харьцуулж үзэхэд дэлхийн бүс нутагтай харьцуулахад хамгийн өндөр буюу 1 сая хүн тутамд 756 байгаа бол Уругвай улсад энэ үзүүлэлт бүс нутгийнхаа үзүүлэлтэд 20 дахин бага буюу 37.1 байна.

Тиймээс тус улсын авч хэрэгжүүлсэн авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ нь тун оновчтой байсан гэж үзэх үндэстэй.

Уругвау улсын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тун энгийн боловч үр дүнтэй байсан гэж мэргэжилтнүүд үзэж байна.
- Уругвай улсад эхний халдвар 3 дугаар сарын дунд үед буюу харьцангуй сүүлд илэрсэн бөгөөд үүнийг хамгийн түрүүнд халдвар голомтлон тархсан улсуудтай шууд нислэг үйлддэггүйтэй холбон тайлбарлаж байсан. Гэхдээ эхний халдвар авсан 4 хүний зарим нь 500 хүнтэй хамт хуриманд оролцсон, хот дамжин 6 цаг автобусаар зорчсон зэргээс шалтгаалан богино хугацаанд олон халдвар бүртгэгдсэн
- Харин эрх баригчид нэн даруй олон нийтийн арга хэмжээнүүдийг цуцалж, 24 цагийн дотор ихэнх хавьтлыг тогтоож, сэжигтэй тохиолдлыг тусгаарласан
- Мөн иргэдэд гэртээ байхыг уриалсан
- Эхлээд Карраско олон улсын нисэх онгоцны буудлаас бусад боомтыг хаагаад, хожим нь халдвар идэвхтэй тархсан улсуудаас нислэг хүлээн авахаа зогсоосон
- Утсаар үнэ төлбөргүй эрүүл мэндийн зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгож, иргэдийг гэрээсээ ажиллахыг уриалсан

- *Эмнэлгийн орыг чөлөөлөхийн түлд зарим хагалгааг хойшлуулах чиглэл өгсөн*
- *Халдвар хамгааллын бүтээгдэхүүнүүд хаана, ямар үнээр зарагдаж буй талаар жагсаалт гаргаж, нийтэд ил богосон*
- *Гуравдугаар сарын сүүл үед байнга оршин суугчид, транзит зорчигчдоос бусад гаднын иргэдийг хилээр нэвтрүүлэхийг бүрэн хориглосон*
- *Засгийн газар шийдвэр бүрээ тусгайлан байгуулсан мэргэжлийн хороогоор хэлэлцүүлж байсан*
- *Сэжигтэй тохиолдол, хавьтал бүрийг шинжлэх бодлого баримталсан. Уругвайд нийт тохиолдлоос 14.3 дахин олон шинжилгээ авсан байхад Аргентинд энэ тоо 3.3, Мексикт 2.5, Колумбид 4.1 байна. Үүнд дотооддоо оношлуур чухал нөлөө үзүүлсэн бөгөөд 5 дугаар сарын дунд үе гэхэд өдөрт 1,000 орчин PCR шинжилгээ авч байсныг талаас илүүг нь дотоодын оношлуураар авч байсан*
- *3 сарын 30-нд иргэдийн хөл хөдөлгөөнийг тодорхой хэмжээнд хязгаарлах шийдвэр гарсан ч бусад улсуудтай харьцуулахад уян хатан, уриалгын шинжтэй байсан. Шийдвэр 12 хоног хэрэгжсэн*
- *Дээр дурдсан энгийн арга хэмжээнүүдийг шуурхай авч хэрэгжүүлсэн тул хөл хорио тогтоолгүйгээр халдварын тархцыг хумьсан*

Эдийн засгийн чиглэлээр:

- *3 дугаар сарын дунд үеэс эрүүл мэндийн байгууллагууд хатуу хөл хорио тогтоох зөвлөмж өгч байсан ч Засгийн газар эдийн засгаа эрсдэл оруулахаас сэргийлж, хөл хорионоос зайлсхийсэн*
- *4 сарын дунд үеэр барилгын салбарын үйл ажиллагааг, 5 дугаар сараас төрийн байгууллагуудын үйл ажиллагааг, 6 дугаар сараас худалдааны төвүүдийн үйл ажиллагааг бүрэн хэвийн болгосон*
- *Нийтдээ ДНБ-нийхээ 1.6 хувьтай тэнцэх хэмжээний төсвийг нэмэлтээр баталсан*
- *Энэ хүрээнд ажилгүйдлийн тэтгэмж хүсэхэд тавигдах шаардлагыг хөнгөвчилсөн*
- *Эмзэг бүлгүүдэд бэлэн мөнгө, хүнс тараасан*
- *Өвчний улмаас чөлөө авсан ажилчдад олгох цалингийн хувийг нэмэгдүүлсэн*
- *Зарим төрлийн татвар, шимтгэлийг бууруулж, хойшлуулсан*
- *6 дугаар сараас эхлэн аж ахуй нэгжүүд шинэ ажилтан авсан тохиолдолд сар тутам 5,000 песо буюу 118 доллар (тус улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1/3-тэй тэнцэх дүн)-ын татаасыг 3 сарын турш олгосон*
- *Өндөр цалинтай нийтийн албан тушаалтнуудын цалинг 20 хувиар танаж, цар тахалтай тэмцэх санд хандивласан*
- *Тус сангаас эмзэг бүлэгт өгөх халамж, бэлэн мөнгийг гаргаж байгаа*
- *3 сарын 1-нээс 8 сарын 31 хүртэлх түрээсийн төлбөрийг 180 хоногийн хугацаагаар царцаасан*
- *ЖДҮ-г дэмжих сангийн хөрөнгийг 50 сая песо байсныг 10 дахин нэмэгдүүлсэн (Зарим санхүүжилтийг олон улсын байгууллагаас татсан)*
- *Нийтдээ цар тахлаас шалтгаалан жижиг дунд бизнес эрхлэгчдэд 2.5 тэрбум песогийн зээл олгох төлөвлөгөөтэй байна*

3. Европын зарим орны цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дийлэнх судалгаанд Европ тивийг 2-3 дэд бүсэд хуваан авч үздэг ч энэхүү судалгаанд Европ тивийг бүхэлд нь 1 хэсэг болгож авч үзлээ.

Цар тахлаас үүдэн амиа алдсан тохиолдлыг нийт хүн амтай нь жишин авч үзэхэд Европын холбооны орнуудад харьцангуй өндөр буюу дунджаар 1 сая хүн тутамд 784 хүн энэ өвчнөөр нас барсан байхад Европын бусад хэсэгт дэлхийн дундажтай ойролцоо байна.

Тиймээс энэхүү судалгаанд халдварын тоо өндөр боловч нас баралтын тоо эрс бага байгаа ХБНГУ-ыг болон шинжээчдийн тооцоолж байгаагаар цар тахлын үед тааруу ажилласан улс орны тоонд багтаж байгаа Их Британи улсын жишээг авч үзлээ.

Энд дурдагдах хоёр улс болон Европын бусад орнууд ерөнхий стратегийн хувьд Азийн орнуудаас өөр байсныг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал Европын дийлэнх орнууд анхнаасаа халдвар бүрийг тусгаарлах, илрүүлэх бодлогыг баримтлаагүй бөгөөд зарим улсад сүргийн дархлаа тогтоох тухай санал ч гарч байсан.

Энэ нь нэг талаасаа эдийн засгийн хүчин зүйлтэй, нөгөө талаасаа цар тахлын аюулыг ташаа үнэлсэнтэй холбоотой гэж үзэж болох юм.

3.1. ХБНГУ

ХБНГУ-д хүн амд харьцуулсан нас баралтын тоо бүс нутгийнхаа өндөр хөгжилтэй бусад орноос эрс бага байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал ХБНГУ-д 100 мянган хүн ам тутамд ногдох Ковид-19 өвчний нас баралтын тоо 34.8 байхад, Испанид 106, Их Британид 104, Францад 92.7, Италид 116.5 байна. Тиймээс ХБНГУ-д халдвар Европын бусад өндөр хөгжилтэй орнуудтай ойролцоо хэмжээнд тархсан ч нас баралтын тоо байгаа тул тус улсын цар тахалтай тэмцэх арга хэмжээг онцлон авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

ХБНГУ-ын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тоймлон авч үзвэл:

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- Халдварын эхний үед буюу 1 сарын 22-нд тус улсын мэргэжлийн байгууллагууд Ковид-19 өвчний “ эрсдэл маш бага” тул хязгаарлах арга хэмжээ авах шаардлагагүй гэсэн дүгнэлт гаргасан нь ташаа байсан нь өдгөө харагдаж байна
- Луфтханза компанийн онгоцонд халдвар илэрсний дараа тус компани БНХАУ руу хийх нислэгээ цуцалсан
- Үүний дараагаас Засгийн газар иргэний агаарын тээврийн нислэгээр ирж буй иргэдээр мэдүүлэг бөглүүлж эхэлсэн
- Үндсэндээ 2 дугаар сарын сүүл үе хүртэл Ковид-19 цар тахлыг аюулгүй гэж тооцож, энэ хугацаанд халуун хэмжих, хөдөлгөөн хязгаарлах шаардлагагүй гэсэн байр суурь баримталж, түүнийгээ Европын холбооны хурал, зөвлөгөөнүүд дээр ч илэрхийлж байсан
- БНХАУ-д хоёр удаа, Иран улсад нэг удаа тусламжаар халдвар хамгааллын бүтээгдэхүүн илгээсэн. Энэ нь цар тахлыг аюул багатай гэж үнэлж, нөөц бүрдүүлэх шаардлагагүй гэж үзэж байсны илрэл юм
- 2 сарын 26-нд Хайнсберг хотод сургууль болон бусад үйлчилгээний байгууллагыг 5 хоногийн хугацаатай хаасан
- Зарим хотод нийтийн арга хэмжээг цуцалж эхэлсэн
- Гэхдээ Төв Засгийн газар хилээ хаах, хязгаарлах шаардлагагүй гэсэн байр сууриа 3 дугаар сарын дунд үе хүртэл баримталсан
- Улмаар харьцангуй хожим буюу 2 сарын 29-нд халдвар идэвхтэй тархсан улс орнуудаас ирэх иргэдийн биеийн байдлыг шалгах шийдвэр гарсан.

- Мэргэжлийн байгууллагууд халдвар хамгааллын бүтээгдэхүүний хомстол үүсч магадгүй талаар хөндөж эхлэхэд экспортыг хориглосон
- Гар ариутгагчийн хомстол үүсэхэд Изопропанолын спиртээр гар ариутгагч үйлдвэрлэхийг зөвшөөрсөн
- Гэхдээ эрүүл иргэдийг амны хаалт зүүх шаардлагагүй гэж үзсэн хэвээр байв. Үүнийг хомстол үүсэхээс сэргийлсэн алхам гэж үзэх үндэс бий
- Засгийн газар иргэдийг шаардлагагүй нөхцөлд аялахгүй байх, эрсдэлт бүсээс ирсэн хүмүүсийг гэртээ байхыг зөвлөж байсан ч хил хаах, сургууль хаахаас татгалзсаар байлаа
- 3 сарын дундуур 1000-аас дээш хүнийг хамарсан бага хэмжээг хориглосон
- Мөн үед 16 мужийн 14 нь сургуулиудыг хааж, Бавари муж онц байдал зарласан
- Мөн үед төв Засгийн газар БНХАУ болон Иранаас ирэх нислэгийг зогсоосон
- Энэ үеэс хойш ХБНГУ-ын Засгийн газар Европын зарим улстай хилээ хааж, ихэнх үйлчилгээний газрыг хаах зэрэг дэлхийн бусад орнуудад харьцангуй түгээмэл авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн
- Иргэдийн хөл, хөдөлгөөнийг хянах ухаалаг утасны аппликейшн нэвтрүүлэх чиглэлд онцгой анхаарч эхэлсэн.
- 4 сарын 15-нд канцлер Ангела Меркел цар тахлын тархацыг амжилттай хязгаарлаж байгаагаа зарласан
- Энэ цагаас хойш муж, мужуудад авч хэрэгжүүлэх хязгаарлалт, арга хэмжээ нь харилцан адилгүй байсан
- Зуны турш зарим бүсэд хязгаарлалтыг эсэргүүцсэн жагсаал явагдсан
- 10 дугаар сараас халдвар эргэн дэгдэж, 11 сарын 2-нд хагас хөл хорио тогтоож одоогоор 2 удаа, 1 сарын 10 хүртэл сунгаад байна
- 12 сарын 13-нд хөл хориог улам чангалсан
- ХБНГУ-ын Засгийн газар цар тахлын үед буруу үнэлгээ хийсэн ч яг энэ алдаа барууны бараг бүх оронд гарсан.
- Харин тус улсыг онцлох гол хүчин зүйл нь дээр дурдсанчлан халдварын тоо өндөр ч нас баралт харьцангуй бага байна. Үүнийг хэд хэдэн хүчин зүйлтэй холбон авч үзэж байна. 1) олон шинжилгээ хийсэн тул халдварыг илт илрүүлж байсан, 2) эрчимт эмчилгээний орны хүрэлцээ Европын орнуудаас өндөр, 3) халдвар илэрсэн хүмүүсийн дунд залуучуудын эзлэх хувь илүү өндөр байсан
- Өмнөх хэсэгт дурдсанчлан улс орны нийтийн эрүүл мэндийн салбарт учирсан хохирлыг нас баралтаар тооцож авч үзвэл ХБНГУ Европын бусад орнуудаас харьцангуй бага хохирол амссан

Эдийн засгийн чиглэлээр:

- Канцлер Ангела Меркел халдварыг амжилттай хязгаарлаж байгаагаа зарласны дараагаас жижиг үйлчилгээний байгууллагуудыг үе шаттайгаар нээсэн
- Хоёр удаагийн төсөв баталсны эхнийх нь 3 дугаар баталсан 156 тэрбум еврогийн төсөв /ДНБ-ий 4.9 хувь/ бол хоёр дахь 6 дугаар сард баталсан 130 тэрбум еврогийн төсөв /ДНБ-ий 4 хувь/
- Ажлын байрыг хадгалахын тулд богино хугацааны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн
- Бага орлоготой өрхийн хүүхдэд олгох тэтгэмжийг нэмэгдүүлсэн
- Хувиараа жил эрхлэгчдэд орлогын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хөнгөлсөн

- Жижиг бизнес эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нийт 50 тэрбум еврогийн дэмжлэг үзүүлж, зарим татварыг алданги тооцохгүйгээр хойшлуулсан
- Старт-ап компаниудыг дэмжихэд 2 тэрбум евро зарцуулсан
- Ажилгүйдлийн даатгалын хугацааг сунгасан
- Хүүхдээ хардаг эцэг, эхэд олгодог тэтгэмжийг нэмсэн
- НӨАТ-ыг бууруулсан
- Зарим өрхөд болон хүнд цохилт амссан жижиг, дунд бизнес эрхлэгчдэд орлогын дэмжлэг үзүүлсэн
- Орон нутгийн засаг захиргаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн
- Эдийн засгийг тогтворжуулах сангаар дамжуулж аж ахуй нэгжид олгох зээлийн батлан даалтыг нэмж байгаа
- Муж, орон нутгийн удирдлагууд мөн тухайн бүсээ хамарсан эдийн засгийн хүндрэлээс сэргийлэх шийдвэр гаргасаар байна.

3.2. ИБУИНВУ

Их Британийн Засгийн газрын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг төв Засгийн газрын авч хэрэгжүүлсэн болон бүрэлдэхүүн улсуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэсэн хоёр үндсэн хэсэгт авч үзэж болно. Энэ хэсэгт төв Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг голлон авч үзлээ.

Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- Халдварын эхэн үед Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яамнаас бусад улс орнууд дахь нөхцөл байдлын талаар мэдээлэл гаргаж, нийтэд хүргэж эхэлсэн
- БНХАУ-ын Хубэй мужаас ирсэн иргэдэд өөрийгөө тусгаарлах зөвлөмж өгч эхэлсэн
- 2 сарын сүүлээр энэ зөвлөмжийн хүрээг тэлж, БНСУ, Иран болон Италийн хойд хэсгээс ирсэн хүмүүсийг хамруулсан
- Цар тахлын үед баримтлах стратегиа зарласан нь 4 үе шатнаас бүрдэж байв. 1) Тогтоон барих. Халдварыг илрүүлж, хавьтлыг тогтоох, орон даяар халдвар тархахаас сэргийлэх, 2) Хойшлуулах. Халдварын тархцыг удаашруулах, хэрвээ чадахгүй бол халдвар оргил үед хүрэх үеийн хохирлыг бууруулах арга хэмжээ авах, 3) Судалгаа хийх. Вирусийн мөн чанарыг ойлгож, учруулж болзошгүй нөлөөг тодорхойлох, 4) Зөөлрүүлэх. Цар тахлын учруулж болзошгүй аюулыг эрсдэлийг бууруулах
- Зарим эрдэмтэд сүргийн дархлаа тогтоох стратеги баримтлахыг уриалж байсан ч Засгийн газар стратеги баримтлахгүй гэдгээ зарласан
- 3 дугаар сараас эхлэн халдварын дэгдэлт идэвхтэй явагдаж эхлэхэд парламентаас тусгайлсан хууль баталж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, хууль сахиулах, хил хамгаалах зэрэг салбарт Засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлсэн.
- Эхний буюу тогтоон барих үе шат 3 сарын 12-нд дууссаныг зарлаж халдварын тархцыг хойшлуулж, цаг хожихыг эрмэлзэхээ зарласан
- Гэвч энэ алхам үр дүнгээ өгөөгүй тул 3 сарын 23-нд анх удаа үндэсний хэмжээнд хөл хорио тогтоосон. Энэ үеэр олон нийтийн газруудыг хааж, иргэдийг онц шаардлагагүй гэрээс гаргахгүй байх шаардлага тавьсан
- Тухайн өдрөөс 20,000 орчим цэргийн алба хаагчийг хөл хорио мөрдүүлэхэд ашиглаж эхэлсэн
- Гэхдээ Их Британийн хөл хориог хожимдсон гэж мэргэжилтнүүд үзэж байгаа. Хэрвээ хөл хориог 1 долоо хоногийн өмнө тогтоосон бол 10,000 хүний амийг аврах байсан гэх судалгаа гарсан.

- 5 сарын эхэн үеэс нөхцөл байдал харьцангуй тогтворжиж, хөл хориог суллах алхмууд эхлэсэн
- Зуны турш хөл хориог суллах үйл явц үргэлжилсэн ч халдварын дараагийн давлагаанаас сэргийлэх бэлэн байдал хангагдаагүй тул удалгүй халдварын тоо эргэн нэмэгдэж эхэлсэн
- Улмаар 10 сарын 31-нд 2 дахь удаа хөл хорио тогтоосон
- 11 сарын 23-наас гурван шатлалт бэлэн байдлын зэргийн системийг нэвтрүүлсэн

Эдийн засгийн чиглэлээр:

- Засгийн газар хөл хориог суллах 60 хуудас бүхий нарийвчилсан төлөвлөгөөг гаргасан
- Энэ үеэс ИБУИНВУ-ын бүрэлдэхүүн дэх Англи, Шотланд, Умард Ирланд, Уэльсд улс өөр өөр үе шаттайгаар эдийн засгийн үйл ажиллагаа сэргэсэн
- Харин эргэн хоёр дахь хөл хориог тогтоож, дараа нь 3 шатлалт бэлэн байдлын зэргийн системийг нэвтрүүлэхдээ барилга, үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааг хэвийн үлдээсэн
- Нийтийн эрүүл мэндийн салбар болон нийтийн үйлчилгээний салбарт 48.5 тэрбум фунт стерлинг нэмж төсөвлөсөн
- Үл хөдлөх хөрөнгийн татварыг царцаах, жижиг аж ахуй нэгжүүд болон онцгой хүндрэл амссан аж ахуй нэгжүүдэд санхүүгийн шууд дэмжлэг үзүүлэх, өвчний чөлөө авсан бол тэтгэмж олгох зэрэгт нийтдээ 29 тэрбум фунтыг зарцуулж, бизнесийн байгууллагуудыг дэмжсэн
- Зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн
- Оны хоёрдугаар улирлаас санхүүгийн жил дуусах хүртэл НӨАТ-ыг хойшлуулсан
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн төлөх орлогын татварыг 6 сараар хойшлуулсан
- Долоо дугаар сард ажлын байрыг хадгалах нэмэгдүүлэх эдийн засгийг сэргээх багц хөтөлбөрийг танилцуулсан
- Ажлын байраа алдах эрсдэл өндөртэй хүмүүсийг ажлын байранд нь үлдээвэл төрөөс татаас өгч эхэлсэн
- Бүсчилсэн хөл хорионы үед үүдээ барьсан аж ахуй нэгжүүдэд 3 долоо хоног тутам 1,500 фунт олгосон
- Журмын дагуу өөрийгөө тусгаарласнаас үүдэн хөдөлмөр эрхэлж чадаагүй, буурай орлоготой иргэдэд 130 фунт, гэр бүлд нь 182 фунтийн тэтгэмж олгосон
- Аялал зэрэг тодорхой салбарт ирэх оны 3 сарыг хүртэл НӨАТ-ыг 15 хувиар буулгаж 5 болгосон

ДҮГНЭЛТ

Зарим улс орны цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрч байна.

Дэлхийн улс орнууд цар тахлын үед баримтлах стратеги, ерөнхий чиглэл нь харилцан адилгүй байна. Тухайлбал Азийн дийлэнх орнууд нэн түрүүнд халдварын тархцыг хумихад ач холбогдол өгч байсан тул хилээ хаах, халдвартай бүсээс ирэх иргэдийг тусгаарлах, халдвар нэг бүрийг мөшгөж илрүүлэх аргыг голлон ашигласан.

Чингэхдээ харьцангуй өндөр хөгжилтэй Япон, БНХАУ, БНСУ зэрэг орнууд технологийн дэвшил дээр суурилан хяналт тавьж байсан бол Вьетнам тэргүүтэй орнууд уламжлалт аргыг ашигласан ч тэр нь өндөр үр дүнд хүрч чадсан.

Харин Европын орнууд анхнаасаа халдвар нэг бүрийг илрүүлэх төдий л ач холбогдол өгөлгүй, харин халдварын тархцыг удаашруулах, хязгаарлахад анхаарч байсан нь харагдаж байна. Энэ нь нэг талаасаа халдварын талаар буруу үнэлгээ, ойлголт түгсэнтэй холбоотой байж болох ч нөгөө талаасаа эдийн засгийн хүчин зүйлтэй шууд уялдаатай юм

Мөн зарим орнууд хатуу Шинэ Зеланд, БНХАУ тэргүүтэй орнууд богино хугацааны хөл хориогоор үр дүнд хүрч, хөл хорионы үеийг үр бүтээлтэй ашиглаж халдварын тархцыг хянах тогтолцоог бэхжүүлж, шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлж чадсан тул дахин халдвар дэгдэхэд маш богино хугацаанд хариу арга хэмжээ авч чадсан.

Өмнөд Солонгос, Япон, Уругвай улсуудын хувьд анхнаасаа үндэсний хэмжээний хатуу хөл хорио тогтоохоос зайлсхийж, дэвшилтэт арга, технологийг ашигласан нь одоог хүртэл үр дүнтэй хэрэгжиж байна.

Харин Филиппин, Их Британи, Италид тогтоосон хөл хорио цаг хугацааны хувьд хожимдсон эсвэл үйл явц нь буруу явагдсан зэргээс шалтгаалан бодит нөлөө, үр дүн боломжит төвшинөөс багатай байлаа.

Тиймээс хөл хориог тогтоох гэдэг нь өөрөө халдварыг хязгаарлах цор ганц эсвэл хамгийн шилдэг арга гэж үзэхэд бэрх юм. Харин хөл хориог зөв цаг үедээ тогтоох, зөв цаг үедээ суллах, хөл хорионы үеийг үр бүтээлтэй ашиглах нь халдварын тархцыг хянахад бодит ач холбогдолтой хүчин зүйл юм.

Үүгээр ч тогтохгүй цар тахалтай холбоотой бусад шийдвэрээс цаг хугацааны хүчин зүйл туйлын чухал болох нь харагдаж байна.

Тухайлбал зарим улсын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зөв ч цаг хугацааны хувьд зохицоогүйгээс шалтгаалж халдвар тархсан байхад Уругвай улс л гэхэд маш шуурхай байж чадсанахаа үр дүнд иргэдийн амьдрал, эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэлгүйгээр халдварыг амжилттай хязгаарласан.

Халдварыг амжилттай хязгаарлаж чадсан улс орнуудын дийлэнх нь шинжилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэх, шинжилгээг эрсдэлгүй нөхцөлд авахад голлон анхаарсан нь ажиглагдсан мөн. Мөн шинжилгээг идэвхтэй авч, халдварыг эрт илрүүлэх нь эндэгдлийг бууруулахад чухал нөлөөтэйг ч ХБНГУ-ын жишээ харуулж байна

Түүнчлэн төрийн удирдлагын талаас авч үзвэл зарим орнуудад, тэр дундаа холбооны улсуудад Төв Засгийн газар болон муж, орон нутгийн хооронд зөрчил үүсэх, улс төржих хандлага гарлаа. Тухайлбал АНУ, Бразилын Ерөнхийлөгч зарим муж, орон нутгийн удирдлагатайгаа шууд зөрчилдөж байсан.

АНУ, Мексикт төв Засгийн газар вакцины асуудлыг нийтэд нь хариуцсан байхад Бразилд мужийн удирдлагууд энэхүү асуудлыг хариуцсан нь Бразилд үүссэн улс төрийн зөрчлийн илрэл юм.

Хэдий тийм ч зарим холбооны улсад Төв Засгийн газар шийдвэр гаргахдаа мужийн удирдлагатай зөвлөлдөж байсан учраас шийдвэр нь ихэнхдээ уялдаж нь дурдаж байсан нь зүйтэй. Ийм хандлага ХБНГУ-д ажиглагдсан.

Харин Вьетнам улсад төв Засгийн газар анх халдвар эрсдэл үүссэн даруйд цар тахлын шийдвэр гарахад голлох үүргийг гүйцэтгэж байсан нь шийдвэр шуурхай гарахад чухал нөлөө үзүүлжээ. Мөн арга хэмжээний хувьд улс орны харилцан адилгүй хугацаанд халдвартай бүсээс ирэх гаднын иргэдийг нэвтрүүлэхгүй байх, өөрийн иргэдээ тусгаарлах журмыг харилцан адилгүй хугацаанд мөрдүүлсэн. Харин тусгаарлахдаа нэг хэсэг нь өөрийгөө тусгаарлах чиглэл өгөөд, хөл хөдөлгөөнийг нь хянаж байсан бол зарим улс тусгайлсан байранд тусгаарлалт зохион байгуулсан гэх мэтээр улс орнуудын сонгосон шийдэл нь харилцан адилгүй.

БНСУ тэргүүтэй өндөр хөгжилтэй орнуудад гамшигаас хамгаалах тогтолцоо сайтар төлөвшсөн тул өмнө нь боловсруулах холбогдох төлөвлөгөөг шууд ашиглах боломжтой байсан, Япон, Шинэ Зеланд зэрэг орнуудад хууль тогтоомжуудад цар тахал, халдварт өвчний тусгайлан тусгасан зэрэг нь эдгээр орнууд цар тахалтай амжилттай тэмцэхэд нөлөөлсөн гэж үзэж болно.

Цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд төр, засгийн шийдвэрээс гадна иргэдийн амьдралын хэвшил, ухамсар чухал нөлөөтэйг ч Азийн болон Европын орнуудын эрс тэс байдал харуулж байна. Тухайлбал Азийн орнуудад өмнө нь САРС болон бусад халдварт өвчин дэгдэж байснаас шалтгаалан иргэд энэ төрлийн гамшигт үзэгдэл харьцангуй бэлэн, асуудал хүлээцтэй хандаж байсан бол Европын зарим оронд эсрэг дүр зураг ажиглагдсан.

Гэхдээ Ковид-19 цар тахлыг амжилттай, хохирол багатай даван туулна гэдэг нь зөвхөн нийтийн эрүүл мэндийн салбарын асуудал биш юм. Харин нийтийн эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүй зэрэг олон салбарт нийтэд нь хохирол багатай байхад чиглэсэн, үндэсний үнэт зүйлсээ хадгалж үлдэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ковид-19 цар тахалтай амжилттай тэмцэж байна гэж дүгнэх нь зүйтэй юм.

Гэхдээ халдварын тархцыг амжилттай хязгаарлаж, дахин давлагаа дэгдэхээс сэргийлнэ гэдэг нь мөн чанартаа бусад салбарт, тэр дундаа эдийн засагт онцгой эерэг нөлөөтэй.

БНХАУ, Шинэ Зеланд зэрэг зарим орны жишээнээс харахад богино хугацаанд халдварын тархцыг хязгаарлаж чадвал эдийн засгийн үйл ажиллагаа хурдан сэргэх нөхцөл бүрдэж байна.

Харин халдварыг хязгаарлаж чадахгүй хугацаа алдвал эдийн засагт ч хохиролтойг Филиппин, Бразил, Мексикийн, дахин давлагаа дэгдэхээс сэргийлж чадахгүй бол дахин хөл хорио тогтоох шаардлага тулгарахыг Европын зарим орны жишээнээс харж болохоор байна.

Улс орнууд цар тахлын эдийн засгийн хүндрэлийг даван туулахдаа харьцангуй нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал нэн түрүүнд дэлхийн улс бараг нийтээрээ бодлогын хүүгээ бууруулж, багц хөтөлбөр зарлах шийдвэр гаргаж байна. Энэ хүрээнд цар тахал хамгийн хүндээр нөлөөлж буй эрсдэлт бүлэг буюу жижиг дунд бизнес эрхлэгчид болон аялал, жуулчлал, иргэний агаарын тээврийн салбарыг төрийн бодлогоор дэмжиж байна.

Түүнчлэн ажлын байр хадгалах асуудалд онцгой анхаарч, ажлын байраа эрсдэл хүлээж хадгалсан аж ахуй нэгжүүдэд татаас олгох, татвараас хөнгөлөх, түрээсийн төлбөрийг хойшлуулах зэрэг алхмыг авч хэрэгжүүлж, ажлын байраа алдсан болон эмзэг давхаргын хүмүүст тэтгэмж олгож байна.

Зарим өндөр хөгжилтэй орнуудын хувьд урт хугацаандаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан эдийн засгийн суурь шинэчлэлээ одооноос хэрэгжүүлэх замаар ажлын байр бий болгох аргыг ч ашиглаж байна.

Үндсэндээ эдийн засгийн чиглэлээр улс орнуудын арга хэмжээ нь эдийн засгийн хүчин чадал, бодлогын чиглэл тодорхой хүчин зүйлсээс хамааран өөр боловч дээр дурдсан жижиг, дунд бизнесийг хамгаалах, ажлын байр хадгалах гэсэн хоёр үндсэн чиглэлийг зорилго болгож байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дэлхийн улс орнуудын цар тахлын үед авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, зарим улсын туршлага, сургамж дээр тулгуурлаж байна.

1. Нийтийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

- БНХАУ-ын Ухань хотод оношлуур хүрэлцээгүй байсан нь халдвар тарах нэг гол хүчин зүйл болсон. Иймд халдвар аль ч бүсэд дэгдэх эрсдэлтэй тул оношлуур бүх бүсэд, хэзээд хүрэлцээтэй байх зайлшгүй шаардлагатай байна.
- Хөл хориог тогтоох, суллахад хамгийн гол хүчин зүйл нь цаг хугацаа болох нь олон хүчин зүйлээс харагдаж буй тул хөл хориог оновчтой цаг хугацаандаа суллах шаардлагатай гэж үзэж байна.
- Хөл хорионы хугацаа иргэдийг идэвхтэй олноор нь шинжилгээнд хамруулах, дараа дараагийн шатны төлөвлөгөө боловсруулах хугацаа болгож үр дүнтэйгээр ашиглаж,
- Төр-иргэн, төр-хувийн хэвшлийн итгэлцэл, хамтын ажиллагаа чухал нь олон жишээнээс харагдаж буй тул хувийн хэвшил, иргэдийг дэмжсэн алхам авч хэрэгжүүлж, тэднийг шаардлагатай бодит мэдээллээр хангах,
- Иргэд асуудалд ухамсартай хандаж, ямар ч нөхцөлд хамтран ажиллах ёстойгоо ойлгох нь төр, засгийн шийдвэрээс дутуугүй нөлөөтэй тул иргэдэд ямар ч үед хамтран ажиллах, мэдээллээ өгөхийг уриалах,
- Бодлогын шийдвэр гаргах тогтолцоо боловсронгуй байж, шийдвэр шуурхай, оновчтой гарах үндсийг бүрдүүлэх,
- Дэлхийн улс орнуудад авч хэрэгжүүлсэнтэй төстэй, дэвшилтэт технологи дээр суурилан иргэдийн хөдөлгөөнийг хянах нөхцөлийг бүрдүүлж, түүнийгээ нийтээр ашиглахыг уриалах,
- Япон улсын туршлагаар хэрвээ халдвар оргил үедээ хүрч тархвал засаг захиргааны нэгж тус бүрт хэдий тооны хүн халдвар авах, тэдгээрээс хэд нь хүнд өвчлөх, хэд нь гэрээр эмчлүүлэх боломжтой байхыг тооцоолж, түүн дээр түшиглэн нөөц бүрдүүлэх, хуваарилах
- Дэлхий дахины жишгээр тусгаарлалтын хугацааг 14 хоног болгох. Дэлхий даяар цар тахлыг амжилттай хязгаарлаж байгаа бүх улсад, тэр дундаа Африкийн ядуу буурай орнуудад ч тусгаарлалтын хугацаа 14 болон түүнээс богино байна.

2. Эдийн засгийн чиглэлээр:

- Жижиг, дунд бизнес болон эмзэг давхаргын иргэд хөл хорионоос шалтгаалж хамгийн хүнд цохилт амсаж буйг харгалзан, зорилтот бүлэг рүү чиглэсэн бодлого хэрэгжүүлэх,
- Дэлхийн улс орнуудад хэрэгжиж буй халамжийн бодлого дийлэнх нь нийт иргэд рүү биш зорилтот бүлэг рүү чиглэж буй энэ бодлогоо зорилтот бүлэг рүү голлон хандуулах
- Эдийн засгийн урт хугацааны хүндрэлээс сэргийлэх тодорхой алхмыг авч хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх
- Аялал, жуулчлал, иргэний агаарын тээвэр цар тахлын үед хүнд цохилт амссан салбаруудыг бодлогоор дэмжих,
- Цар тахлын нөхцөл байдал тогтворжсоны дараагаар Япон, БНХАУ-ын нэгэн адилаар аялал жуулчлалын салбараа дотоодын жуулчлалаар дамжуулан сэргээх бодлого баримтлах нь өндөр үр дүнтэй байх бүрэн боломжтой

- Энэтхэг улсын нэгэн адилаар Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлогоо зарим талаар зөөлрүүлэх боломж бий эсэхийг судлах, дүгнэлт гаргах
- Жижиг, дунд аж ахуй нэгжүүдийг үйл ажиллагаа цахим хэлбэрээр, тасралтгүй явуулах боломжийг хангах, түүнийг нь бодлого, санхүүгээр дэмжих,
- Олон улсын эрсдлийн үнэлгээн дээр тулгуурлан зарим улстай үе шаттайгаар хилээ нээх алхмыг авч хэрэгжүүлэх

3. Бусад чиглэлээр

- Цар тахлын үеийн бүх арга хэмжээг эрх зүйн хүрээнд явуулах, хуулинд заасан бүх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Цар тахал хүний эрх зөрчих, үндэсний үндэсний үнэт зүйлсээ үл ойшоох шалтаг хэрхэвч болох ёсгүй тул бодлого, үйл ажиллагаандаа үүнийг харгалзах,
- Нийгмийн сэтгэл зүйн хэрхэвч орхигдуулж болохгүй бөгөөд зарим улсад нийгмийн сэтгэл зүй онцгой цочирдож буйг харгалзах,
- Нийгмийг сэтгэл зүйн ноцтой хямралаас хамгаалахын тулд иргэдэд үнэн бодит, үндэслэлтэй мэдээлэл өгөх, цар тахлын аюулыг хэт үл ойшоох, хэт дэгстүүлэхгүй байх,
- Тэр дундаа хэт аюулыг хэт дэвэргэх хандлага нийгэмд үүсэх нь халдвар тарсан нөхцөлд иргэд ноцтой хямралд, цочролд орж, болчимгүй үйлдэл хийхэд хүргэх эрсдэлтэй байна,
- Төрийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хоёрдмол утгагүй, өөр хоорондоо зөрчилгүй байх

ХАВСРАЛТЫН ОРОНД

Цар тахлын үеийн сонгууль ба цахим санал хураалтын шийдэл

2020 оны 12 дугаар сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

Ардчилсан сонгууль бүх нийтийн байж сонгуулийн эрх бүхий иргэдэд бүгдэд хүртээмжтэй, эрхээ эдлэхэд нь ямар нэг саад учруулахгүй байх учиртай.


Дэлхий нийтээр ковид-19 цар тахлын үед зохион байгуулагдаж буй сонгуулиудад сонгогчийн бөөгнөрөл үүсгэхгүй байх, сонгогч байгаа газраасаа санал өгөх боломжийг бүрдүүлэхээр зорьж ажиллаж байна. Ардчилал, Сонгуулийн Туслалцааны Олон Улсын Хүрээлэн /International idea Supporting democracy worldwide/ -ээс хийсэн судалгаагаар цар тахлын үед нийт 168 улсын 188 сонгууль зохион байгуулагдах байснаас 95 сонгуулийг хойшлуулсан 89 сонгууль хугацаандаа явагдсан, 4 сонгууль хугацаандаа зохион байгуулагдахаар байна.



Status of Elections and Referendums during COVID-19 Pandemic

[Back To Page 1](#)

Select Month



Click on the chart for more information (Disable slide to zoom)


Month Year	Election Status	Number of Electoral Events
Sep 2020	Held on schedule	7
Oct 2020	Held on schedule	17
Oct 2020	Postponed and rescheduled	3
Oct 2020	Postponed then held	1
Oct 2020	Upcoming on schedule	1
Nov 2020	Held on schedule	12
Nov 2020	Postponed and rescheduled	4
Dec 2020	Held on schedule	3
Dec 2020	Postponed with no new date	3
Grand total		120



120

Countries/territories decided to hold or postpone elections

From 21 February - 31 December 2020



Зураг 1. Цар тахлын үед сонгууль зохион байгуулсан улсууд

Сонгууль зохион байгуулж буй улс орнууд аль болох урьдчилсан санал хураалт зохион байгуулах, шуудангаар санал авах, факсаар санал өгөх, имэйлээр санал өгөх, итгэмжлэгдсэн хүнээр дамжуулан санал өгөх, интернет санал хураалтаар санал өгөх, санал хураалтын өдөр сонгогчдын оргил цагуудыг олон нийтэд мэдээлэлж аль болох ачаалал үүсгэхгүй, сонгогчдыг олноор цуглуулахгүй байх зэргээр санал хураалтын шийдлийг сонгож байгаа билээ.

Цар тахлын үед зохион байгуулагдсан сонгуулийн нэг болох Герман улсын Бавари мужийн орон нутгийн сонгууль 2020 оны 3 дугаар сард 2 үе шаттай зохион байгуулагдсан. 1 дүгээр шатыг 3 дугаар сарын 16-ний өдөр шуудангаар санал өгөх болон санал авах байраар санал өгөх гэсэн сонголттойгоор зохион байгуулсан бол 2 дугаар шатыг 3 дугаар сарын 29-ний өдөр 100% шуудангаар санал өгөх байдлаар зохион байгуулсан.

Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн сонгууль 2020 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан бөгөөд нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор урьдчилсан санал хураалт болоод имэйлээр гэрээсээ санал өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан. Урьдчилсан санал хураалтаар нийт сонгогчдын 26.7% нь санал өгсөн байна.

Хамгийн сүүлд 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгчийн сонгуульд нийт сонгогчдын 41.23% нь урьдчилсан санал хураалтын хугацаанд шуудангаар санал өгсөн нь 2016 оны сонгуультай харьцуулахад 2.3 дахин өссөн байна. Урьдчилсан санал хураалтын хугацаанд санал авах байраар нийт сонгогчдын 22.62% буюу 2016 оноос 1.3 дахин өссөн. Монгол Улс 1992 оноос хойш бүх нийтийн, шууд, чөлөөт, ардчилсан сонгууль зохион байгуулж ирсэн. Бид цар тахлын хугацаанд ээлжит сонгуулиа хугацаанд нь амжилттай зохион байгуулсан улс орны хувьд албан ёсоор орж байгаа билээ. Учир нь 2020 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн Хурлын сонгуулийг амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль дотооддоо ковидын тархалттай байгаа хүнд нөхцөлд зохион байгуулагдана. Мөн манай улсын хувьд гадаадад оршин суугаа 150,000 орчим иргэдээс сонгуулийн насны 80,000 орчим иргэн, уул уурхайн салбарт ажиллаж байгаа 38,000 иргэн, хотод суралцаж байгаа орон нутгийн харьяалалтай 20,000 оюутан санал өгөх боломж хязгаарлагдмал байдаг. Дээрх нөхцөл байдалтай уялдуулан цахим санал хураалт /интернет санал хураалт/-ыг зохион байгуулж, сонгогчид байршил харгалзахгүйгээр санал хураалтад оролцох боломжийг бүрдүүлэх тухай судаллаа.

2019 оны байдлаар Эстони, Шинэ Зеланд, Австрали, Панам, АНУ, Мексик, Швейцар зэрэг орнууд цахим санал хураалтын системийг ашиглан сонгогчдод орон зай хамааралгүй, ямар нэгэн бэрхшээлгүйгээр санал хураалтад оролцох нөхцөл боломжоор хангаж байна.

№	Цахим санал хураалтыг ашиглаж буй хэлбэрүүд	Эстони	Армен	Шинэ Зеланд	Канад	Австрали	Панам	АНУ	Мексик	Швейцар
1	Улс даяар	+								
2	Дипломат албаныхан, түүний гэр бүл	+	+	+		+	+	+	+	+
3	Гадаадад оршин суугаа сонгогчид	+		+		+	+	+	+	+
4	Зарим муж, хотууд	+			+					
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	+			+	+				

Хүснэгт 1. Цахим санал хураалтыг ашиглаж буй улс орнууд

Дээрх улс орнуудаас Эстоний улсын жишээг илүү дэлгэрэнгүйгээр авч үзвэл 2005 оноос Орон нутгийн хурлын сонгууль, 2007 оноос Парламентын сонгууль, 2011 оноос Ерөнхийлөгчийн сонгууль, 2012 оноос блокчейн технологид суурилсан цахим санал хураалтыг зохион байгуулж ирсэн. Эстони улсын хувьд цахим санал хураалтыг зөвхөн урьдчилсан санал хураалтад хэрэглэдэг. Урьдчилсан санал хураалт сонгуулийн санал хураалтын өдрөөс 10 хоногийн өмнө эхэлж 7 хоног үргэлжилнэ. Тус хугацаанд ЦАХИМ САНАЛ ХУРААЛТ болон уламжлалт санал хураалт зэрэг явагдана. Санал хураалтын өдөр хүртэлх 3 хоногийн хугацаанд сонгогчийн нэрийн жагсаалтыг санал хураалтын өдөрт бэлтгэнэ. Харин сонгуулийн өдөр санал хураалт нь зөвхөн уламжлалт аргаар зохион байгуулагддаг. Эстони улсад цахим санал хураалтын ирц тасралтгүй өссөөр 2019 онд 43,8 хувьд хүрсэн.

Манай улсын хувьд цахим санал хураалтыг сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах нөхцөл, боломжийг дараах байдлаар судаллаа.

Нэг. Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-д шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ гэж заасан. Сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн орчинд сонгуулийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах талаар хуульчлан тусгагдаагүй байна. Иймд сонгуулийг цахим систем ашиглан зохион байгуулах тохиолдолд сонгогчийн бүртгэл болон санал авах, тоолох, дүн гаргах зэрэг ажиллагаанд цахим систем ашиглах зарчим, журмыг тодорхойлж, түүнийг ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай. Цахим гарын үсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 хэсэгт "... цахим гарын үсгийг ердийн гарын үсэгтэй адил хэрэглэнэ." гэж зохицуулсан нь тоон гарын үсгийг цахим санал хураалтад ашиглаж болохоор байна.

Хоёр. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц

Цахим санал хураалтыг нэвтрүүлэхэд манай улсын хувьд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дараах дэд бүтэц боломжууд бүрдсэн байна. Үүнд:

- Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2025 болон Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэх зорилго бүхий "Цахим засаглал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлснээр 2019 оны жилийн эцсийн байдлаар төрийн 47 байгууллага, хувийн хэвшлийн 118 байгууллага холбогдож цахим хэлбэрээр мэдээлэл солилцож байгаа

- Иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах “Дан” системд иргэн өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаараар нэг удаагийн нууц үг авч нэвтрэх, тоон гарын үсгээр, банкны эрхээр нэвтрэх боломжтой. 2020 оны 10 дугаар сарын эхний байдлаар нийт 235 мянга гаруй иргэн танилт нэвтрэлтийн Дан системд бүртгэгдсэн
- Цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд үндэсний дата төв УТҮГ-аас цахим шуудангийн системийг нэвтрүүлж, иргэний бүртгэлийн дугаараар иргэн бүрт цахим шуудангийн хаяг үүсгэсэн бөгөөд тус цахим шуудангийн хаягаар дамжуулан төрийн цахим үйлчилгээг онлайнаар хүлээн авах, иргэнтэй холбоотой мэдээлэлд хандсан тухай мэдэгдлийг хүлээн авах боломжтой болсон. Үндэсний цахим шуудан хэрэглэгчийн тоо 2020 оны 10 сарын эхний байдлаар 104500 хүрсэн
- Дээрх суурь системүүд дээр суурилсан Төрийн үйлчилгээний e-Mongolia системийг ашиглалтад оруулж, төрөөс иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн 181 нэр төрлийн төрийн үйлчилгээг, цаг хугацаа байршил харгалзахгүйгээр цахим хэлбэрээр үзүүлж байна. Хилийн чандад байгаа иргэдэд төрийн үйлчилгээг уг системээр дамжуулан хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлэхээр Гадаад харилцааны яамны төлөөллөөр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж эхэлсэн,
- Монгол Улсын 21 аймгийн төв болон 330 сум, суурин нийтдээ 50,792 км шилэн кабелин дамжуулах сүлжээ байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Одоогийн байдлаар 320 сум (нийт сумдын 96,67%) нь шилэн кабелийн сүлжээнд холбогдсон. Интернет хэрэглэгч өрхийн тоо 308,411 буюу нийт өрхийн 34,3 хувьтай
- Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 4,4 саяд хүрсэн байна. Нийт гар утас хэрэглэгчийг хүн амын тоонд харьцуулбал хувь 136,4% давсан үзүүлэлттэй. Хот, хөдөөд харилцаа холбооны хэрэгсэл болох гар утасны хэрэглээ харилцан өндөр үзүүлэлттэй байна. Үүрэн холбооны хөдөлгөөнт сүлжээний 3G интернет хэрэглэгчийн тоо 3.3 саяд хүрч, хамрах хүрээ нь нийт хүн амын 96%-д нэвтэрсэн байна. Улаанбаатар хотын нийт өрхийн 42,8% компьютертэй байна. Цахим банк хэрэглэгчдийн тоо 2.3 сая хүрсэн үзүүлэлттэй,
- Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр 2008-2012 онд хэрэгжсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2011 онд улс даяар Иргэний шинэчилсэн бүртгэл хийгдэж, хурууны хээгээр бүх иргэнээ бүртгэсэн. Иргэний шинэчилсэн баазаас сонгогчдын нэрсийн жагсаалтаа гаргадаг ба 2012 оноос хойш 8 удаагийн сонгуульд сонгогчдын бүртгэлд сонгогчийг хурууны хээгээр таних технологийг ашигласан байна.

Гурав. Сонгогчийн насны бүтэц

Манай улсын сонгогчдын насны бүтцийн хувьд нийт сонгогчдын 55%-ийг 18-40 насныхан эзэлж байгаа нь харьцангуй залуу сонгогчтой улс билээ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үед 3,296,900 иргэнээс 2,000,624 иргэн сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн ба насны бүтцээр нь ангилбал:

- 18-40 насны сонгогч 1,108,146 буюу 55%,
- 41-55 насны сонгогч 517,323 буюу 26%,
- 56-дээш насны сонгогч 375,155 буюу 19% байна.

Дөрөв. Гадаад дахь сонгогчдын саналыг авсан туршлага

Манай улс гадаад дахь сонгогчдын саналыг сонгуулийн пропорционал тогтолцоо болон улс нэг тойрог /Ерөнхийлөгчийн сонгууль/ байх үед авч байсан туршлагатай.

Санал хураалтын үйл ажиллагааг гадаад хэргийн яамны салбар комисс зохион байгуулдаг бөгөөд сонгогч өөрийн биеэр элчин сайдын яам болон консулын газарт очиж саналаа өгдөг.

№	Сонгуулийн нэр	он	Санал өгөхөөр бүртгүүлсэн	Санал өгсөн
1	Улсын Их Хурал	2012	4276	2777
2	Ерөнхийлөгч	2013	6233	4242
3	Ерөнхийлөгч	2017	7374	4816

Хүснэгт 6. Гадаад дахь сонгогчдын санал хураалтад оролцсон байдал

Тав. Сонгогчийг цахим орчинд таньж, баталгаажуулах

Олон улсын жишгээс харахад цахим санал хураалтын сонгогчийн танилт, баталгаажуулалтын хэсэгт тоон гарын үсгийг ашиглаж байна. Монгол Улсын Их хурлаас 2011 онд “Цахим гарын үсгийн тухай” хууль баталж, хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын Их Хурлын 2011 оны 61 дүгээр тогтоолоор “цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2015 оны 71 дүгээр тушаалаар “Монгол Улсад цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл”, Засгийн газрын 2016 оны 151 дүгээр тогтоолоор “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох талаар авах зарим арга хэмжээний тухай” зэрэг баримт бичгүүд батлагдсан.

Монгол улсын хэмжээнд тоон гарын үсэг олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрчилгээжүүлэх хувийн 4 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

2020 оны III улирлын байдлаар

№	Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллага	Олгосон тоо	Гэрчилгээ үүсгэсэн огноо
1	Үндэсний Дата Төв УТҮГ	6020	
2	Ви Эс Эм ХХК	90	2018.05.04
3	Ньюкомпас ХХК	206	2019.05.24
4	Тридум э-секьюрити ХХК	446	2018.05.30
5	Мон Пасс СА	24092	2015.11.13
	Нийт	30854	

Хүснэгт 7. Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчдийн тоо

Манай улсын хувьд иргэний цахим үнэмлэхэд тоон гарын үсгийн гэрчилгээ суулгах бэлтгэл бүрэн хангагдсан.

Дүгнэлт

Монгол улс мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцэд суурилан цахим санал хураалтыг хэсэгчилсэн байдлаар, сонгуулийн автоматжуулсан системтэй хамт зэрэгцээ байдлаар зохион байгуулах бүрэн боломж байна. Эрх зүйн орчныг бэлтгэж Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон Сонгуулийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, цахим систем ашиглах зарчим, журмыг тодорхойлж, түүнийг ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах шаардлагатай. Цахим санал хураалтыг ашиглаж буй гадны орны туршилага болон манай улсын сонгуулийн тогтолцоо, хууль эрх зүйн орчин, туршилага, дэд бүтцийн боломж, нөхцөлийг харгалзан цахим санал хураалтыг урьдчилсан санал хураалтын хугацаанд сонгуулийн автоматжуулсан системтэй хослуулан ашиглах, хилийн чандад байгаа иргэдийн цахим санал хураалтад оролцох боломжийг бүрдүүлж болно.

Цахим санал хураалтын системийг нэвтрүүлэхэд систем, тоног төхөөрөмж, сүлжээний хамгаалалт, сонгогчдын тоон гарын үсгийн гэрчилгээ, түүнийг олгох үйл ажиллагааны гээд анхны суурилуулалтын зардал өндөр гарах ч суурилуулалт хийгдсэнээс хойш зардал бага. Цахим санал хураалтыг манай улсад нэвтрүүлснээр гадаадад амьдарч буй сонгогчид санал өгөхөд илүү хялбар болно, оюутан залуучуудын оролцоо нэмэгдэнэ, ээлжийн ажилтай сонгогчдын оролцоо нэмэгдэнэ, сонгогчдын саналыг худалдан авах байдлыг багасгана, гадаад дахь сонгогчдын санал хураалтыг зохион байгуулах зардал хэмнэгдэнэ, сонгогчдын шилжилт хөдөлгөөнийг зогсоож улмаар өмнөх сонгуулиудад үүссэн олноор шилжих /царцаа/ асуудлыг шийдвэрлэнэ, сонгогч саналаа тоологдсон эсэхийг шалгах боломжтой /Санал тоологдох үед хэн санал өгсөн буюу сонгогчийн мэдээллийг мэдэх боломжгүй/, сонгогчийн итгэл үнэмшил нэмэгдэх зэрэг олон давуу талууд бий болох юм. Ингэснээр тогтмол, хүртээмжтэй байх ардчилсан сонгуулийн зарчмыг хангасан сонгууль зохион байгуулагдах боломжтой.

Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
4. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
5. “Цахим гарын үсгийн тухай” хууль
6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
7. “Цахим засаглал” хөтөлбөр
8. “Эстони улсын цахим санал хураалт” өгүүллэг, “Үндэсний ардчилал хүрээлэн” олон улсын байгууллагын цахим хуудас <https://www.ndi.org>
9. “Сонгуулийн дижитал технологи” судалгааны эмхэтгэл, 2018 он, Европын парламентын судалгааны алба
10. Эстони улсын албан ёсны вэб хуудас, <https://e-estonia.com/solutions/e-governance/i-voting/>
11. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, <https://www.idea.int/data-tools/data/icts-elections>
12. Сонгуулийн системийн олон улсын сан, <https://www.electionguide.org/countries/id/69/>
13. “Цахим санал хураалтад талаар анхаарах зүйлс” судалгааны эмхэтгэл, 2020 он, IFES International Foundation for Electoral Systems
14. “Эстони улсын цахим санал хураалтын зарим тоо баримт”, 2020 он, <https://www.valimised.ee/en/archive/statistics-about-internet-voting-estonia>
15. “Эстони улсын цахим санал хураалтаас Европ юу суралцсан бэ”, 2019 он, <https://blogs.microsoft.com/eupolicy/2019/05/10/electronic-voting-estonia/>
16. “Цахим санал хураалт” эмхэтгэл, 2011 он, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн
17. “Цахим санал хураалтад итгэж болох уу” илтгэл, 2013 он, Норвеги улс
18. “Эстони улсын цахим санал хураалтыг нэвтрүүлэх үйл ажиллагаа”, 2017 он, Эстони улсын Сонгуулийн байгууллага
19. ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он
20. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2019 он
21. Харилцаа холбооны зохицуулах хороо, Мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлт, 2020 оны хагас жил
22. “Хөдөлгөөнт банкны тайлан”, 2020 оны 1 дүгээр улирал, Монгол банк
23. “Тусгаар тогтнол” сэтгүүл №3, 2019 он
24. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар <https://www.cita.gov.mn>
25. Үндэсний дата төв <https://datacenter.gov.mn>
<https://www.esign.gov.mn/faq>
26. Мон Пасс СА <https://www.monpass.mn>
27. Тридум <http://tridum.mn>
28. Ви Эс Эм <https://www.vsm.mn>
29. Нью Компасс <https://www.newcompass.mn>